



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-27
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	28-116
<hr/>	
<i>1. “Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	30-69
<i>2. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	69-116

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 17-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Б.Баярсайхан, Х.Болорчулуун, С.Бямбацогт, С.Ганбаатар, Ж.Мөнхбат, Д.Өнөрболор, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Ц.Анандбазар, Э.Бат-Амгалан;

Хоцорсон: С.Батболд-2 цаг 18 минут, Ц.Мөнх-Оргил-19 минут, С.Одонтуяа-33 минут, Ц.Сэргэлэн-2 цаг 18 минут, Д.Цогтбаатар-30 минут, Н.Энхболд-21 минут, Т.Энхтүвшин-2 цаг 18 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

Нэг. “Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, ахлах шинжээч Г.Болормаа, шинжээч Б.Гоёсайхан, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, мөн яамны Тусгай хамгаалалтын бүс нутгийн удирдлагын газрын дарга Д.Батмөнх, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Б.Уранчимэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Захиргаа, удирдлага хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга Д.Батмагнай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Г.Дамдинням, Д.Тогтохсүрэн, Б.Пүрэвдорж, Г.Ганболд, Ц.Туваан, Ц.Даваасүрэн, Х.Ганхуяг, Ж.Батсуурь нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга А.Энхманлай нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг хариуцсан сайд нь гадаадад томилолттой байгаа тул хойшлуулав. /12:17/

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 18 минут үргэлжилж, 12 цаг 22 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 06 минутад эхлэв.

Хоёр.Төр хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын хуулийн мэргэжилтэн Б.Мөнхтогтох, Ү.Алтаншагай, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Н.Наранбаатар, Э.Батшугар, Т.Энхтүвшин, Х.Ганхуяг, Ж.Батсуурь, Н.Энхболд, Т.Аубакир нарын тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Г.Түвдэндорж нар хариулж, тайлбар хийв.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 14 цаг 57 минутаас хуралдааныг даргалав.

Нэг.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

С.Одонтуяа: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3.4 дэх хэсгийн “хөрөнгийг” гэснийг “хөрөнгийн эрхийг” гэж, 3.7 дахь хэсгийн “холбогдох хууль тогтоомжид” гэснийг “энэ хуульд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.2.1 дэх заалтын “үндэсний аюулгүй байдал”, 3.7 дахь хэсгийн “мэргэжлийн зөвлөхтэй” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.5.Түншлэлийн хүрээнд бусдын эзэмшил газрыг нөхөх олговортой солих буюу эргүүлэн авах асуудлыг Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5.1.14 дэх заалтын “/нийтийн үйлчилгээ/” гэснийг хасаж, 5.1.23 дахь заалтын “нийтийн” гэснийг “төрийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44
69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 5.1.32 дахь заалт нэмэх:

“5.1.32.“Засгийн газрын баталгаа” гэж түншлэлийн төслийг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан Засгийн газрын хүлээсэн үүргийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6.1.1 дэх заалтын “талаарх стратеги, бодлого болон мэдээллийг,” гэснийг “зорилт, арга хэмжээг” гэж өөрчлөн, 6.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19

Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7.1.7 дахь заалтын “зорилгоор” гэсний дараа “хувийн хэвшлийн түншлэгчтэй тохиролцсоны дагуу” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.8 дахь заалт нэмэх:

“7.1.8.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21, 24 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аймаг, нийслэлд түншлэлийн төсөл бие даан хэрэгжүүлэх эрхийг аймаг, нийслэлийн нэг жилд хийх түншлэлийн гэрээний нийт үнийн дүн нь тухайн аймаг, нийслэлийн жилийн төсвийн аравны нэгээс хэтрэхгүй байхаар олгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ж.Сүхбаатар, С.Чинзориг, Ж.Батжаргал, Ц.Цэрэнпунцаг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 30
Бүгд: 44
31.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.4 дэх хэсэг, 7.2.8 дахь заалт тус тус нэмэх:

“7.4.Энэ хуулийн 7.2.8-д заасан журам нь энэ хуульд нийцэж, холбогдох шаардлагыг хангасан байна.”

“7.2.8.энэ хуулийн 7.1.8-д заасан эрх олгохтой холбогдсон журам.”

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8.1.1 дэх заалтын “үнэлгээнд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран үнэлгээ өгч,” гэснийг “үнэлгээг” гэж өөрчилж, 8.1.3 дахь заалтын “шинжилгээг” гэснийг

дараа “хянаж, дүгнэлт гарган” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 21
Бүгд: 44
52.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 8.1.19, 8.1.20 дахь заалт нэмэх:

“8.1.19.энэ хуулийн 7.2.8-д заасан журмыг боловсруулах.

8.1.20.баримт бичгийн үнэ тогтоох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8.3 дахь хэсгийг хасах гэсэн **саналыг** дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9.1.1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9.1.5 дахь заалтын “хэрэгжүүлэх” гэсний дараа “төслийн бүрэн шинжилгээнд үндэслэн төсвийн эрсдэл, төсөвт үзүүлэх нөлөөлөл болон хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл өгөх,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44

56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 22
Бүгд: 44

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44

59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Одонтуяа: Төслийн 9.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43

55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 16 цаг 03 минутаас хуралдааныг даргалав.

Г.Занданшатар: 17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10.1.4 дэх заалтын “хувийн хэвшлээс” гэсний өмнө “аймаг, нийслэл болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 15.1.4 дэх заалт нэмэх:

“15.1.4.барих, түрээслэх, ашиглах, шилжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18.2.1 дэх заалтын “энэ хуулийн 19.4, 19.6-д нийцүүлэн гүйцэтгэсэн” гэснийг “боловсруулсан” гэж өөрчилж, 18.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2.7.төслийн үйл ажиллагаанд шаардлагатай, Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдох тусгай болон энгийн зөвшөөрлийг тодорхойлсон байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэсний дараа “, аймаг, нийслэл” гэж нэмж, 19.3 дахь хэсгийн “хуульд заасан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20

Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.4.Энэ хуулийн 19.1-д заасан төслийн саналыг хүлээн авснаас хойш салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншлэлийн төв хамтран урьдчилсан үнэлгээг 30 хоногийн дотор хийж, дүгнэлтийг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.3.Энэ хуулийн 20.2-т заасан төслийн багийн бүрэлдэхүүнд түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншлэлийн төслөөс хамааран холбогдох төрийн байгууллага, төсөл хэрэгжих аймаг, нийслэлийн төлөөлөл байх бөгөөд төслийн багийн бүрэлдэхүүний 30-аас доошгүй хувь нь санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, нийгэм, байгаль орчин болон холбогдох бусад салбарын үндэсний, олон улсын мэргэжлийн судлаач, зөвлөх, хөндлөнгийн хараат бус зөвлөх гишүүн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.6.Энэ хуулийн 7.2.4, 9.2-т заасан аргачлал болон 20.4-т заасан эрсдэлийн шинжилгээний дүгнэлтийн дагуу түншлэлээр хэрэгжүүлэх төслийн эрсдэлийг үнэлэх, хуваарилах, бууруулах, хянах зэрэг эрсдэлийн удирдлагын арга хэмжээг төлөвлөсөн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21.3, 21.4 дэх хэсгийн “10” гэснийг “15” гэж, 21.6 дахь хэсгийн “Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ” гэснийг “Засгийн газарт хүргүүлнэ” гэж, 21.7 дахь хэсгийн “шийдвэрийг гаргаж, ТХХТ-ийн төслийг батална.” гэснийг “шийдвэрийг гаргана.” гэж, 21.8 дахь хэсгийн “хэрэгжүүлнэ.” гэснийг “зохион байгуулна.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21.2.1 болон 21.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.1.энэ хуулийн 21.2-т заасан хяналтын хуудсанд төрийн түншлэгчид хамаарах дараах мэдээллийг тусгана:

21.2.2.энэ хуулийн 21.2-т заасан хяналтын хуудсанд дараах түншлэлийн мэдээллийг тусгана:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 15

Бүгд: 42

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25.2.6 дахь заалтын “үнэлэх” гэснийг “үнэлэх, шаардлага хангаагүй бол энэ хуулийн 25.2.7-д заасан хугацааны дотор оролцогчид мэдэгдэх;” гэж өөрчлөн, 25.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 25.2.2.д дэд заалт нэмэх:

“25.2.2.д.баримт бичгийн үнэ;”

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “25.6.2.в” дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.2.Ажлын хэсэг энэ хуулийн 25.6.7-д заасны дагуу хамгийн сайн нөхцөлтэй төслийн саналаар шалгарсан оролцогчоос эхлэн хэлэлцээг хийж, үр дүнг нээлттэй мэдээлэх бөгөөд хэлэлцээрийн тэмдэглэлийг энэ хуулийн 52.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд тусгана.”

Дээрх саналыг Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

31.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.1.7 дахь заалт нэмэх:

“27.1.7.сонгон шалгаруулалтад оролцогчид нь Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасны дагуу харилцан хамааралгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29.1 дэх хэсгийн “зээлдэгчийн” гэснийг “санхүүжүүлэгчийн” гэж, 29.2 дахь хэсгийн “Монгол Улсын хууль болон түншлэлийн гэрээнд заасан эрх, үүргийн дагуу оролцоно.” гэснийг “холбогдох хууль, түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 22
Бүгд: 42
47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 23
Бүгд: 43

46.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33.9 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42

52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн гарчгийн “төлбөрийн” гэснийг “төсвөөс санхүүжүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35.2.26 дахь заалтын “байгуулах аливаа” гэснийг “түншлэлийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавхтай холбоотой” гэж, 35.2.35 дахь заалтын “хянах боломжгүй” гэснийг “урьдчилан тооцоолох боломжгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40

57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41.3.1 дэх заалтын “газрыг” гэсний дараа “холбогдох хуульд заасны дагуу” гэж нэмж, 41 дүгээр зүйлийн гарчгийн “газар чөлөөлөлт” гэснийг болон 41.3.1 дэх заалтын “газар чөлөөлөх” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43.6 дахь хэсгийн “дагуу бий болсон хөрөнгийг” гэснийг “зүйлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44.5 дахь хэсгийн “хувийн хэвшлийн түншлэгч” гэсний дараа “энэ хуулийн 44.4-т заасны дагуу” гэж, “үйл ажиллагааны эрх,” гэсний дараа “төсөл хэрэгжүүлэх зорилгоор авсан” гэж, 44.7 дахь хэсгийн “хувийн хэвшлийн түншлэгч түншлэлийн” гэсний дараа “үндсэн болон дагалдах” гэж, “зардлын дагуу” гэсний дараа “түншлэлийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44.1 дэх хэсгийн “санхүүжүүлнэ.” гэснийг “санхүүжүүлж болно.” гэж өөрчилж, 44.7 дахь хэсгийн “хариуцлагыг баталж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45.2 дахь хэсгийн “төлбөрийн хэмжээг” гэсний дараа “харилцан тохиролцож,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46.3 дахь хэсгийн “түншлэлийн гэрээг” гэсний өмнө “төрийн түншлэгчээс” гэж, мөн хэсгийн “шилжүүлж” гэсний өмнө “уг нөхцөл байдал арилах хүртэлх хугацаанд” гэж тус тус нэмж, 46.2 дахь хэсгийн “Тайлбарыг” доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Тайлбар:“Санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрх” гэдэгт санхүүжүүлэгч, эсхүл зээлдүүлэгч нь түншлэлийн гэрээний үүргээ зөрчсөн хувийн хэвшлийн түншлэгчийн эрх, үүргийг энэ хуульд заасан шаардлагыг хангасан өөр этгээдэд төрийн түншлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр шилжүүлэхийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 16
Бүгд: 45
64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46.3 дахь хэсгийн “буруутай үйл ажиллагааг засаж залруулаагүй” гэснийг болон мөн хэсгийн “Тайлбар”-ыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 15
Бүгд: 45
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50.1.3 дахь заалтын “ажлын төлбөр,” гэсний дараа “төслийн баримт бичгийн үнэ,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 52.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 18
Бүгд: 45
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 56.4 дэх хэсгийн “25.6.8” гэсний өмнө “25.2.6,” гэж, мөн хэсгийн “гомдол” гэсний өмнө “багтаан” гэж тус тус нэмж, төслийн 56.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“56.5.Түншлэлийн төслийн сонгон шалгаруулалттай холбоотой маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хүсэлтээр үндэсний болон олон улсын шинжээчийг оролцуулж, дүгнэлт гаргуулж болох бөгөөд холбогдох зардлыг оролцогч хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 17
Бүгд: 45
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 57.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 60.1 дэх хэсгийн хуулийн дагаж мөрдөх хугацааг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.4 дэх хэсгийн “өмчийн тухай” гэсний дараа “хууль” гэж, 5.1.17 дахь заалтын “төсөл хөгжүүлэх сан” гэсний өмнө “түншлэлийн” гэж, 5.1.27 дахь заалтын “Компанийн тухай” гэсний дараа “хууль” гэж, 14.1.3 дахь заалтын “заасны” гэсний дараа “дагуу” гэж, 14.4 дэх хэсгийн “зардлыг” гэсний дараа “дангаар” гэж, 17.1.2 дахь заалтын “төсөлд” гэсний өмнө “түншлэлийн” гэж, 17.1.2.б, 17.1.2.г, 17.1.7 дахь заалтуудын

“төслийн” гэсний өмнө “түншлэлийн” гэж, 20.1 дэх хэсгийн “үр ашиг” гэсний өмнө “төслийн” гэж, 20.2 дахь хэсгийн “дэргэд” гэсний дараа “хамтран” гэж, 20.10 дахь хэсгийн “зарим” гэсний ард “уялдаатай” гэж, 21.2.2.г заалтын “барилга” гэсний дараа “, байгууламж” гэж, 25.2.2.б заалтын “хувийн хэвшлийн” гэсний дараа “түншлэгчийн” гэж, мөн заалтын “дэмжлэгийн” гэсний дараа “тухай” гэж, 35.2.2б дахь заалтын “төрийн” гэсний дараа “түншлэгчийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 16
Бүгд: 45
64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2.1 дэх хэсгийн “ТХХТ эсхүл” гэснийг хасаж, төслийн зүйл, хэсэг, заалтуудад байх “ТХХТ” гэснийг тохиолдол бүрд нь тохируулан “түншлэл” гэж, 5.1.26 дахь заалтын “бичгүүдийг” гэснийг “бичгийг” гэж, 8.1.2 дахь заалтын “хийгдсэн” гэснийг “хийсэн” гэж, 8.1.7 дахь заалтын “орчинг” гэснийг “орчныг” гэж, 9.2 дахь хэсгийн “хүрээнд төсвийн” гэснийг “төсөвт үзүүлэх” гэж, 12.2.3 дахь заалтын “мэргэжлийн зөвлөхүүдтэй хамтран мэргэжлийн түвшинд төслийн багтай” гэснийг “мэргэжлийн зөвлөх, төслийн багтай” гэж, 12.2.5 дахь заалтын “төслүүдийн” гэснийг “төслийн” гэж, 12.2.6 дахь заалтын “эксперт” гэснийг “шинжээч” гэж, 13.1 дэх хэсгийн “чиглэлүүдийг” гэснийг “чиглэлийг” гэж, мөн хэсгийн “тогтооно” гэснийг “батална” гэж, 14.1 дэх хэсгийн “ТХХТ-ийг санхүүжүүлэх” гэснийг “Түншлэлийг санхүүжилтийн” гэж, 14.4 дэх хэсгийн “хураамж дангаар” гэснийг “хураамжаар” гэж, 18.1.2 дахь заалтын “бодлогод тусгагдсан” гэснийг “бодлого” гэж, 18.1.3 дахь заалтын “хэлбэрүүдэд” гэснийг “хэлбэрт” гэж, 18.2.12 дахь заалтын “нөхцөлүүдийг” гэснийг “нөхцөлийг” гэж, 18.2.16 дахь заалтын “удирдахад тавигдах” гэснийг “удирдах зорилгоор” гэж, 19.1, 22.1 дэх хэсгийн “тухайн” гэснийг “салбарын” гэж, 19.5 дахь хэсгийн “байгууллагаас” гэснийг “байгууллага” гэж, 21.2 дахь хэсгийн “хүргүүлсэн байна” гэснийг “хамт хүргүүлнэ” гэж, 21.10, 22.8 дахь хэсгийн “тохиолдолд” гэснийг “бол” гэж, 21.2.2.д заалтын “байгууллагууд” гэснийг “байгууллага” гэж, 22.3 дахь хэсгийн “заасны дагуу” гэснийг “заасан” гэж, 22.4 дэх хэсгийн “үзсэн байна” гэснийг “үзнэ” гэж, 23.1 дэх хэсгийн “хойших 12 сарын ” гэснийг “хойш 12 хүртэлх сарын” гэж, 23.4 дэх хэсгийн “тооцогдохгүй, тухайн төслийн” гэснийг “тооцохгүй бөгөөд” гэж, 24.1 дэх хэсгийн “хэсгийг” гэснийг “хэсэг /цаашид “ажлын хэсэг” гэх/-ийг” гэж, 24.5 дахь хэсгийн “ижил түвшинд” гэснийг “жигд” гэж, 25.2.6 дахь заалтын “хангах” гэснийг “хангаж байгаа” гэж, 25.6.12 дахь заалтын “зааснаар” гэснийг “заасан” гэж, 25.7 дахь хэсгийн “этгээдээс” гэснийг “оролцогчийн” гэж, 26.5 дахь хэсгийн “ТХХТ-ийн” гэснийг “түншлэлийн асуудал эрхэлсэн” гэж, 27 дугаар зүйлийн гарчгийн “шалгаруулалтын” гэснийг “шалгаруулалтад” гэж, 27.1.2 дахь заалтын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэйгөөр” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу энгийн болон тусгай зөвшөөрөлтэйгөөр” гэж, 28.1.5 дахь заалтын “гэрээний зүйлийн” гэснийг “түншлэлийн зүйлийн” гэж, 28.2.6 дахь заалтын

“хугацаанд нь хангах, түүний үнэн зөв, найдвартай байдлыг хангах” гэснийг “хугацаанд нь хангаж, түүний үнэн зөв, найдвартай байдлыг хариуцах” гэж, 30.2 дахь хэсгийн “холбоотой” гэснийг “холбогдсон” гэж, 33.10 дахь хэсгийн “Засгийн газраас” гэснийг “Засгийн газар” гэж, 35.2.22 дахь заалтын “нөхцөлүүд” гэснийг “үндэслэл,” гэж, 35.2.26 дахь заалтын “түүнчлэн хувьцаа эзэмшигчтэйгээ” гэснийг “хувьцаа эзэмшигчтэй” гэж, 35.2.31 дэх заалтын “онцгой тохиолдол” гэснийг “үндэслэл” гэж, 39.3 дахь хэсгийн “байгууллагын дүгнэлтийг” гэснийг “байгууллагаас” гэж, 41.3.6 дахь заалтын “хууль бус, үндэслэлгүйгээр цуцлах, хураан авахыг таслан зогсоох” гэснийг “хууль бусаар хураан авахгүй байх” гэж, 51.8 дахь хэсгийн “сангийн цахим хуудаст” гэснийг “цахим санд” гэж, 52.3 дахь хэсгийн “52.2-т” гэснийг “8.2-т” гэж, 59.3 дахь хэсгийн “хууль зөрчигчид” гэснийг “хууль зөрчсөн этгээдэд” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийг “ТҮНШЛЭЛИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5.1.25 дахь хэсгийн “урьдчилсан” гэсний дараах “үнэлгээ” гэснийг, 12.2.3 дахь заалтын “байгууллага” гэснийг, 12.2.7 дахь заалтын “үр дүнг” гэсний дараах “тухайн” гэснийг, 20.2 дахь хэсгийн “хамтран” гэснийг, 21.5.3 дахь заалтын “хууль” гэснийг, 22.4 дэх хэсгийн “холбогдох” гэснийг, 22.4.3 дахь заалтын “цор ганц,” гэснийг, 23.1 дэх хэсгийн “зориулан” гэснийг, 23.3 дахь хэсгийн “шаардлагатай” гэснийг, 22.2, 24.1, 51.7 дахь хэсгийн “тухайн” гэснийг, 24.7 дахь хэсгийн “байх” гэснийг, 24.2, 25.6.4, 25.6.7, 25.6.9 дэх заалтуудын “сонгон шалгаруулалтын” гэснийг, 25.6.12 дахь заалтын “ТХХТ-ийн” гэснийг, 27.3 дахь хэсгийн “этгээд” гэснийг, 30.1 дэх хэсгийн “хуваарилах,” гэсний дараах “эрсдэлийг” гэснийг, 30.4 дэх хэсгийн “түншлэгчид,” гэсний дараах “эрсдэлийн” гэснийг, 33.1 дэх хэсгийн “хувийн эрх зүйн салбарын гэрээнд хамаарах” гэснийг, 35.2.7 дахь заалтын “аль” гэснийг, 37.2 дахь хэсгийн “тухайн” гэснийг, 42.2, 50.4 дэх хэсгийн “Монгол Улсын” гэснийг, 43.2 дахь хэсгийн “ТХХТ-ийн гэрээний” гэснийг, 48.3 дахь хэсгийн “нэгбүрчлэн” гэснийг, Гуравдугаар бүлгийн гарчгийн “ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 22
Бүгд: 46
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт

болон эшлэлийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 1.Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл. Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 17
Бүгд: 46
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.1.16” гэснийг “16.1.16” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 20
Бүгд: 46
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “15.1.16” гэснийг “17/” гэж, 2 дугаар зүйлийн “15.1.16” гэснийг “1 дэх хэсгийн 17” гэж, “15.1.17” гэснийг “18/” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “33.1.23” гэснийг “33.1.24” гэж, 2 дугаар зүйлийн “33.1.23” гэснийг “33.1.24” гэж, “33.1.24” гэснийг “33.1.25” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 18
Бүгд: 46
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “10.29” гэснийг “10.30” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10.29.2 дахь заалтын “хуульд” гэснийг “хуулийн 28.2-т” гэж өөрчлөн, мөн заалтын “зохих ёсоор” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 17

Бүгд: 46
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14.1-ийн “түншлэлээр” гэсний дараах “хэрэгжүүлэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 18
Бүгд: 46
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“2 дугаар зүйл. Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.12 дахь заалтын дугаарыг “21.1.13” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 18
Бүгд: 46
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “21.1.13” гэснийг “21.1.12” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 17
Бүгд: 46
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 52.6.3-ын “түншлэлийн” гэсний дараах “тухай” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 17

Бүгд: 46
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “энэ хуульд зааснаар хүчингүй болгосон, цуцалсан, өөрчилснөөс бусдаар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 18
Бүгд: 46
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 18
Бүгд: 46
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн “мөн адил энэ хуулийн дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 20
Бүгд: 46

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 20

Бүгд: 46

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Энэ хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө Концессын тухай хуулийн дагуу байгуулсан концессын гэрээнүүдэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран үнэлгээ хийж, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, цуцлах концессын гэрээнүүдийг Засгийн газар холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 17

Бүгд: 46

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн “хүчин төгөлдөр болсноос” гэснийг “батлагдсанаас” гэж, “батлах ба тэдгээрийг батлагдах хүртэлх хугацаанд тухайн харилцааг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журам, аргачлал, холбогдох бусад баримт бичгээр зохицуулна.” гэснийг “батална.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 17

Бүгд: 46

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг “Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9, 6.5.10 дахь заалтын “концессын гэрээ” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ” гэж, мөн зүйлийн 6.2.4, 6.5.8 дахь заалтын “концессын зүйлийн жагсаалт” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалт” гэж, мөн зүйлийн 6.5.10 дахь заалтын “концесс эзэмшигч”

гэснийг “хувийн хэвшлийн түншлэгч гэж, “концессын зүйл” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн зүйл” гэж тус тус өөрчилсүгэй.” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 20
Бүгд: 46
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Концессын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “18” гэснийг “28” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 18
Бүгд: 46
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар” гэснийг хасаж, мөн зүйлийн “төсөл санаачлах,” гэсний дараа “Засгийн газар эрх олгосны дагуу түншлэлийг хэрэгжүүлэх,” гэж нэмэх.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

13.“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц,

орон тоог баталж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг 2023 оны 3 дугаар улиралд багтаан хэрэгжүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 18
Бүгд: 46
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалт болгож, “хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Эдийн засаг, хөгжлийн яам /Ч.Хүрэлбаатар/-нд тус тус үүрэг болгосугай” гэснийг “хэрэгжүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 17
Бүгд: 46
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Холбогдох хуулийн төслүүдийн “санал хүргүүлэх” гэснийг “санал гаргах” гэж тохиолдол бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр саналаа тайлбарлав.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 35
Бүгд: 46
20.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Б.Жавхлан, Ц.Цэрэнпунцаг нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 11 дүгээр сарын 10-ны өдөр төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхыг хүсэн ерөөв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Багахангай, Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн урилгаар Хил хамгаалах байгууллагын ахмад хилчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Ганбаатар, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 162, 242 дугаар цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Б.Жавхлан, Б.Баттөмөр нарын урилгаар Дархан-Уул аймгийн иргэдийн төлөөлөл болон Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Х.Баделхан нарын урилгаар Баян-Өлгий аймгийн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд,

Ж.Батжаргал, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн урилгаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Төв лабораторийн албан хаагчдын төлөөлөл, “Шихихутуг” Их сургуулийн Эрх зүйн 1^б ангийн багш, оюутнууд, Иргэд, олон нийттэй харилцах “11 11” төвийн ажилтнууд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 40 минут үргэлжилж, 76 гишүүнээс 59 гишүүн хүрэлцэн ирж, 77.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ

2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 04 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 6 асуудал байна.

Нэг.Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /хэлэлцэх эсэх/

Хоёр.Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн /хэлэлцэх эсэх/

Гурав.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /хэлэлцэх эсэх/

Дөрөв.Нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /хэлэлцэх эсэх/

Тав.Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /хэлэлцэх эсэх/

Зургаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /анхны хэлэлцүүлэг/ явуулна
Зарчмын зөрүүтэй 83 саналтай.
Хэлэлцэх асуудалдаа орж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүү **Хишгээгийн Нямбаатараас** албан бичиг ирүүлсэн байна. Уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга **Гомбожавын Занданшатар** танаа.

Улсын Их Хурлын гишүүн миний бие 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтэй байх тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгоно уу гэсэн байна. **Хишгээгийн Нямбаатар** гишүүн үг хэлнэ.

Х.Нямбаатар: **Баярлалаа.** Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр би Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу үг авч байна. Би гишүүдийн ширээ бүр дээр Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх, зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, нөхцөл байдлын талаар Үндэсний

зөвлөлийг тэргүүлж байгаа хүний хувьд та бүхэнд танилцуулга тавьсан байгаа. Сая 8 дугаар сард Малайз улсын Куала лампур хотод Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, санхүүжихтэй тэмцэх тогтолцооны тайланг хамгаалсан байна. Ази, Номхон далайн бүсэд. Бид нар ФАТФ-аас өгсөн 40 зөвлөмжийн 3-ийг амжилттай хэрэгжүүлсэн гэдэг маш сайн үнэлгээг авсан. Тэгэхээр би гишүүдийг нэг зүйлд анхаарлаа хандуулаасай гэж бодож байна.

Манай улс 2020 онд саарал жагсаалтаас гарсан. Одоо бид нар өргөтгөсөн хяналтад байгаа. Хэрэв бид нар өргөтгөсөн хяналтаас гарч, ердийн улсын жагсаалтад оръё гэж байгаа бол ирэх оны 1 дүгээр сарын 31-ээс өмнө бид нар зэрэглэл ахиулах хүсэлтээ ФАТФ-т тавих ёстой. Ирэх 2023 оны 1 дүгээр сарын 31-ээс өмнө.

Бид нар хүсэлтээ тавиад төрийн бус байгууллага холбоо сангийнхаа эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгоод үүнийгээ шалгуулаад ФАТФ-аас тавьсан 40 зөвлөмжийг 40-үүлэнд нь биелүүлсэн гэж хамгаалж чадах юм бол бид нар ердийн ангилалд орохоор байгаа гэдгийг эрхэм гишүүдэд танилцуулга болгож тавьсан байгаа. Тийм учраас би Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Төгтохсүрэн дарга нарт хандаж энэ 5 дахь өдрийн хэлэлцэх асуудлын дараалалд Холбоо сангийн хуулийн анхны хэлэлцүүлгийг хийж өгөөч гэдэг хүсэлтийг тавих гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл бид нар сая Ази, Номхон далайн бүсэд 39 зөвлөмжийг хэрэгжүүлсэн. 1 зөвлөмж дутуу байгаа нь ашгийн төлөө бус

хуулийн этгээдийнхээ эрх зүйн зохицуулалт тогтолцоог бий болгосны дараа тухайн улс зэрэглэл ахиулах хүсэлтээ тавих гэж байгаа юм. Цаг хугацааны хувьд бид нар ирэх оны 1 дүгээр сарын 31-ээс өмнө манай үндэсний зөвлөл хуралдаад хүсэлтээ тавих учиртай. Тийм учраас ийм асуудал байгаа учраас та бүхэн энэ удаагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Холбоо сангийнхаа хуулийн анхны хэлэлцүүлгийг хийх асуудлыг хэлэлцэх асуудлын дараалалд оруулж өгөөч ээ, санал хураалгаж өгөөч гэдэг ийм хүсэлтийг тавьж байгаа юм.

Хоёрдугаарт, Өнөөдөр би үг авсан 2 дахь шалтгаан бол Улсын Их Хурлын дэд дарга Одонтуяагаас удаа дараагийн мэдэгдлүүд хийсэн байгаа. Монгол Улс хүний эрхийн хувьд нэлээд зөрчилтэй байна. Нэгдсэн Үндэсний байгууллагын шинжээчид ирээд Монгол Улсад шүүхийн шийдвэргүйгээр хүнийг баривчлах эрхзүйн тогтолцоо үйлчилж байна гэдэг ийм үндэслэлгүй мэдээллийг олон удаа олон удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийсэнд би харамсаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн хяналтаас гадуур, шүүхийн зөвшөөрлөөс гадуур хэн нэг хүнийг цагдан хорих тогтолцоо Монгол улсад огт байхгүй байгаа. Гагцхүү гэмт хэрэг үйлдэж байр үед нь газар дээр нь хойшлуулишгүй ажиллагааны журмаар баривчлах тохиолдол байдаг. Энэ тохиолдолд 24 цагийн дотор шүүхээс зөвшөөрөл авдаг тогтолцоо өнөөдөр үйлчилж байгаа. Тийм учраас ардчилсан намын бүлэг Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяаг албан ёсоор Монгол Улсын

Засгийн газарт энэ асуудлаар асуулга тавьж Чуулганы нэгдсэн хуралдаан дээр мэдээлэл сонсооч ээ гэдэг хүсэлтийг би гаргаж байна. Өөрөөр хэлбэл энэ өөрөө бид нар олон улсад, дэлхий нийтэд хүний эрхийн чиглэлээр Монгол улс урагшаа ахиж, ахиц дэвшил гаргаж байгаа баривчлах тохиолдолд хуучин 72 цагийн баривчилгаа байсныг 48 цаг болгож өөрчилсөн. 24 цагийн дотор хойшлуулиггүй ажиллагааны журмаар баривчилсан тохиолдолд шүүхээс нөхөж зөвшөөрөл авна. Аваагүй тохиолдолд нэн даруй суллах ийм хууль, эрх зүйн орчин манайд үйлчилж байгаа. Тийм учраас олон нийтэд энэ төөрөгдсөн ташаа мэдээлэл байгаа учраас Чуулганы нэгдсэн хуралдаан дээр та бүхэн асуулга тавивал бид нар дэгийн тухай хуульд заасны дагуу нэгдсэн хуралдаан дээр дэлгэрэнгүй мэдээлэл өгье гэдэг 2 зүйлийг хэлэх гэж өнөөдөр Чуулганы нэгдсэн хуралдаанд үг авсан юм.

Тийм учраас эхний асуудал дээр Их Хурлын дарга энэ хэлэлцэх асуудлын дараалал дээр Холбоо, сангийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг анхны хэлэлцүүлгийг хийж өгөөч ээ. Бид нар ирэх оны 1 сарын 31-ээс өмнө өөрсдийнхөө зэрэглэлийг ахиулж ердийн улсын жагсаалтад ирэх онд орох шалгалтаа өгмөөр байна гэдгийг хэлэх гэсэн юм.

Г.Занданиатар: Гишүүд үг хэлж дууслаа. Энэ асуудлаар Засгийн газрын нэгдсэн байр суурийг тодорхой болгоод бичгээр ирсэн өмнөх хүсэлтээ үгүйсгээд тодорхой болсны дараа хэлэлцэхэд болохгүй гэх асуудалгүй. Одоо хэлэлцэх асуудалдаа орно.

Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Газрын харилцааны салбар нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геодези, зураг зүй, суурь судалгаа газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, орон зайн мэдээллийн менежментийн бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, баялаг бүтээх суурь орчныг бүрдүүлдэг онцлог суурь салбар билээ.

Монгол Улсын Их Хурлаас баталсан Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Засгийн газраас ухаалаг иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал шударга, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах, газрын харилцаа барилга хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлэх, хиймэл оюун ухаан блокчэйн болон газарзүйн мэдээллийн системд суурилсан 3 болон 4 хэмжээст газар үл хөдлөх хөрөнгийн бүртгэл үнэлгээ, татвар,

төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, цахим үйл ажиллагаанд газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулан газрын биржийн үйл ажиллагааны тодорхой хувиар газар хөгжүүлэх санг бүрдүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Газрын тухай хууль нь анх 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр нийт 7 бүлэг 64 зүйлтэйгээр Улсын Их Хурлаар хэлэлцэгдэн батлагдсан бөгөөд үүнээс хойших хугацаанд бусад хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор нийтдээ 32 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Энэхүү хуулийн давхардал хийдэл зөрчлийн талаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгааны тайланд тус хуульд 7 давхардал, 29 зөрчил, 25 хийдэл байна гэж дүгнэсэн.

Өнөөдрийн байдлаар нийт 60 гаруй хууль, 200 орчим захиргааны хэм хэмжээний актад газрын талаарх зохицуулалтыг нэмэлтээр бий болгосон зэрэгцэн үйлчилж хууль тогтоомжийн давхардал хийдэл зөрчлийг бий болгож хэрэглэгч болох төр, орон нутгийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд ойлгомжгүй эрх зүйн үр дагаврыг үүсгэж байгаа тул газрын тухай хууль тогтоомжийн нэгдмэл системчлэлийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болсон.

Нөгөө талаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцад шинэ тутам үүсэж байгаа газартай холбоотой олон талт харилцаа 2002 онд батлагдсан газрын тухай хуулиар зохицуулахад хүндрэлтэй болж, тус

хуулийг боловсронгуй болгох, өөрчлөх замаар шийдвэрлэвэл зохих олон асуудал үүсгээд байна.

Монгол улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол улсад газар түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд төрийн хамгаалалтад байна.

2 дах хэсэгт Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн гэж зааснаар газрын харилцаанд Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалтай холбоотой суурь асуудал гэдэг утгаараа газрын талаар нэгдмэл, тогтвортой бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналттай байх зохицуулалтыг багтаасан Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 11 бүлэг 110 зүйлтэй боловсрууллаа.

Хуулийн төсөлд үзэл баримтлалын чанартай дараах асуудлуудыг тусгалаа. Үүнд:

1. Газрын харилцаанд Монгол улсын газар нутаг салиггүй бүрэн бүтэн, газрын сан нэгдмэл байх, газар нь төрийн хамгаалалтад байх, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд хариллах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх, газрыг хуульд заасан нөхцөл журмын дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм хорыг арилгуулах, газрын талаарх мэдээлэл ил тод нээлттэй байх зэрэг үндсэн зарчмуудыг бүх түвшинд баримталж ажиллахаар Газрын ерөнхий хуулийн төсөлд тусган баталгаажууллаа.

2.Одоогийн эрхзүйн зохицуулалтаар тодорхойлогдсон газар өмчлөх, эзэмших, ашиглах гэсэн 3 эрхийн төрлийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хуулийн суурь үзэл баримтлал болон олон улсад нийтлэг хэрэглэгдэж буй эд хөрөнгийн эрхийн зохицуулалттай нийцүүлэн өөрчлөн томъёолж, шинэчилсэн хуулийн төсөлд газрын Монгол Улсын иргэнд өмчлүүлэх, хүн, хуулийн этгээдэд газрын хязгаарлагдмал эрхээ шилжүүлэх, гэрээгээр ашиглуулах харилцааг зохицуулахаар тусгалаа.

Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар нь төрийн нийтийн өмч, цаашид /төрийн өмчийн газар/ гэх байх бөгөөд төрийн өмчийн газрыг бусдад шилжүүлэх, ашиглуулах, төрөл зориулалт хэмжээ хугацаа, хязгаарлалт нөхцөл шаардлагыг тусгайлан зааж өгсөн.

3.Газар зохион байгуулалтын үйл ажиллагааг цогц байдлаар тодорхойлж төлөвлөлтийн дэс дараалсан үйл ажиллагааг тодорхой болгож, газрын мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх, эрхлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах эрхзүйн үндэслэлийг бүрдүүлж өглөө.

4.Газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авах зориулалт, тэдгээрт тавигдах шалгуур үзүүлэлт, түүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх асуудлыг тодорхой болгож хуульчлахын зэрэгцээ Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад газрын харилцааны талаарх эрх үүргийг зааглан ялгаж, нарийвчлан тодорхойлсон.

5.Хуулийн төсөлд газрын хязгаарлагдмал эрх олгох болон газрыг гэрээгээр ашиглуулахдаа иргэний хүсэлтээр, дуудлага худалдааны анхны үнээр, төсөл сонгон шалгаруулалтаар, дуудлага худалдааны аргыг хэрэглэхээр заасан бөгөөд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг газрын биржээр дамжуулан зохион байгуулна. Цахим үйл ажиллагаатай газрын биржийг улсын хэмжээнд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага удирдан зохион байгуулах бөгөөд аймаг, нийслэлийн түвшинд салбар нэгжүүд эрхлэн явуулна. Уг биржийн үйл ажиллагааны дүрмийг Засгийн газар баталдаг байх зохицуулалтыг шинээр тусгав.

6.Хот, тосгон, бусад суурины газрын нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалтын зохицуулалт тодорхойгүйгээс үүдэн нийтийн эдэлбэрийн газрыг зөвшөөрөлгүй дур мэдэн эзэмших, ашиглах зөрчил даамжирч, улмаар эзэнгүйдэх асуудал гарч байгаа тул нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалтын талаарх зүйл, заалтыг илүү нарийвчлан тусгаж, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалтыг нэмж тусгасан.

7.Улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарт мониторинг хийж үнэлэлт дүгнэлт өгөх замаар доройтсон газрыг сайжруулах дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд өгч хэрэгжүүлдэг байх тогтолцоог хуульчилсан.

8.Хүн, хуулийн этгээдээс газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрх, дундын мэдлийн газрын эрх, газрыг гэрээгээр ашиглуулах, газар чөлөөлөхтэй холбоотой гаргасан гомдлыг цаг хугацаа алдалгүй хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус бүтцийг холбогдох байгууллагын төлөөлөлтэйгөөр аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд байгуулан ажиллуулахаар тусгаад байна.

9.Хуулиар хориглосон, хязгаарласан заалтыг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээний тухай зүйл, заалт нэмж, газрын чанарыг доройтуулах, хохирол учруулах, нөхөн сэргээхгүй байгаа зэрэг зөрчилд хяналт шалгалт хийх эрхтэй этгээд, түүний бүрэн эрхийг тодорхой болгож, улмаар хөндлөнгийн мониторинг хийх боломжийг тусган, хяналт шалгалт болон мониторингийн үр дүнд хэрэглэх албадлага, хариуцлагыг тодорхойлон, үр дүнтэй байхаар зохицуулах тухай зүйл, заалтыг илүү нарийвчлан тусгаж, шаардлагатай тохиолдолд Эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалттай болгосон болно.

Энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны Батсүхийн Саранчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцад газартай холбоотой олон талт харилцааг хуучин хуулиар зохицуулахад хүндрэлтэй болж, тус хуулийг шинэчлэх, боловсронгуй болгох цаг үе, нийгэм, эдийн засгийн шаардлага тулгараад байна. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, газрыг өмчлөлийн хэлбэр, зориулалтаас шалтгаалан бусад төрлийн нийтийн эд зүйлсээс ялгаатай авч үзэх, газар зохион байгуулалтын үйл ажиллагааг цогц байдлаар төлөвлөх, газар эзэмших эрхийг эд хөрөнгийн эрхийн зохицуулалттай нийцүүлэх, газрыг улсын болон тусгай хэрэгцээнд авах зориулалт, тавигдах шалгуур, нийгмийн зайлшгүй хэрэгцээнд газрыг чөлөөлөх, нөхөн сэргээх, газрыг дүйцүүлэн хамгаалах, иргэнд газар өмчлүүлэх, нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт хамгаалалтыг сайжруулах, улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарт мониторинг хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, төрийн хяналт, маргаан шийдвэрлэх зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар газарт тулгуурласан эдийн засгийн суурь харилцааг зохицуулж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл бүрдэж, газрын асуудал төлөвлөлтөөсөө эхлээд газар олголт, бүртгэл, ашиглалт, үнэ, татвар, төлбөр, хяналт, хамгаалалт хүртэлх бүх үе шат нээлттэй, ил тод болно гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг dparliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал бэлчээрийн асуудлыг тодорхой тусгах, эдийн засгийн эргэлтэд оруулах, орон нутагт тулгардаг бодит бэрхшээлийг шийдвэрлэх, атарисан газрыг эргэлтэд оруулах, сумын төвийн газрын төлөвлөлтийг нарийвчлан тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар газрын асуудал эрхэлсэн даргыг томилж, чөлөөлөхөд тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга нартай зөвшилцөхөөр тусгаж байгаа нь оновчтой эсэх, цэргийн анги байгууллагуудыг газрын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг нэмж тусгах, төвлөрлийг сааруулахад хуулийн төсөлд тодорхой заалт туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг өргөн бүрэлдэхүүнтэй байгуулж, нухацтай хэлэлцэх, газрын нэгдмэл сангийн ангилал хоорондын өөрчлөлтийг төлөвлөлтийн түвшинд тодорхой болгох, тусгай хэрэгцээний газрыг олгоход салбарын яамд хоорондын уялдаа холбоог хангах, бэлчээрийн газрын ашиглалтын асуудлыг зүй зохистой шийдвэрлэх, хот суурины тэлэлт, хөгжилтөд шаардлагатай байгаа газрыг тусгай

хэрэгцээнд авах, засаг захиргааны нэгжийн оролцоог хангах, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүх эрх мэдлийг төвлөрүүлсэн байгаа нь оновчтой эсэх, хилийн зурвас газрыг байгуулаад дундын ашиглалтын хувилбар болгож байгаа нь хуульд нийцэж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан бэлчээрийн тодорхойлолт, суурь зохицуулалтыг тусгасан эсэх, Улаанбаатар хотыг тойрсон сумдын хилийн цэсийн маргаантай асуудлын талаар, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталсны дараагаас тулгарах асуудлыг хэрхэн зохицуулах, атар газар болон тусгай хамгаалалттай газар нутгийн зохицуулалтыг тодорхой тусгасан эсэх, хилийн зурвас газрын асуудлыг дахин нягтлах, Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг газрын асуудал нь бүх нийтэд хамааралтай учир зохих түвшинд хэлэлцүүлэг хангалттай зохион байгуулагдсан эсэх, өмнө яригдаж байсан Бэлчээр ашиглалтын хуулийн зохицуулалт энэ хуульд тодорхой туссан эсэх, отрын бүс нутгийн асуудлыг гэрээгээр зохицуулахаар тусгаж байгаа нь зохимжтой эсэх, аж ахуйн нэгжид газрыг давуу эрхээр олгохоор заасан нь хуульд нийцэж байгаа эсэх, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн төслийг яаралтай өргөн мэдүүлж, хамтад нь хэлэлцүүлэх, соёлын өвийн үйл ажиллагаа явуулж байгаа татвар төлөгчийг газрын төлбөрөөс чөлөөлж байгааг дэмжиж, талбайн хүртээмж хангалттай байгаа эсэх, бэлчээр, отрын бүс нутгийн асуудлыг оновчтой тусгах, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен улсын тусгай

хамгаалалттай газар нутгийн захиргааны байршлыг оновчтой болгох, кадастрын зураглалд нэр буруу оруулсан зөрчлийг засах, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд газрын маргаан болон хилийн цэсийн асуудал шүүх дээр хэлэлцэгдэж байгаа нийт маргааны 23 хувийг эзэлдэг учир хуулийн төслийг нухацтай, олон нийтийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэх, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх мэдлийг өргөжүүлсэн байгаа нь хуульд нийцэж байгаа эсэх, газрын дуудлага худалдаагаар олсон орлогыг зүй зохистой зарцуулах, газар зохион байгуулалтын цаглаврыг төсөв батлагдахаас өмнө боловсруулах зэрэг асуудлаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат бэлчээрийн хомсдол, өвөлжсөө, хаваржсаа, отрын асуудлыг хуулийн төсөлд тодорхой тусгах, аймаг, сумын хилийн цэсийн асуудлыг хөндөхгүй байх, хилийн зурвасын асуудлыг тусгаснаар зөрчил үүсэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен хуулийн төслийг дэмжээд Газрын ерөнхий хуулийн үйлчлэх хүрээнд тусгасан хүн, хуулийн этгээдийн тодорхойлолтыг нягтлах, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн нийцлийг хангах, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр газрын асуудал нь аюулгүй байдал, тусгаар тогтнолын асуудал бөгөөд бүх хүмүүст, бүх салбарт хамааралтай суурь хууль учир Улсын Их Хурал дээр нухацтай хэлэлцэх, газрын асуудлаарх суурь судалгааг сайн хийсэн энэ хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Газрын багц хууль болон Иргэний

хуулийн нийцлийг хангах, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал газрын реформ хийх зорилго хангагдаагүй, шинэчлэлийн асуудлууд бүрэн тусгагдаагүй, газрын асуудлыг цогцоор нь шийдээгүй байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нэр томъёог цэгцлэх, гадаад үг хэллэгээс зайлсхийх, тусгай хамгаалалттай газар нутагт газар олголттой холбоотой маргааныг шийдвэрлэх, тусгай хэрэгцээний газрын зохицуулалтыг хөнгөвчлөн, иргэд хохирдог явдлыг зогсоох, орон нутгийн иргэд, засаг захиргааны нэгжийн оролцоог хангах, олон талаас ярьж хэлэлцүүлэг хийх шаардлагатай байгаа талаар тус тус санал хэлсэн болно.

Газрын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Газрын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Барилгын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамигаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний

орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Саранчимэг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Барилга, хот байгуулалтын дэд сайд Энхтүвшингийн Золбоо, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагийн Магнайсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Байгаль, орчин аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Эрхэмбаярын

Баттулга, Байгаль, орчин аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалтын бүс нутгийн удирдлагын газрын дарга Даидэмбэрэлийн Батмөнх, Сангийн яамны Татварын бодлогын гарын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цогтын Баярбат, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга Анандын Энхманлай, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Захиргаа, удирдлага хамтын ажиллагааны газрын дарга Раднаабазарын Ганхуяг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Цэвэлмаагийн Ихбаяр, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Кадастрын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Баянтүмэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Барилга хот, байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Батдэлгэрийн Нямдорж, Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга Доржийн Батмагнай, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба Ганболдын Батзориг. Ганболдын Батзориг хаана байна. Ажлын хэсгийн нөхрийг дуудаарай. Барилга хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээж Гомбодоржийн Болормаа, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Базарпүрэвийн Гоёсайхан, Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн Дэндэвийн Энхтуяа,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Найдангийн Бямбадорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Базаррагчаагийн Уранчимэг.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнээр тасаллаа. Хонх чинь санал хураалт дээр дугардаг. Энэ санал хураалт биш. Үргэлжлүүлээд нэрээ өгөөд, дараад оруулаач. Эхэлнэ гэж байхгүй. Хүмүүсийн нэр орсон. Дараад нэрээ оруулцгаа. Хүчингүй болгох юм байхгүй. Нэрээ дараа оруулцгаа. Нэрийг нь ав. Нэрээ дахиж бич, саяны хүмүүсийг эхэнд нь бичээрэй. Ирцээ уншуул. Өмнө орсон байсан хүмүүсийн нэрийг өмнө нь оруулчих. Хаагаагүй байна шүү дээ. Нэрээ оруул. Та картаа уншуулаагүй юм чинь яаж дарагдах юм. Ганибал гишүүн ирцэд ороогүй байсан байна. Түрүүчийн нэрийг яагаад хүчингүй болгож байгаа юм. Эхнээсээ оруул. Ингээд нэр тасаллаа. Түрүүчийн нэр хадгалагдсан байгаа. Эхэнд нь орно. Ингээд хэл амгүй. Нэр тасаллаа.

Ганбат гишүүн 9.55-д ирсэн, Түрүүчийнх дээр таны нэр байсан уу. Тэр сэргэнэ. Тэгвэл байхгүй байсан байна. Худлаа ярьж болохгүй. Шударга байх хэрэгтэй. Эхний хүмүүсийн нэрээ эхэнд нь оруулчих. Түрүүчийн нэр байсан дарааллаар. Даваасүрэн гишүүнийх түрүүн байсан. Орно. Баттөмөр гишүүн, Батлут гишүүн, Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн, Ганибал гишүүн, Тогмидын Доржханд гишүүн, Даидэмбэрэлийн Бат-Эрдэнэ гишүүн,

Дашдондогийн Ганбат гишүүдийг нэмж оруулаад тэгээд хаалаа.

Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя. Дараа нь нэрсийг дарааллаар нь сэргээгээрэй.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Газрын ерөнхий хууль орж ирж байна. Энэ хууль батлагдсанаар сум хоорондын хилийн цэсийн маргаантай асуудал, аймаг хоорондын сум, дүүргийн хоорондын хилийн цэсийн маргаантай асуудал шийдэгдэх үү. Сая 2 хоногийн өмнө нутгийн удирдлага 30 гээд эрдэм шинжилгээний хурал Төрийн ордонд болсон. Энэ хурал дээр үг хэлсэн орон нутгийн Иргэдийн Хурлын төлөөлөгч нараас асар олон хүмүүс газрын хилийн цэсийн маргаантай асуудлаар санал хүсэлт тавьж байна лээ. Тэгээд энэ хууль батлагдсанаар энэ хилийн цэсийн маргаантай асуудлууд хэрхэн яаж шийдэгдэх юм бэ. Энийг тодруулж өгөөч.

Хоёрдугаарт, энэ Богд уул тойрсон улсын тусгай хэрэгцээний газарт худлаа, үнэн хэлж байгаад янз бүрийн байдлаар газар аваад орон сууц барьчихсан, тэнд нь иргэд захиалга өгөөд бөөн зээл аваад барьчихсан. Одоо болтол орон сууцынх нь ордер гараагүй, тэгээд банкны хүүд олон жил дарамтлуулаад явж байдаг ийм олон иргэд хохироод байж байна. Энэ хууль батлагдсанаар энэ олон иргэдийн энэ асуудлыг хэрхэн яаж шийдэх юм бэ? Энэ замбараагүй баригдсан орон сууцуудын асуудал хэрхэн яаж шийдэгдэх юм бэ?

Төлөвлөлтийн асуудал байгаа юм. Аймаг болгон дүүрэг болгон газрын, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй байдаг. Тэгээд энэ бол хоосон цаас болчихоод байгаа юм л

даа. Аймаг нь сумтайгаа уялдаагүй, нийслэл нь дүүрэгтэйгээ уялдаагүй ингээд жилийн эцэст газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг хэлэлцэх болохоор нөгөө ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын төлгүйгээр зөрчөөд явчихдаг. Хэрвээ энэ ерөнхий төлөвлөгөө хот байгуулалтын төлөвлөгөөнүүдийг зөрчсөн тохиолдолд газар олголтыг хийсэн тохиолдолд буруутай эзэн нь хэн юм бэ? Тухайн орон нутгийн шатны иргэдийн хурал юм уу, тухайн газрын олголт хийсэн Засаг дарга юм уу? ийм хариуцлагагүй үйл ажиллагаа гаргасан тохиолдолд ямар хариуцлага хүлээхээр энэ хуулийн зүйл заалтад орж ирж байгаа вэ?

Төлбөрийн асуудал. Энэ төрийн байгууллагууд, сургууль, цэцэрлэг энэ бол газрын төлбөрөөс чөлөөлөгддөг. Энэ төрийн өмчийн компаниуд өөрсдийн тусгай хэрэгцээнд төмөр зам гэхэд хамгаалалтын зурвастай, эрчим хүч гэхэд хамгаалалтын зурвастай, дулаан, шугам сүлжээ бүгд хамгаалалтын зурвастай. Гэтэл тухайн байгууллагуудын төсөв дээр газартай холбоотой ямар ч төлбөрийн төсвийн эх үүсвэр байдаггүй л дээ. Тэгээд мэргэжлийн байгууллагуудын зүгээс бол газрынхаа кадастрыг хийлгэ, төлбөрөө төл гээд байдаг. Энэ нь он жил хуримтлагдаад хэдэн тэрбум төгрөгөөр яригдах төлбөр хоосон цаас болоод хувираад байдаг. Газрын албанаас бол нэхээд байдаг, тухайн байгууллагууд бол төсөв байхгүй гээд өгдөггүй. Тэгээд төрийн байгууллагуудын хооронд Төрийн өмчит компаниудын газрын байгууллагуудын хооронд ийм төлбөрийн холбоотой маргаантай асуудлууд байгаад байдаг. Энийг энэ хуулиар хэрхэн яаж зохицуулж байгаа

вэ? гэдэг ийм 4 асуултыг асууя.
Баярлалаа.

Г.Занданшатар: 81. Золбоо дэд сайд хариулъя.

Э.Золбоо: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Барилга хот байгуулалтын яам, Дэд сайд Золбоо. Тусгай хамгаалалттай газар нутаг дээр барилга байгууламжууд хууль зөрчиж баригдаад байна. Энэ асуудлыг энэ хуулиар яаж, хэрхэн шийдвэрлэж байгаа гэдэг асуулт асууж байна. Энэ дээр хариулъя. Өнөөдөр Монгол Улсын газар нутгийн нийт 20 орчим хувь нь Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа. Тэр нь бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариуцаад явж байгаа гэсэн үг. Энэ тусгай хамгаалалттай газар нутгийн дээр үйлчилж байгаа үйлчилгээ нь бол Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа гэсэн үг. Энэ тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хууль бол удахгүй Засгийн газраар орно. Улсын Их Хуралд өргөн баригдана. Энэ тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн үзэл баримтлалыг бол Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан байгаа. Энэ шинэ хууль, шинэ хуулийн төсөл дээр эдгээр асуудлууд яаж зохицуулагдах вэ гэвэл цаашидаа энэ нэгдсэн байдлаар жилийн газар олголтын төлөвлөлтийг батална гэсэн үг. Энэ бол бүх газар олголттой холбоотой, аймаг, нийслэл, сум, мөн яамнууд, энэ Байгаль орчин, аялал жуулчлалын яам, чөлөөт бүсийн газар гээд энэ бүх газар олголтын нэгдсэн төлөвлөлтийг газрын асуудал

хариуцсан төр захиргааны байгууллага зохион байгуулаад Засгийн газраар 12 дугаар сарын 1-ээр баталгаажуулаад энэ төлөвлөлтийн дагуу дараа жил нь бүх газар олголтууд явагдана гэж ойлгож болно. Энэ асуудлыг бол цаашидаа төлөвлөлтийн журмын дагуу шийдэх боломжтой.

Өнгөрсөн хугацаанд гарсан алдаа дутагдал, тулгамдсан асуудлуудыг бол удахгүй оруулж ирэх Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулахаар байгаа.

Хоёрдугаар асуулт юу вэ гэхээр, газар олголт төлөвлөлтийн дагуу явагдахгүй байна. Алдаа дутагдлууд гараад байна, Энгийг яаж шинэ ерөнхий хуулиар зохицуулж байгаа вэ гэдэг асуулт асууж байна. Энгийг хариулахад бол түрүүний ярьдаг төлөвлөлтүүд нэгдсэн байдлаар улсын жилийн газар олголтын төлөвлөлтүүд нэгдсэн байдлаар зохион байгуулагдаад, энэ төлөвлөлтийн дагуу ирэх жил нь газар олголтууд цахим биржээр явагдана гэсэн үг. Ерөнхийдөө бол бараг гол гол салбарын уялдаа холбоо хангагддаггүй гол гол газар олголтууд бол энэ төлөвлөлтөд багтана гэсэн үг. Жишээлэх юм бол улсын төсвийн хөрөнгө оруулалт, концесс, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүд, ашигт малтмал, газрын тосны байришил, улсын тусгай хамгаалалттай газар нутаг, нийгмийн зайлигүй хэрэгцээ өмчлүүлэх газрын байришил, улсын тусгай хэрэгцээ төсөл сонгон шалгаруулах гэх мэт бүх газар олголтын төлөвлөлтүүдийг бол нэгдсэн байдлаар төлөвлөд, цаашидаа газар олголтыг цахим биржээр зохион байгуулна гэж тусгасан байгаа.

Бусад асуудлыг ажлын хэсэг хариулна.

Г.Занданишатар: 85. Ажлын хэсэг хариулъя.

А.Энхманлай: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хилийн цэсийн маргаантай асуудал бол ер нь сүүлийн үед бас нэлээд гарч байгаа. Энэ асуудлыг гол шийдэх шийдэл нь юу вэ гэхээр, газар зүйн нэрийн асуудал байгаа. Улсын Их Хураар 2002 онд нийт газар нутгийн газар зүйн нэрийг баталсан байдаг. Ингээд 4 жил тутам тодотгож явах ёстой байсан бол тэр ажил өнөөг хүртэл хийгдээгүй. Хилийн цэстэй холбоотой маргаан мөн газар зүйн нэрийг дураараа өөрчилж байгаатай холбоотой, бид бүхэн орон нутгуудад газар зүйн нэрийг тодруулах, шинэчлэх ийм ажлыг зохион байгуулж ажиллаж байгаа юм. Энэ асуудал дуусахаар Улсын Их Хурлаар бол газар зүйн нэрийг дахин шинэчилж тогтоох ийм асуудал шийдэгдэнэ. Ингээд газар зүйн нэрийг зөв ойлгосноор хилийн цэсийн маргаантай асуудлаа шийдэх бололцоотой. 1977 онд Ардын Их Хурлын тогтоолоор ихэнх сумдын бол хилийн цэс тогтоогдсон, одоо бол харин энэ хилийн цэсийн буруу ойлголт, өөрөөр хэлбэл газар зүйн байршлуудаа, нэршлээ буруу тогтоож ойлгосноос болж бол энэ газар зүйн нэртэй холбоотой маргаан гарч ирж ийм байдлууд үүсэж байгаа. Тэгээд энийг бол шийдэхэд бол энэ газар зүйн нэрийг бол тодорхой тогтоож, түүнийг мөрдүүлснээр бол асуудал шийдэгдэнэ.

Хилийн цэцтэй маргаантай асуудал, ер нь газартай холбоотой

маргаантай асуудлыг Газрын тухай хуулиар, Газрын маргаан таслах зөвлөлөөр бол бид бүхэн хэлэлцэж шийдэхээр зохицуулсан байгаа. Тэгээд энэ маргаан таслах зөвлөл бол олон нийтийн бүрэлдэхүүн, мэргэжлийн байгууллагууд оролцсон, аймаг, нийслэлийн газартай холбоотой маргааныг аймаг, нийслэлийн Засаг дарга, Маргаан таслах зөвлөлийг байгуулж ажиллуулна. Тусгай хэрэгцээний газартай холбоотой маргааныг бол газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дэргэдээ байгуулж, энэ асуудлуудыг бол хэлэлцэж шийдэхээр ингэж бол зохион байгуулсан байгаа.

Г.Занданишатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Асуултад хариулсан 2 дарга энэ хууль батлагдсаны дараа гээд байх юм. Нэг мөсөн цогцоор нь бүгдийг нь оруулж ирж асуудлаа ярьж болохгүй байсан юм уу? Энэ газрын хууль орж ирэхээр чинь саяын асуудлууд бүгд л орон нутагт тулгамдсан асуудлууд шүү дээ. Тэгээд шийдэгдэхгүй юм байна шүү дээ. Энэ хуулиар чинь. Дараа нь энэ хууль батлагдсаны дараа 1970-аад онд батлагдсан энэ газрын нэршлийн асуудлыг өөрчилнө л гэнэ. Энэ хууль батлагдсаны дараа газрын тусгай хэрэгцээ зориулалтын газрын хуулиар тус асуудлыг шийднэ л гэх юм. Энэ асуудлуудаа нэг мөсөн цогцоор нь оруулж ирээд асуудлаа Их Хурал дээрээ яриад шийдүүлэхгүй бол энэ чинь хүмүүсийн үүсээд байгаа хэрэгцээ, эрэлт хэрэгцээг шийдэхгүй юм байна шүү дээ. Энэ тал дээр та бүхэн юу гэж үзэж байгаа юм?

Г.Занданишатар: Хэн хариулах вэ. 85. Өөрийгөө танилцуулаарай.

А.Энхманлай: Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга Энхманлай. Энэ хууль батлагдсан нь шалтгаалахгүй, ер нь бол газар зүйн нэртэй холбоотой, мөн хилийн цэстэй холбоотой асуудал бол өөр Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулиараа шийдэгдээд, зохицуулагдаад явах бол бүрэн бололцоотой. Харин саяын ярьсан зүйл дээр бол судалгаа, тодруулалтын ажлууд мэргэжлийн байгууллагууд, орон нутгууд дээр хийгдэж байна. Тэгээд энэ асуудал дуусахаар бол улсын хэмжээнд Их Хурлаар газар зүйн нэрийг 20 жилийн дараа тодруулж шинэчлэх ийм шийдвэр гаргуулна. Энэ шийдвэр гарснаараа бол саяын сумуудад үүсээд байгаа хилийн цэцтэй холбоотой маргаантай асуудлууд бол бүр мөсөн шийдэгдэнэ. Ер нь бол Их хурлын тогтоолтой холбоотой маргаан бол ганцхан нийслэл, Төв аймгийн зарим сумуудтай холбоотой л гарсан маргаан байгаа. Тэрнээс бусад нь бол Их Хурлын тогтоолыг зөв ойлгож, мөрдөхтэй холбоотой л ийм маргаан үүссэн байгаа. Тэгэхээр бол энэ асуудал бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууна.

Г.Дамдинням: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Газрын тухай ерөнхий хуулийн төсөл орж ирж байгаатай холбогдуулаад хэдэн асуулт байна. Сая Сандаг-Очир гишүүний асууж байгаа асуулттай холбогдуулаад хэлэхэд зөвхөн Төв аймаг дээр Их Хурлын тогтоолтой холбоотой маргаан гарсан юм бол байхгүй. Маши их маргаан байдаг. Би зүгээр захын жишээ хэлье. 2016 онд Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Дархан-

Уул аймгийн Хонгор сумын 9600 га газрыг дээрэмдээд авчихсан. Их Хурлын тогтоолын нэрийг будилуулаад. Тэгээд би одоо асуух гээд байгаа асуултын маань нэг нь бол энэ юм байгаа юм. Тухайн үед энэ газар нутаг дээрэмддэг, тухайн үед хэн том даргатай, аймаг орон нутаг нь бусдыгаа дээрэлхэж, дээрэмддэг энэ асуудал ер нь энэ хуулиар цэгцрэх юм уу. Маш жижигхэн газар нутагтай Дархан-Уул аймгийн газар нутгаас ингээд дээрэмдээд л аваад явчихсан, одоо тэгээд бөөн малчдын, ард иргэдийн хэрүүл зодоон болж байгаа ийм асуудал байгаа. Тэр Их Хурлын тогтоолыг бол би тэр архиваар нь ухааж үзээд зөндөө харсан. Маш их маргаантай юм байдаг. Тэгэхээр энэ асуудал цэгцрэх үү. Сая бол өөрөө худлаа л ярьж байна. Ганцхан л ийм маргаан байгаа гэж. Улс орон даяар тийм маргаан байдаг юм байна лээ Энэ дээр хариулт өгөөрэй нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ орж ирж байгаа хууль Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай хэр уялдаж байгаа вэ? Дархан-Уул аймгийн 2 дугаар багийн нутаг дэвсгэрт амьдарч байгаа бараг 3000 орчим иргэн байна. Энэ иргэдийг бол ширээ нурууныхан гэж нэрлэдэг юм. Дархан-Уул аймгийг мэддэг хүмүүс бол мэдэж байгаа байх. Хараа голын баруун эрэг дээр амьдарч байгаа хүмүүс. Энэ газар дээр амьдарч байгаа иргэд нь бол манай Дархан-Уул аймгийн иргэд. Газар нутаг нь бол Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутаг дэвсгэр. Тэгээд энд ямар асуудал үүсээд байдаг вэ гэхээр нийгмийн дэд бүтэц ерөөсөө байхгүй, тэнд сургууль байхгүй, цэцэрлэг байхгүй, эмнэлэг байхгүй, төсвийн хөрөнгө оруулалт тавьж болдоггүй, ийм хэцүү байдал руу орчихоод байгаа юм. Тэгэхээр энэ

бодит байдал дээр хүн хаана амьдарч байгаа хүнд нь нийгмийн хэрэгцээгээ хүргэж явах нь л төрийн зорилго баймаар байгаад байдаг. Гэтэл би тус тойргоос сонгогдоод явж байгаа гишүүний хувьд тэнд амьдарч байгаа иргэд сонгогчдынхоо асуудлыг шийдье гэхээр энэ газар нутагтай холбоотой асуудлаас болоод шийдэж чаддаггүй юм. Тэгэхээр энэ асуудал шийдэгдэх үү? Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуультайгаа хэрхэн уялдаж байгаа вэ? Энэ хүмүүсээ бас нийгмийн үйлчилгээнд нь хамруулчихмаар байгаа байхгүй юу? Энэ дээр тодорхой хариулт өгөөч.

Гуравдугаар асуудал. Энэ уул уурхайн хуультайгаа, хуулиудтайгаа яаж уялдаж байгаа вэ? Ер нь бол өндөр хөгжилтэй улс орнуудад бол байгалийн баялгийн бодлого гэж юм гардаг. Энэ нь бол газрын баялгаас гадна үзэгдэх байдлын баялаг, тэгээд л соёл, түүхийн баялаг гээд бүх юмыг оруулаад тооцдог ийм баялаг байдаг л даа. Тэгээд манайх энэ дээрээ ер нь та нар яаж уялдуулж энэ газрын тухай хуулиа хийсэн бэ? Дараа нь баахан маргаан гарах л байх даа. Нөгөө Хүннүгийн булшийг маань ухаад хаячихлаа, бидний өвөлжиж байсан өвөлжөө дээр очоод хайгуул хийгээд эхэллээ гээд л энэ маргаан тасардаггүй шүү дээ. Энэтэй холбоотой асуудлыг ер нь яаж шийдэж байгаа юм? Энэ хууль дээр. Ийм 3 асуулт байна.

Г.Занданишатар: 85.

А.Энхманлай: Дамдинням гишүүний асуултад хариулъя.

Хилийн цэстэй холбоотой, маргаантай асуудал бол саяын түрүүн хэлж байсан газар зүйн

нэрийн асуудалтай холбоотой, хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын тогтоол, Их хурлын тогтоолыг аймаг, орон нутгууд, сумууд маань буруу ойлголцсонтой холбоотой ийм маргаанууд ерөөсөө зонхилж байгаа юм. Ингээд улсын хэмжээнд 118 сум дээр ийм маргаантай асуудал одоогоор үүссэн. Тэгээд энэ асуудал дээр бид нар ажлын хэсэг байгуулаад, сум суманд нь очиж ажилласан байгаа. Энэний дотор бол Сэлэнгэ аймгийн Ерөө суман дээр Дархан-Уул аймгийн Орхон сумтай хоорондоо хилийн цэсийн Улсын Их Хурлаар батлагдсан тогтоолоо буруу ойлгосон. Өөрөөр хэлбэл тогтоол дээр дурдагдсан газар зүйн нэр цэг, тэмдэгтүүд хилийн цэсийн байршилүүдыг буруу ойлголцсоноос болж үүссэн маргаан байсан. Тэгээд энэ дээр ажлын хэсэг ажиллаад 2 сумын удирдлагуудтай яг газар дээр нь ажиллаад энэ асуудал бол ойлголтын зөрүүгүй болж бол шийдэгдсэн. Тэгээд ер нь бол цаашидаа саяын хэлсэн газар зүйн нэрээ ер нь тодруулж, шинэчлэх ёстой юм байна. Энэ дээр Засгийн газраас ажлын хэсэг байгуулагдаад бид бүхэн ажиллаж байгаа. Ирэх жилд багтаж энэ Улсын Их Хуралд оруулж ирэх төлөвлөгөөтэй энэ ажил хийгдэж байгаа гэж ойлгож болно. Тэгээд энэ асуудал шийдэгдээд хамгийн гол нь орон нутгийн маань удирдлагууд, иргэд маань өөрсдөө Их хурал, Ардын Их Хурлаас батлагдсан энэ газар зүйн нэр, хилийн цэсийнхээ асуудлыг зөв ойлгож, зөв мөрдөх нь хамгийн чухал байгаад байгаа юм. Улсын Их Хурлын тогтоолтой холбоотой хүчингүй болгож, шинэ тогтоол гаргаагүйтэй холбоотой Төв аймгийн Эрдэнэ сум, Улаанбаатар хотын Налайх дүүрэгтэй л холбоотой ийм асуудал бол байгаа. Энэ бол бас Засгийн газар

дээр хэлэлцэгдээд Их Хуралд орж шийдэгдэх асуудал байгаа юм.

Г.Занданшатар: 83.
Магнайсүрэн дарга хариулъя.

С.Магнайсүрэн: Барилга хот байгуулалтын яам, Магнайсүрэн. Дамдинням гишүүний Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон уул уурхайн чиглэлийн хуулиудтай хэрхэн уялдаж байгаа гэдэг тал дээр тодруулж хариулъя. Ер нь бол Газрын ерөнхий хуулийн төслөөр б байгууллага энэ газартай холбоотой асуудлыг тус тусынхаа хуулиар шийддэг. Тэгээд холбогдох дүрэм журмууд цааш нь нарийвчлаад гаргачихсан ийм зохицуулалтууд байснаас зарим газрын хуулийн үндсэн концепци, үзэл баримтлал эвдэгдэх ийм түвшинд байсан. Энэний нэг хэсэг нь бол энэ уул уурхайтай холбоотой асуудал байсан. Өөрөөр хэлэх юм бол Ашигт малтмалын тухай хуулиар лицензүүд олгогдоод “Х” болон “А” лицензүүд олгогдоод газрын мэдээллийн нэгдмэл нэгдсэн санд бүртгэгддэггүйгээс болоод олон давхардлууд гарах, маргаан үүсэх ийм асуудлууд байсан.

Манай энэ оруулж ирж байгаа хуулийн төслөөр бол энэ асуудал бүрэн шийдэгдэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол газар зохион байгуулалтын улсын ерөнхий болон жилийн төлөвлөгөөний төсөлд энэ асуудлыг эхэлж төлөвлөх ёстой ч өөрөөр хэлэх юм бол улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө батлагдахад хайгуулын ямар лицензүүд хаана, хаана олгогдох вэ гэдэг энэ байрилууд тодорхой суугаад тэрний дагуу асуудал шийдэгдэж байгаа юм. “Х” лиценз олгогдох асуудлууд Ашигт

малтмалын хуулийн дагуу явахаар энэ холбогдох уялдааг нь оруулж ирсэн байгаа. “А” лицензийн тухайд бол энэ “Х” лицензийн яваад энэ дээр “А” лиценз авах тохиолдолд тусгай зөвшөөрөл авснаасаа хойш “А” лиценз авснаас хойш 30 хоногийн дотор тухайн газар дээр газар ашиглах гэрээ байгуулах энэ ас асуудал нь манай газрын мэдээллийн цахим сангаар дамжаад ингээд 30 хоногийн дотор шийдвэрлэгдэх ийм бололцоотой байхаар бид нар ингэж хуулийн төсөл оруулж ирсэн. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай бол үндсэндээ шууд холбогдохгүй ч гэсэн Хот тосгон гэдэг бол тодорхой засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар нутаг дээр байрладаг ийм зохион байгуулалтын хувьд тухайн газар, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дээр байгаа улсын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөнд туссан тэр газрын бодлогын эдэлбэр газрын хүрээнд асуудал нь шийдэгдээд явна. Иргэдийн тухайд бол газартай холбоотой үйлчилгээг авахад нь бол ямар ч саад байхгүй. Бүр өөр нэгжээс ч цахим сангаар дамжиж, өөр аймаг, сум руу ч хүсэлтээ тавьж асуудлаа шийдүүлэх ийм бололцоог бол энэ хуулийн төслөөр бол зохицуулж оруулж ирсэн байгаа. баярлалаа.

Г.Занданшатар: Дамдинням гишүүн тодруулж асууя.

Г.Дамдинням: За байз та нар Их Хурал дээр орж ирээд л худлаа яриад байх юм даа. Түрүүн дээр хамгийн эхэлж тайлбар хэлээд байсан хүн хэн билээ. Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын хүн үү. 1970-аад оноос хойш Дархан-Уул аймагт байсан 9600 га газар. 1992 оны Ардын Их Хурлын тогтоолоор

Дархан-Уул аймагт байсан газар. Тогтоолоос хойш 24 жилийн дараа 2016 онд та нар дарга нарт үйлчлээд дээрэмдчихсэн газар байхгүй юу. Буруу ойлгосон гэж яриад байх юм. Хэн ч буруу ойлгоогүй. 50 гаруй жил энэ аймагт Дархан-Уул аймгийн Дархан хотын газар байсан газрыг буруу ойлгосон гэж хэлээд луйвардаад дээрэмдээд явчихсан л байхгүй юу. Тэгээд юу яриад байгаа юм Та нар. 2 сумын дарга нар хоорондоо яриад шийдсэн юм байхгүй шүү дээ. Энийг та нар тодорхой хэл л дээ, үнэн биз дээ.

Г.Занданшатар: 85.

А.Энхманлай: Тодруулж хариулъя. Ер нь бол Их Хурлын 2002 оны газар зүйн нэр баталсан тогтоол. Энэ тогтоол батлагдахдаа энэ тогтоолд гол судалгаа хийж үндэслэл болгосон материал бол 1985 онд хийгдсэн судалгаан дээр суурилсан ийм тогтоол байсан. Тэр үед бол энэ сүүлд байгуулагдсан Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон зэрэг аймгууд бол аймгуудын нэршил, сумуудын нь нэр тухайн аймгийн, тэр сумын ийм газар гэж бол ингэж Улсын Их Хурлаар тогтоогдоогүй. Тэгэхээр энэ шинэ тогтоолоор бол Дархан-Уул аймгийн Хонгор сумын тийм нэртэй газар гэж энэ шинэ тогтоолоор л орж ирэх ийм бололцоо бүрдэж байгаа. Тийм учраас аймгуудаас бид нар энэ газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг хийгээд аймгийнх нь Иргэдийн хурлаар хэлэлцүүлээд эхнээсээ бол аймгууд дууссан нь ирээд явж байна.Тэгээд аймаг бүгд бүрдэхээрээ Их Хурал дээр орж ирж энэ шийдэгдэнэ.

Хилийн цэсийн асуудал дээр бол ямар нэгэн маргаан байхгүй. Ямар байдлаар.../минут дуусав/

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Газрын тухай хууль, Газрын тухай багц хуулийг бүхэлд нь оруулж ирж байна. Тэгээд хуулийг бол бүхэлд нь бол дэмжиж байгаа юм. Би бодож байгаа юм. Газрын тухай хууль орж ирснээрээ бид нар тулгамдсан, маргаантай байдаг 4 том асуудлыг шийдэх ёстой гэж боддог юм. Тэгээд би энэ хуулийг энэ 4 том асуудлыг шийдсэн үү гэж асуух гэж байгаа юм.

Нэгдүгээрт нь үл хөдлөх хөрөнгө, газартай холбоотой асуудал байдаг. Төв суурин газар дээр үл хөдлөх хөрөнгө нь тусгай бүртгэлтэй, газар нь тусгай бүртгэлтэй явдаг. Энэ Газрын тухай хууль орж ирснээрээ үл хөдлөх хөрөнгө, газар 2 нэгдсэн бүртгэлтэй болж чадаж байгаа юу гэдэг асуудал байгаа юм.

Хоёрдугаар асуудал. Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай асуудал байгаа юм. Өнөөдөр ний нуугүй хэлэхэд Улаанбаатар хотод энэ Зайсан урагшаа энэ Богдхан уулын бүс бол тэр чигээрээ барилгажчихсан. Гэтэл тусгай хамгаалалттай газар байдаг гээд. Өөр одоо Байгаль орчин, аялал жуулчлалын яам газрыг нь олгодог. Төлөвлөлт байдаггүй. Өнөөдөр энэ Яармагийн түгжрэлийг бол манайхан харж байгаа. Ямар түгжрэл байна вэ гэж. Тэгэхээр энэ тусгай хамгаалалттай газар нутгийн асуудлыг энэ хуулиар яаж шийдэж байгаа вэ. Энэ өнөөдөр шийдэх ёстой хамгийн том асуудлын нэг мөн үү гэвэл мөн. Далд бизнес байнга явагдаж байдаг. Төлөвлөлт огт байдаггүй. Өнөөдөр Улаанбаатар хотын түгжрэлд томоохон хувь

нэмэр болж байгаа нэг хэсэг объектын хувьд мөн үү гэвэл мөн байгаа. Энийг энэ газрын багц хуулиар яаж шийдэж байгаа вэ. Энийг шийдэхгүйгээр бид нар газрын тухай асуудлыг яриад, хөөрөөд хэрэггүй юм байгаа юм.

Гурав дахь асуудал, бэлчээртэй холбоотой асуудал. Малчдын хувьд бэлчээрийн маргаан их байна. Зуд зурхан болж байна. Энэтэй холбоотойгоор аймаг, сумдыг дамжиж отор нүүдэл хийж байна. Энд маш их хэмжээний бэлчээрийн маргаан гарч байна. Би бэлчээрийн маргааныг шийдвэрлэхийн тулд бид нар бэлчээрийн маргааныг шийдэх шаардлагатай. Энийг бид нар бэлчээр ашиглалтын асуудлаар нь шийдэх ёстой гэж боддог юм. Энэ хууль энэ Газрын тухай багц хууль нь бэлчээр ашиглалтыг зохицуулах чиглэлээр юу тусгагдсан бэ гэдгийг асуух гээд байгаа юм. Бид бэлчээр ашиглалтыг л зохицуулалт хийх ёстой. Зохицуулалтгүй яваад энэ цаашидаа явах гарцгүй зогссон. Гурав дахь асуудал нь энэ.

Дөрөвдүгээр асуудал нь лицензтэй холбоотой асуудал. Уул уурхайн лицензтэй холбоотой асуудал. Хуучин бол лиценз харьцангуй энэ Урт нэртэй хууль гараад 2008, 2010-аад оноос хойш жаахан цэгцэрсэн. Гэхдээ сүүлийн үед энэ эдийн засгийг хөгжүүлэх хэрэгтэй байна. Уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжье гэдэг нэрийн дор лицензийн олголт жаахан замбараагаа явагдаад байх шиг байгаа юм. Сүүлийн үед энэ Их Хурлын гишүүд бид нар хөдөө очиж ажиллахад ерөөсөө хамгийн их тулгамдаж ярьдаг юм нь лиценз ярьдаг болсон байна. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл.

Үүнийг олгохдоо, анх зөвшөөрөл авахдаа орон нутгийн зөвшөөрөл авдаггүй, санал авдаггүй, энэнээс болоод энэ лицензтэй холбоотой маргаан их байна. Энэ газрын тухай багц хууль дээр ашигт малтмалтай холбоотой асуудлуудыг яаж зохицуулж оруулж ирж байгаа вэ гэдэг асуудлыг би дөрөвдүгээрт нь асуух гэж байгаа юм.

Энэ 4 бол өнөөдөр манайд газартай холбоотой асуудал дээр үүсэж байгаа 4 том тулгамдсан асуудал. Газрын тухай багц хуулийг ярьж байхад бол бид нар энэ 4 асуудлыг заавал шийдэх шаардлагатай гэж бодож байна.

Тав дахь асуулт нь хот байгуулалтынхаа хуультай хэрхэн уялдаж байгаа вэ? Газрын хууль, хот байгуулалтын хууль 2 хоорондоо уялдаагүй. Тус тусдаа явдаг. Энэнээс болоод үл хөдлөх хөрөнгийн болон газрын маргаанууд маш их гардаг. Одоо бид нар энэ хот байгуулалтын хуультай газрын хуулийг хэрхэн уяж өгч байна вэ? Суурь асуудал нь газар учраас бид нар газрын хуулиар нь хот байгуулалтын олон асуудлыг зохицуулах шаардлага байгаа юм. Энэ чиглэлээр тавдугаарт нь юу тусгагдав вэ гэсэн ийм 5 багц асуудлыг асууя. Баярлалаа.

Г.Занданшатар: 5 багц асуудлыг асуулаа. Магнайсүрэн дарга. 83.

С.Магнайсүрэн: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Барилга хот байгуулалтын яам. Магнайсүрэн.

Энэ хуулийг оруулж ирэх нэг гол үндэслэл нь Газрын тухай багц хуулийн хуулийн төслийн ерөнхий концепцийг Иргэний хуулийн суурь

зарчимтай нийцүүлж Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд нийцүүлэх ийм үндсэн чиглэл байсан. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг баталсантай холбогдуулаад Улсын Их Хурлаас тогтоол гаргаж, энэ газрын хуулийн энэ зарчмын асуудлыг шийдэж оруулж ирэх ийм үүрэг өгсөн. Энэ дагуу үл хөдлөх хөрөнгө бол газраасаа салшгүй нэгдмэл байх, бүртгэл нь нэг байх энэ зарчмын асуудлуудыг бид нар бол хуулийн төсөлдөө тусгаж оруулж ирж, бүрэн шийдэж оруулж ирсэн. Энэ дээр бол Хууль зүйн яам, бусад холбогдох байгууллага, Улсын бүртгэлийн газартай бид нар нягт хамтарч ажиллаж, асуудлыг шийдсэн, бүрэн шийдсэн гэж ингэж ойлгож байгаа.

Бүртгэлтэй холбоотой асуудал нь бол газрын дундын мэдээллийн сангаар дамжуулаад шуурхай, богино хугацаанд, хүний оролцоогүйгээр асуудлыг шийдэх ийм бололцоог бол бүрдүүлэхээр хуульчилж орж ирсэн.

Тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой асуудлыг бол бүрэн цэгцэлж орж ирсэн гэж ойлгож болно. Ер нь бол тусгай хамгаалалттай газар нутаг дээр ашиглуулах газрын асуудал шийдэгдээд, тэгээд тэр асуудал нь манай газрын мэдээллийн санд бүртгэгддэггүйгээс болоод дээр нь хилийн цэстэй холбоотой зөрчил, маргаан давхардлаас болоод олон асуудал бол энэ шүүх болон хууль хяналтын байгууллага дээр маргаан үүсгэж, тэр нь ихээхэн бидэнд ачаалал төвөгтэй байдал үүсгэдэг байсан. Энэ асуудал бол өнөөдрийн энэ газрын ерөнхий хуулийн төслөөр бол бүрэн шийдэгдэж орж ирсэн. Тусгай хамгаалалттай газар нутгийн ерөнхий төлөвлөгөө бол хуульчлагдаж

орж ирж байгаа. Энэхүү ерөнхий төлөвлөгөөг Засгийн газар батална. Энэ ерөнхий төлөвлөгөө нь бол 15 жилийн хугацаатай ийм ерөнхий төлөвлөгөө байна. Энэ ерөнхий төлөвлөгөө боловсруулах журмыг бол Байгаль орчны болоод газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтарч батална. Энэ ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг нь болохоор зэрэг 2 сайд хамтарч баталж өгч байгаа. Ингээд ерөнхий зарчмаараа бол энэ тусгай хамаатай газар нутагт газар ашиглахад бол дуудлага худалдааны төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу дуудлага худалдааны журмаар асуудал шийдэгдээд, тэр дуудлага худалдааны ялагч нь ялагчийн мэдээлэл, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд дундын мэдээллийн сангаар дамжиж хүрээд, тэгээд тэр яамтай энэ гэрээ байгуулагдаж, гэрчилгээ нь олгогдож, ингэж явахаар, өөрөөр хэлэх юм бол мэдээллийн сан, зохион байгуулалтын төлөвлөлт хоёроороо бол нэгтгэж өгсөн ийм зарчмын шийдэл орж ирж байгаа.

Лицензтэй холбоотой асуудал мөн саяныхтай төстэй. “Х” лицензтэй холбоотой төлөвлөлт буюу хайгуулын төлөвлөлтийн асуудал нь улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд сууж байгаа. Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг Засгийн газар батална. Энэ дотор ямар ямар газар лиценз, уул уурхайн асуудлыг шийдэх асуудал нь бол тодорхой тусаж орж ирнэ. Энэ дагуу бол асуудал нь шийдэгдэнэ. Энэ хүрээнд шийдэгдсэн асуудал бол мэдээллийн санд нэгтгэгдэж, гэрээ байгуулах нь бол Ашигт малтмалын газар буюу уул

уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын түвшинд шийдэгдэж явж байгаа. “А” лицензийн асуудал бол арай өөр. Шийдэгдсэн “Х” лиценз нь хэзээ “А” лиценз бол болох вэ, тэр асуудал нь шийдэгдээд зөвшөөрөл авсан нөхцөлд 30 хоногийн дотор манай цахим мэдээллийн сангаар дамжиж хүсэлт нь тавигдаж, гэрээ нь хийгдэж ингээж явж байгаа.

Бэлчээртэй холбоотой асуудлаар. Ер нь бол бид нар отрын бүс нутагт л гэрээгээр бэлчээрийг эзэмшүүлж болохоор оруулсан. Бусад тохиолдолд бол уламжлалт нүүдлийн хэв маягийг бол оруулж ингээж.../минут дуусав/

Г.Занданшатар: 5 багц асуулт асуусан шүү дээ. Сая 3-ыг нь л хариуллаа. 85.

А.Энхманлай: Нэмэлт хариулт өгье. Бэлчээртэй холбоотой асуудлыг бол бид бүхэн бас энэ газрын хууль дээр зохицуулж оруулж өгсөн. Бэлчээрийг зүй зохистой яаж ашиглах вэ, бэлчээрийг яаж хамгаалах вэ, бэлчээр ашиглагчийн үүрэг юу юм, бэлчээрт хохирол учирвал хэн энэ хохирлыг нөхөн төлж барагдуулах юм, үйл ажиллагааг яаж явуулах юм гэдгийг бол тусгасан. Тэгээд ингээд бэлчээрийг бол 2 төрлөөр ашиглана. Нэгийг нь бол нийтээр ашиглана. 2-т нь бол гэрээгээр ашиглана гэж байгаа. Нийтээр ашиглах бэлчээрт бол хүний гараар бий болсон ус цэг, хужир мараа бүхий бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээрүүд бол нийтээр ашиглагдана. Отрын нөөц бэлчээрийг бол гэрээгээр ашиглана. Одоо бол нийт бэлчээрийн 0.6 хувь бол отрын нөөц бэлчээр гэж үзэж байгаа. Цаашидаа бол бид нар энэ

бэлчээрийнхээ газрын 10 хүртэлх хувийг 10 хувьд хүргэж отрын нөөц бэлчээрийг шинээр үүсгэж, хамгаалах хэрэгтэй юм байгаа юм. Тэгээд энэ дээрээ бол байгаль, цаг уур хүндэрсэн үед малчдыг нүүлгэж энэ отрын нөөц бэлчээр дээр өвөлжүүлэх, хаваржуулах ийм бололцоог бүрдүүлэх үүднээс ийм бэлчээрийн ашиглалтыг зохион байгуулж оруулсан байгаа.

Хот байгуулалтын тухай хуультай яаж уялдаж байгаа вэ гэхээр бид бүхэн хот байгуулалтын бүсчлэл бүсчлэлүүдийг гаргаж ирсэн байгаа. Энэ газар ашиглалтын бүсчлэл, хотын бүсчлэл гээд 9 төрлийн бүсчлэл байгаа. Энэ бүсчлэл дээр бол бид нар газар ашиглалт, газар олгох ажлыг бүсчлэлийнхээ дагуу зохион байгуулна. Одоо бол тийм асуудлыг мөрдөхгүй яваад байгаа. Ер нь дэлхийд бол угаасаа энэ бүсчлэлийнхээ дүрмээр, бүсчлэлийнхээ зохион байгуулалттай энэ ажлыг бол хийгддэг. Тэгэхээр гол зохион байгуулалтын өөрчлөлт бол энэ асуудал дээр төвлөрч байгаа. Тэгэхээр бүсчлэл дээрээ яг ямар давхартай барилга байгууламж барих юм, үйлдвэрлэлийн бүс дээр ямар үйл ажиллагааг зөвшөөрөх юм, орон сууцны бүсэд ямар үйл ажиллагааг явуулах юм, олон нийтийн бүсэд яах юм, ногоон байгууламжийн бүсэд яах юм гээд тодорхой бүсүүд дээр газар олгох газрын зориулалтууд болон хот байгуулалт, барилгын зөвшөөрөл олгох ажлууд бол энэнтэйгээ холбоотойгоор уялдаатай шийдэгдэж явахаар ингээж зохион байгуулж өгсөн байгаа.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Монгол Улсын Үндсэн хуульд “Төрийн удирдлагыг нутгийн өөрөө удирдах ёстой хослуулан хэрэгжүүлнэ.” гэж заасан байдаг. Тэгэхээр Монгол Ардын нам 2016 оноос хойш энэ нутгийн өөрөө удирдах ёс руу халдсан ийм эрээ цээргүй халдлагыг байнга хийж байна. Үндсэн хуульд ч хийсэн, бусад хуулиудаар маш их хийж байгаа. Тэгэхээр нутгийн өөрөө удирдах ёс муудна гэдэг чинь яг тэр өөрийнхөө ойр байдаг сумын Иргэдийн хурал, аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгчөөрөө дамжуулаад тэр Иргэдийн хурлаараа дамжуулаад энэ төрийн үйл ажиллагаанд оролцох тэр эрхийг л боомилж өгч байгаа юм л даа. Ялангуяа энэ асуудал юун дээр их гардаг вэ гэхлээр ашигт малтмалын лицензтэй холбоотой маргаан дээр гардаг. Тэгэхлээр өнгөрсөн хугацаанд Ашигт малтмалын тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, тэгээд өнөөдөр энэ Газрын тухай хууль дээр энэ ашигт малтмалын лицензтэй холбоотой иргэдийн эрх, багийн Иргэдийн нийтийн хурлын эрх, сумын Иргэдийн нийтийн хурлын эрх, аймгийн Иргэдийн хурлын эрх, тэгээд багийн Засаг дарга, сумын Засаг дарга, аймгийн Засаг даргын бүрэн эрх рүү халдсан ийм халдлагуудыг хийж байна. Тэгэхээр өнөөдөр Ашигт малтмалын тухай хуулиар тэр ашигт малтмалын лицензтэй холбоотой маргаан суман дээр нь үүслээ гэхэд сумын дарга Баатар гэдэг хүн иргэн Доржтойгоо адилхан ямар ч эрхгүй болсон байгаа. Хэрвээ ямарваа нэгэн тийм эрх ашгийг нь хөндсөн шийдвэр, асуудал гарлаа гэхэд тэр ашигт малтмалын уурхайг ганцхан зогсоох хэрэгтэй хүн нь аймгийн Засаг дарга л байгаа шүү дээ. Тэгээд урьд нь ашигт

малтмалын лиценз авахад багийн Иргэдийн хурлаар хэлэлцэж байгаад дэмжсэн бол багийн Иргэдийн хурал нь сумын Засаг даргадаа санал оруулаад, иргэдийн хуралдаа санал оруулаад л шийддэг байсан бол энэ эрхүүдийг бүгдийг нь үе шаттай Ашигт малтмалын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиас авч хаяж байна. Өнөөдөр Газрын тухай хуулиар Багийн иргэдийн хурал, сумын Иргэдийн хурал, аймгийн Иргэдийн хурал, багийн Засаг дарга, сумын Засаг дарга, аймгийн Засаг даргын нийтдээ 40 гаруй эрхийг бүгдийг нь авч хаялаа.

Мянга мянган жил энэ эцэг өвгөдийнхөө амьдарч байгаа энэ нутагт нь төр, өөрөөр хэлбэл Засгийн газар шууд халдах ийм боломжийг л энэ хуулиар олгож байна. Урьд нь Газрын тухай хууль дээр хамгийн наад захын эрхийг нь би хэлээд өг л дөө. Багийн Засаг даргын эрх нь болохоор газар хамгаалах талаар шаардлагыг хангуулах үүрэгтэй байсан. Хангуулах үүрэгтэй байсан. Тэгээд багийн Иргэдийн нийтийн хурал, тэр багийн Засаг дарга юу хийсэн юм, ямар асуудал яасан юм, тэр илтгэлийг нь тайланг нь сонсдог, дүгнэдэг байсан ийм л бүх эрхүүдийг бүгдийг нь авч хаях замаар, өөрөөр хэлбэл иргэдийн насан туршидаа үе уламжлан амьдарсан, тэр нутгаас нь л хөөж зайлуулах ийм зүйлийг л энэ үе шаттайгаар хийж энэ орон нутагт амьдарч байгаа тэр хүмүүсийнхээ хөл дээр гишгэх зүйлийг л хийгээд байна л даа. Ийм учраас энд тэнд суманд баг дээр асуудал гарч байгаа бол энэ асуудал чинь ерөөсөө л энэ үе шаттайгаар МАН-ын 2016 оноос хойш хийж байгаа энэ хуулиудын үр дүнд та нар ямар ч эрхгүй, багийн

иргэд ямар ч эрхгүй, багийн дарга чинь ямар ч эрхгүй, сумын дарга чинь ямар ч эрхгүй, бүх зүйл нь ийм болоод хувираад байна шүү дээ. Та нарын хэлж байгаа үг чинь цуурайд цуурах мэт тийм л үг болж хувирч байгаа. Тийм учраас хуулийн дагуу та нарын газрын асуудлыг шийдвэрлэж байгаа дээрэмдэж байгаа юм.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. 83. Магнайсүрэн. Сандагийн Магнайсүрэн Төрийн нарийн бичгийн дарга.

С.Магнайсүрэн: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яам. Магнайсүрэн.

Багийн Иргэдийн нийтийн хурал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, холбогдох шатны Засаг дарга нарын эрх хэмжээ бол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиар бол ерөнхий зохицуулалтууд нь бол байгаа. Манай газрын ерөнхий хууль дээр орж ирсэн концепци бол тухайн, тухайн асуудал. Тухайлбал газар зохион байгуулалтын тухайн шатны төлөвлөгөөг боловсруулах, батлах шатанд бүх шатны хурлууд хэлэлцэж, санал дүгнэлтээ өгөх, эрх хэмжээнийхээ хүрээнд батлах, дараа нь хэрэгжилтийн тайлан үнэлгээг сонсох, тодотгож өөрчлөхтэй холбоотой бүх зохицуулалт, эрх хэмжээнүүд бол энэ хуулийн тухайн холбогдох зүйл заалтуудад нь бол тараад бид нар хийчихсэн байгаа. Тодорхой зүйл заалтаар энэ эрх хэмжээ нь сумын даргын эрх, эрх хэмжээ, чиг үүрэг, эсвэл сумын Иргэдийн нийтийн хурлын эрх хэмжээ, чиг үүрэг гэж тусгайлан заагаагүй боловч тухайн тодорхой зүйл заалтууд дээрээ бол тарж,

тарж байрлуулж, хуулийн төсөл бичигдэж орж ирснээрээ бол өөр юм байхгүй байгаа юм шиг ингэж харагдаад байх шиг байна. Ашигт малтмалын тухай хууль дээр бол харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар нь ашиглуулах зөрчил гаргавал таслан зогсоохтой холбоотой сумын Засаг даргын бүрэн эрх бол бас хэвээрээ байж байгаа. Тэгэхээр энэ лицензтэй холбоотой асуудлаар бид бол ямар нэгэн маргаан төлөвлөлтөөсөө авхуулаад анхнаасаа сумын, багийн Иргэдийн нийтийн хурлаас авхуулж яваад сумын улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө хүртэл саналууд орж батлагдах учраас төлөвлөлт нь алдаагүй төлөвлөгдөөд цаашаа олголт нь хийгдээд явах учраас ямар нэгэн маргаан гарахгүй байх ийм нөхцөл талаас нь бол илүү бодож манай газрын ерөнхий хуулийн төсөл бол томъёологдож орж ирсэн байгаа гэж ингэж ойлгож болно. Баярлалаа.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн тодруулъя. Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Яг энэ Ашигт малтмалын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хууль, тэгээд Газрын тухай хуулиар, дээрээс нь жил болгоны төсвийн хуулиар тодорхой хэмжээгээр энэ Ашигт малтмалын хууль дээр өөрчлөлтүүдийг оруулдаг. Заалт оруулж ирж өөрчилдөг. Тэгээд өнөөдөр энэ 40 гаруй эрх байсныг нь бүгдийг нь тараах замаар, өөрөөр хэлбэл энэ эрхүүдийг ер нь бол ихэнх нь үүрэгтэй, өөрөөр хэлбэл тэр багийн Иргэдийн нийтийн хурлын дарга болон бусад одоо багийн Засаг

дарга энэ тэр бол бүгдээрээ үүрэгтэй ажиллаж эхэлж байгаа юм. Тэнд тэнд байсан эрхүүдийг нь бүгдийг нь хангуулах эрхүүдийг бүгдийг нь авч хаяж байгаа юм. тэгээд та нар Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хууль руу шилжсэн гэж ярьж байгаа боловч яг ачир дээрээ тэнд нь очоод яг тэн дээр нь ашигт малтмалын лицензтэй холбоотой маргааныг иргэдийнхээ өмнөөс гомдол гаргах, хуулийн дагуу.../минут дуусав/

Г.Занданишатар: Хэн хариулах вэ. Магнайсүрэн. 83.

С.Магнайсүрэн: Тодруулж хариулъя. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийн шинэ хууль гараад хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байгаа. Энэ хуулийн концесстой бид нар бас уялдуулж Газрын ерөнхий хуулийн төсөл, бусад 4 хууль, ингээд 5 хуулийн төслөө оруулж ирж байгаа. Ашигт малтмалтай холбоотой асуудлаар яг лицензтэй холбоотой асуудал нь Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагдаж яваа. Энэ хүрээнд байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын түвшний эрх хэмжээ, чиг үүрэг бол хэвээрээ байж байгаа. Газрын ерөнхий хуульд бол лицензийн зөвхөн газар ашиглуулах гэрээ байгуулахтай холбоотой, энэ процесс нь бол 30 хоногийн дотор гээд тодорхой болж орж ирсэн, илүү тодорхой болж орж ирсэн гэж хэлж болно. Газартай холбоотой газрын эрх хэмжээтэй холбоотой баг, хороо болон сум, дүүргийн Иргэдийн нийтийн хурал болон Иргэдийн хурал Засаг дарга нарын бүрэн эрх тодорхой яг тухайн зохицуулалт.../минут дуусав/

Г.Занданишатар: Гүйцээгээд хариулчих. 83. Гүйцээгээд хариулчих.

С.Магнайсүрэн: Эрх хэмжээг бол бид нар бол хасаагүй.

Г.Занданишатар: 1 минут асууя Пүрэвдорж гишүүн. Цөөнх гэж бодоод.

Б.Пүрэвдорж: Энэ түрүүчийн Газрын тухай хууль дээр байсан газар хамгаалах талаар багийн Засаг даргын шаардлагыг хангуулах, өөрөөр хэлбэл тэр аж ахуйн нэгж дээр шаардлага хангуулах эрх нь хааччихсан юм. Байхгүй болчихсон байгаа биз дээ? Тэгээд таны хэлээд байгаа тэр Ашигт малтмалын тухай хууль дээр чинь хэрвээ ашигт малтмалтай холбоотой байгаль орчны болон бусад асуудал гарахад зогсоох эрх ганцхан аймгийн Засаг даргад л байгаа шүү дээ. Сумын засаг даргад байсан бүх эрхүүд бүгдээрээ алга болчихсон шүү дээ. Сумын засаг дарга Баатар гэдэг хүн чинь сумын иргэн Дорж гэдэг хүнтэйгээ адилхан ямар ч эрхгүй болчихсон байхгүй юу даа. Тэгээд манай сумдын иргэд болохлоор зөвхөн тэр нөгөө сумын дарга руугаа дайраад байгаа юм. Энэ Монгол Ардын нам чинь тэр хуульд нь өөрчлөлт оруулах замаар ашигт малтмалын лицензийг бүгдийг нь дээрээс нь шийддэг тийм эрхийг л өөртөө үе шаттайгаар авч байна шүү дээ. Энэ ашигт малтмалын бизнес хийдэг тэр хүмүүсийн лоббигоор. Тэр хүмүүсийн лобби чинь энэ хууль дээр дахиад ороод ирчихсэн байна. Чамаас хариулт авахгүй.

Г.Занданишатар: Дэг зөрчиж байна шүү, хариулт авахгүй гэж. Хариулт тодруулж асуух ёстой болохоос биш. 83. Магнайсүрэн.

С.Магнайсүрэн: Би товчхон, тодорхой хариулчихъя. Ашигт малтмалын хуульд аймаг, сумын Засаг даргын бүрэн эрх гээд 12.1.2 дээр харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрөл олгогдсон талбайг зориулалтаар нь ашиглуулах зөрчил гаргавал таслан зогсоох гээд Засаг даргын бүрэн эрх байгаа. Мөн сумын дарга дээр одоо би танд хэлээд өгье. Ашигт малтмалын хуулийн 12 дугаар зүйл дээр сумын Засаг даргын бүрэн эрх. 12.2 дээр байж байгаа. Энэ дээр бол энэ хяналт тавих, харьяалах нутаг дэвсгэртээ эрдэс баялгийн салбарын талаар хэрэгжүүлж байгаа шийдвэрийн талаар жил болгон олон нийтэд мэдээлэх, олборлох үйл ажиллагаанд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хяналт тавих гээд энэ бүрэн эрхүүд байгаа. Таслан зогсоох гээд сая би 12.1.2-т сумын Засаг дарга дээр байгаа. Аймаг, сумын Засаг даргын бүрэн эрх 12-дугаар зүйл дээр байгаа.

Г.Занданшатар: Хуулиа сайн унш. Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Газрын хууль бол чухал хууль. Одоо бол хөдөө бэлчээрийн маргаан, өвөлжөө, хаваржааны газрын маргаан, сумуудын хооронд хилийн цэсийн маргаан, аймгуудын хооронд хилийн цэсийн маргаан, Улаанбаатар хот руу орж ирэх юм бол Богд уулын захиргаа, тусгай хамгаалалт, нийслэлийн газрын маргаан гээд энэ дунд нь иргэд асар их хохирч байгаа. Өнөөдөр энэ Богд уул Яармагийн хавь гэхэд Улаанбаатар хот нэг хилийн цэстэй, Байгаль орчны яам нэг хилийн цэстэй, дунд нь энэ газрын харилцаа геодези, зураг зүйн газрынхан нь нэг цэстэй. 3 хилийн цэс байдаг. Тэгээд тэр дунд нь

Байгаль орчны яамны сайдын тушаалаар газар олгогчид, тэрийг нь нийслэлийн дүүргүүд гуравласан гэрээ хийдэггүй. Энэнээсээ болоод иргэд асар их хохирч байгаа учраас энэ газрын хуулийг хэлэлцэх явцад нь өмнөх энэ зөрчлүүдээ цэгцлэх зайлиггүй шаардлага байгаа юм. Өнөөдөр шүүх дээр байгаа нийт хэргийн бараг 23 хувь нь газрын маргаантай холбоотой асуудал байна гэж түүрүүн мэдээлж байна лээ.

Тэгээд хуулийн төсөл оруулж ирэхээрээ манай энэ холбогдох байгууллагууд ерөөсөө ерөнхий хууль бол хамгийн чухал удирдлага, зохион байгуулалт эхлээд явж байгаа юм л даа. Гэтэл яаж байна гэх дээр зэрэг ерөөсөө хууль оруулж ирэхээр л томилгоо булаацалдсан, дээш нь төвлөрүүлэх гэсэн юмнууд л яваад байх юм. Өнөөдөр энэ ерөнхий хууль дээр аймаг, нийслэлийн Иргэдийн хурал, Засаг даргын бүрэн эрх, эрх мэдэл, үүрэг юу ч байхгүй, нэг ч заалтгүй болгоод хаячихсан. Тэр битгий хэл нийслэлийн Засаг дарга, аймаг, сумын дарга нар газар олгохыг нь хориглоххож байгаа юм. Газрын алба газар олгоно. Тэр битгий хэл аймгийн газрын албаны хэлтсийн дарга нар, мэргэжилтнүүд, бүх хүмүүсийн сумдын газрын даамлуудыг бүгдийг нь Газрын харилцаа, геодези зураг зүйн газраас томилно. Ийм юм яваад байгаа байхгүй юу. Тэгээд л ерөөсөө эрх мэдлийг төвлөрүүлэх, өөрсөд дээрээ эрх мэдэл авах, тэр хөдөө орон нутгийнхныг томилох л ийм л зорилго агуулдаг. Тэрнээс үндсэн газрынхаа энэ маргааныг цэгцэлье гэсэн юм ерөөсөө явахгүй байгаа юм. Тэр битгий хэл нийслэлийн юм уу, аймгийн олгосон газруудыг шууд хүчингүй болгодог эрх мэдлийг хүртэл агентлаг дээр авахаар ийм

юмнууд яваад байгаа юм. Яагаад ийм юм хийгээд байгаа юм бэ.

Бид нар чинь бол төвлөрлийг сааруулъя, орон нутгийн эрх мэдлийг нэмье гэдэг л Засгийн газар ч тэр, Их Хурлаас ч гэсэн ийм бодлого бариад яваад байдаг. Гэтэл эсрэгээр нь энэ оруулж ирж байгаа хуулиудыг чинь агентлагийнхан чинь зөвхөн өөрсдийнхөө эрх мэдлийг нэмэх л юмнууд хийгээд байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр би хариулт авмаар байгаа юм.

Сая одоо олон гишүүд ярьж байна. Ашигт малтмалын хуультай холбоотой. Хөдөө орон нутагт бол сүүлийн үед энэ лицензийн газартай холбоотой, дуудлага худалдаагаар олгож байгаа газар, эсвэл шууд олгодог нефтийн хайгуултай холбоотой газрууд дээр бол иргэдээс асар их шүүмжлэлүүд гомдлууд ирж байна. Тэгэхээр би бол ерөнхий хуульд сая гишүүдийн асуултад яамныхан яаж хариулж байна гэхээр дараа нь Ашигт малтмалын хуулиар, эсвэл дараа тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулчихна л гээд байгаа байхгүй юу, тэгэх биш. Ерөнхий хуульдаа бид нар оруулж өгмөөр байна. Орон нутгийн энэ засаг захиргааны эрх мэдэл юу байх юм, багийн Иргэдийн нийтийн хурлын эрх мэдэл юу байх юм гэдгийг Ерөнхий хуульдаа оруулж өгч байж энэ хууль нь дараа дараагийн салбар хуульдаа заавал орж явахгүй бол өөр хуулиуд руу чихэж явсаар байгаад гол асуудлаа бид нар энэ ерөнхий хуулиас хасчих гээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол бид нар зайлшгүй энэ зүйлүүдийг оруулах шаардлага байна. Тэгээд газрын маргаан таслах зөвлөл гээд бас нэг

татварын маргаан таслах зөвлөл шиг дамжлага болсон ийм зүйл явах гээд байгаа юм. Тэгэхээр энийг яг яаж явах юм бэ?

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. 83. Сандагийн Магнайсүрэн.

С.Магнайсүрэн: Ганболд гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яам. Магнайсүрэн.

Томилгоотой холбоотой асуудал. Аймаг, нийслэлийн Засаг дарга, хурлын эрх хэмжээтэй холбоотой асуудлыг хөндөж асууж байна. Томилгоог бол бид нар өнөөдрийн аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагтай зөвшилцөж газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдлагаа тухайн шатандаа томилох, энэ эрх хэмжээ, зохицуулалтыг хэвээр оруулж ирсэн. Сум дүүрэг, тэгээд бусад албан хаагчдын тухайд бол тухайн манай газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилгоо бас явахаар ийм онцлог зохицуулалт оруулж ирсэн байгаа. Энэ нь болохоор газрын сан, удирдлага, төлөвлөлт нэгдмэл төвлөрсөн байх энэ зарчимтай бид нар уялдуулж авч үзсэн.

Дээр нь бол энэ босоо тогтолцоотой байгууллагуудын бусад хуулийн зохицуулалт, томилгоотой бол адилтгаж энэ томилгоотой холбоотой асуудлуудыг уялдуулж авч орж ирсэн. Хэлэлцүүлгийн шатанд гишүүдээс гарч байгаа саналуудыг бол бид нар бас ярилцаж, энэ асуудлыг шийдвэрлэх бололцоотой гэж харж байгаа.

Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх хэмжээ бол хумигдсан зүйл байхгүй гэж бол хэлж болно. Яагаад вэ гэхээр зэрэг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнүүд буюу төлөвлөлтөөрөө бид нар бүх асуудлыг үндсэнд нь цэгцэлж, базаж байгаа. Энэ концепциор авч үзэх юм бол энэ төлөвлөлтийг аймаг, нийслэлийн Засаг дарга нь боловсруулж, батлуулж, хэрэгжилтийг нь хангаж, хянаж, үнэлгээ өгөөд дахиад шинэчлэх, өөрчлөхтэй холбоотой бүх асуудлууд тухайн шатныхаа төлөвлөлт, дээд шатны төлөвлөлтдөө саналаа өгөөд ингээд хэрэгжилтийг нь хангах ийм нэгдмэл, төвлөрсөн зохицуулалт орж ирж байгаа учраас энэ хүрээнд бол бүх эрх нь байж байгаа. Асуудал, төлөвлөсөн төлөвлөлтийн дагуу цахим программаар асуудал шийдэгдээд, тэр шийдэл нь бол газрын асуудал эрхэлсэн аймаг, нийслэлийн байгууллага дээр шийдэгдээд явж байгаа нь бол Засаг дарга дээр шийдэгдэхгүй байгаа гэдгээсээ бол мэргэжлийн ийм шийдэл гарч байгаа учраас тэр байгууллага нь шийдээд хариуцлагаа хүлээгээд явах нь зүйтэй юм гэсэн ийм концепци орж ирж байгаа.

Тэгээд энэ дээр ямар нэгэн маргаантай асуудал үүслээ гэх юм бол дараа дараагийн шатны байгууллага, албан тушаалтан нь хүчингүй болгох ийм эрх хэмжээ нь байгаа учраас хяналт хариуцлага бол энэ дээр бололцооны тусгагдсан гэж бид нар үзэж байгаа.

Ашигт малтмалтай холбоотой асуудлаар хурлын эрх хэмжээ бас саяын хэлсний дагуу ерөөсөө ашигт малтмалын лиценз төлөвлөх асуудал нь улсын газар зохион байгуулалтын

жилийн төлөвлөгөөнд Засгийн газраар орж батлагдахад энэ суурь нь бол тавигдана. Том зургаараа бол улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд сууна, тэгээд улсын тухайн жилийн төлөвлөгөөнд суусан тэр ашигт малтмалын төлөвлөлт нь хэрэгжилтийн шатанд хэрэгжээд явна. Ингээд лиценз болсноос хойших асуудлууд бол Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагдана. Газрын ерөнхий хуульд бол зөвхөн төлөвлөлт буюу газар дээр яаж зохион байгуулж төлөвлөж, энэ бүс тогтоож “А” болон “Х” лицензүүд олгогдох уу гэдэг төлөвлөлтийнх нь асуудал л орж ирж байгаа. Тэрнээс хойших олгогдсоноос хойших асуудал бол газар дээр гэрээ байгуулснаас хойших бүх асуудал, ашиглалттай холбоотой асуудал бол Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагдаад явж байгаа.

Газрын маргаан таслах зөвлөл дээр бол товчхондоо хэлэх юм бол ер нь олон тооны маргаанууд энэ шүүх дээр нэлээн ачаалал үүсгэж байгаа. Жилд 13000 орчим маргаан захиргааны шүүх дээр байдгийн 3000 гаруй нь буюу 23.0, 24.0 хувь нь бол манай газартай холбоотой маргаан байдаг. Тийм учраас энэ маргааныг.../минут дуусав/

Г.Занданшатар: Тодруулж асууя Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Энэ хариултуудаас харахад ер нь хууль оруулж ирэхдээ энэ яамнууд, тэр сайдын зөвлөл дээрээ хэлэлцдэг юм уу, үгүй юу? Хариуцсан агентлагаараа нухуулж нухуулаад тэгээд л оруулж ирсэн хойноо ингээд л ичсэн хүн хүн ална гэдэг шиг л юм хариулаад суугаад байх юм. Энэ чинь ерөнхий хууль дээр

чинь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийн дагуу ч тэр, энэ орон нутгийн Иргэдийн хурал, Засаг даргын эрх мэдэл юу ч байхгүй. Эрх үүргийг нь заавал зааж өгөх ёстой байхгүй юу. Тэгэнгүүт төлөвлөгөө батална. Тэр дотор нь эрх, үүрэг нь цуг явж байгаа гээд худлаа, үнэн юм яриад суугаад байх юм. Та нар наадхыгаа өөрсдөө оруулж ирэхээсээ өмнө яам, агентлаг дээрээ энэ хуулийнхаа боловсруулалтыг нь жоохон анхаарч үзэж бай л даа. Тийм учраас энэ дээр бол Их хурлын даргаа энэ ажлын хэсэг байгуулж явахад нэлээн олон асуудлууд хэлэлцэх ийм шаардлагууд байгаа шүү. Энэ хууль дээр уншаад үзэх юм бол өнөөдрийн нийгэмд үүсээд байгаа маргааныг цэгцлэх энэ асуудлууд бол нэлээн орхигдсон.

Г.Занданшатар: 83. Сандагийн Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

С.Магнайсүрэн: Асуултад тодруулж хариулъя. Ер нь бол бид нар ажлын хэсэг байгуулаад нэлээн сайн, жил гаруй хугацаанд ажилласан. Бүх яамнуудтай доод тал нь 2-3 удаагийн уулзалт хийж, чиглэл чиглэлээр концепцоо тохирсон. 20-оод удаа бид нар бүсчилсэн болон төрийн бус байгууллагуудын оролцоотой хэлэлцүүлгүүдийг хийгээд 1000 орчим хүн, иргэд, судлаачид хамрагдсан ийм дүнтэй байдаг. Газрын маргаантай холбоотой асуудал энэ хууль гарснаар бид бол харин ч цэгцэлж шуурхай шийднэ гэж харж орж ирсэн. Газрын маргаан таслах зөвлөлийг бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд нь бид нар мэргэжлийн хүмүүсээр нь бүрдсэн орон тооны бус маргаан таслах зөвлөл ажиллаад богино хугацаанд шуурхай шийдэх ийм

бололцоог нь нээсэн. Иргэн эрхийнхээ дагуу энэ шийдвэрт гомдолтой байна гэвэл шүүхээр маргах энэ процесс нь бол нээлттэй байж байгаа. Энэ хуулийн төсөл батлагдсанаар харин ч газрын маргаантай холбоо.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Газрын тухай ерөнхий хууль орж ирж байна. Тэгээд Монгол Улсын Үндсэн хуулийн дараа орох Монгол Улсын хөгжилтэй холбоотой хөгжих үү, хөгжихгүй юу гэдэгтэй холбоотой маш том суурь хууль орж ирж байгаа. Тэгээд өнөөдөр Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэж байна. Энэ хуулийн шинэчилсэн найруулга хийх энэ аргумент, үндэслэлүүд чинь л сайн тодорхой харагдахгүй байгаа юм даа. Энэ үндэслэлүүдээ давтаад нэг хэлээд өгөөч.

Хоёрдугаарт нь энэ хууль дотор бэлчээрийн тухай асуудлыг тодорхой оруулж ирээгүйгээр оруулаад ирсэн нь ямар учиртай юм бэ? Энийг дахиад тодруулж хэлж өгөөч. Тэгээд л бэлчээр газар 2 чинь салшгүй холбоотой, маш том асуудал. Монгол улсын шинэ парламент бүрдсэнийхээ дараа жил болгон энэ бэлчээрийн тухай асуудлыг ярьдаг, тэгээд л шийдэхгүй ингээд хаячихдаг. Тэгээд сая энэ дундаас үгэндээ сонсож байхад бол энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дээр энэ бэлчээр ашиглалтын тухай хуулийн төслийг түлхээд л ингээд л хаяж байх шиг байна. Тэгэхээр энэ бол тийм бага асуудал биш шүү, энэ бол том асуудал гэдгийг хэлчихье. Мэдэхгүй, би л сонсоогүй юм байна. Малчдын төлөөлөл, тариаланчдын төлөөлөл, хөдөө орон нутгийн иргэдийн

төлөөллийг оролцуулж хэлэлцүүлэг хийсэн үү. Сонсогдоогүй. Тэгээд энэ хүмүүсийн хамгийн том эрх ашиг хөндөгдөх гэж байгаа хүмүүсийнхээ төлөөлөл оролцуулаагүй, хэлэлцүүлэг хийсэн чинь энэ гишүүдийн шүүмжилж байна таарч байна шүү дээ. Тэгээд энэ хуулийн төсөл нь улсын төсвийн дараа орж ирж байгаа нь цаг хугацааны дарааллын хувьд бол зөв л байх, тэгээд манай Төв аймгийн хувьд бол маш хүнд нөхцөлтэй байгаа. Хойноос ирээд хот минийх, хотонд ирээд хонь минийх гэдэг шиг маш их хүн амын төвлөрөл ирж байгаа, бүх зам, газар нутаг Төв аймгийн нутгаар дайрч гарч байгаа юм. Тэгээд энэ тойрсон сумуудтай бүгдтэй нь хилийн маргаантай. Тэгэхээр энэ дээр Төв аймаг, Улаанбаатар хот, Төв аймгийн Эрдэнэ сум 2-ын хоорондох маргаан дээр ирээд, нутгийн удирдлага нь ямар ч буруу байхгүй. Байгаа юу, байхгүй юу гэдгийг нь хариуцсан газрын дарга нь хэлээд өгөөрэй. Ингээд л тэлэх л оролдлогууд дандаа явж байдаг. Дээрээс нь энэ гишүүд хэлээд байна. Нэгжгийн тухай хуулиар багийн дарга, сумын Засаг дарга, иргэдийн эрх мэдэл гэж юм ерөөсөө байхгүй болсон шүү дээ. Худлаа, үнэн хуралдуулдаг, шат ахиулж авчирч байгаад л Засгийн газар дээр ямар ч эсрэг асуудал байсан шууд шийдээд явчхаж байгаа юм. Тэгэхээр энэ асуудал яаж орж ирж байгаа вэ?

Отгор нутаг гээд, отрын газар. Одоо мал өсчихсөн, отор оруулсан газар орсон аль аль нь дуусна. Жоохон газартай тэрнийхээ бэлчээрээ идээд л, тэгээд л 2-улаа хохирно. Энэ асуудал ер нь яаж орж ирж байгаа юм.

Иргэн Дорж гээд байлаа гэхэд энэ хүн хадлангаа хаанаас хадах вэ? Энэ асуудал яаж орж ирж байгаа юм. Тэгээд мал аж ахуй, газар тариалан 2 бол хосолж хөгжих нь бүр гарцаагүй болсон. Хуучных шиг тэр оторлоод бэлчээр яадаг асуудал байхгүй болсон. Тэгэхээр энэ хүмүүс дээр тэр өвөлжөөн дээрээ, өвөлжөөнийхөө хөлд нэг жоохон тариа, ногоон тэжээл тарьчих ийм боломж энэ хуульд байгаа юу.

Тэгээд ер нь шулуухан хэлэхэд малчдын өвөлжөө доорх газар, гэрийнх нь доорх газар өмчлөлд, морины уяа, жорлон энэ тэр чинь ер нь кадастрын гадна л байгаа шүү дээ. Сумын төвд шинээр, ялангуяа энэ залуучууд төвлөрөл сааруулна гээд байгаа энэ хүмүүс ямар нэгэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд газрын дуудлага худалдаа, суурь үнэ бол маш өндөр болсон. Энэний үнэ яг одоо хэд байна. Дуудлага худалдааны анх.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Сандагийн Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

С.Магнайсүрэн: Туваан гишүүний асуултад хариулъя. Шинэчилсэн найруулга бол зайлшгүй хийх шаардлага байсан.

Нэгдүгээрт бол 32 удаа өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт орсон байсан. Энэ оруулсан өөрчлөлтүүд дандаа бусад хуулиудыг дагасан төсвийн хууль юм уу, бусад өөр анхдагч хуулиудыг дагуулж өөрчилсөн өөрчлөлтүүдээс болоод, дээр нь 200 гаруй эрх зүйн актаар газрын асуудлуудыг нарийвчлан зохицуулсан. Энэ

зохицуулалтууд нь бол газрын хуулийн ерөнхий концепцийг ер нь алдагдуулахад хүргэсэн. Дээр нь 60 орчим давхардал, хийдэл, зөрчил байна гэсэн ийм Хууль зүйн яамны судалгааны үр дүн, дээр нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль баталсантай холбогдуулаад Иргэний хуулийн энэ суурь зарчимд газрын хуулийг нийцүүлж батлах шаардлагатай байна гэсэн ийм чиг үүргүүд өгөгдсөн. Энэ бүх зүйлүүдийг нэгдүгээрт харгалзсан.

Хоёрдугаарт, хүчин төгөлдөр үйлчилж байгаа газрын хуульд оруулсан өөрчлөлт бол 50 хувиас давахаар тийм хэмжээний өөрчлөлтүүд хийгдэхээр байсан учраас гарцаагүй шинэчилсэн найруулга болгож Газрын ерөнхий хуулийн төсөл орж ирж байгаа. 4 хуулийн төслийн хамт багцаараа орж ирж байгаа гэдгийг хэлье.

Бэлчээрийн зохицуулалт дээр бол түрүүн манайхан хариулсан. Гэрээгээр болон нийтээрээ эзэмшихээр байгаа. Гэрээ нь бол отрын бүс нутагт гэрээ гэрээлэхээр. Тэгээд отрын бүс нутгийн зохицуулалт нь болохоор сумын отрын бүс нутаг, сум дундын, аймаг дундын, улсын гэсэн ийм түвшний отрын бүс нутгууд байхаар, улсын отрын бүсэд болохоор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мал бүхий иргэнийг оруулж, гаргах энэ зохицуулалтыг хийхээр, аймаг дундынх дээр аймгийн Засгийн газар болон Засаг дарга нар шийдэхээр, сум дундынх дээр болохоор аймгийн дарга, суманд сумын дотоод юун дээрээ болохоор сумын дарга гээд шат шатандаа тухайн шатны Засаг дарга нь, дээд шатных нь Засаг дарга нь шийдэх ийм

зохицуулалтуудыг бид нар отрын бүс нутагтай холбоотой зохицуулалт оруулж ирсэн байж байгаа.

Хэлэлцүүлгийг бид нар бүх шатанд хийсэн. 21 аймагт манай газрын асуудал, газар барилгын асуудал эрхэлсэн нэгж маань манай агентлагтай хамтраад бүх аймагт сумдын төлөөлүүдийг оруулаад хийсэн. Бид бол, яам бол бүсчлээд хийсэн. Мөн төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудын түвшинд хэлэлцүүлэг хийж байж энэ төслийг оруулж ирж байгаа.

Г.Занданшатар: 85.

А.Энхманлай: Туваан гишүүний асуултад хариулъя. Төв аймгийн 7 сумын асуудал байгаа. 7 сумын хилийн цэс...

Г.Занданшатар: Өөрийгөө танилцуул. Протоколд үлдэнэ. Нэрээ дандаа хэлж бай.

А.Энхманлай: Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга Энхманлай. Төв аймгийн 7 сумын асуудал эдийн засгийн маргаантай байгаа. 1982 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Нийслэлийн хилийн цэс, Төв аймгийн сумуудын хилийн цэс батлагдсан. Тэгээд 1996 оны Ардын Их Хурлын, Улсын Их Хурлын тогтоолоор Нийслэлийн хилийн цэсийг өөрчилж, өөрөөр хэлбэл газрын хэмжээг нь нэмэгдүүлж Төв аймгийн 7 сумын газарт өөрчлөлт орох ийм шийдвэр гарсан байгаа. Тэгээд энэтэй холбогдуулаад тухайн Улсын Их Хурлын тогтоолын 2 дахь хэсэг дээр хилийн цэс өөрчлөгдөж байгаа Төв аймгийн сумуудын шинэчилсэн хилийн цэсийг Улсын Их Хуралд танилцуулж

шийдвэрлэхийг бол Засгийн газарт үүрэг болгосон. Гэтэл энэ ажиллагаа хийгдээгүй 1996 онд, 1998 онд хийгдсэн боловч зарим сумдын асуудал орхигдсон. Эндээс болоод өнөөдөр одоо Төв аймгийн Эрдэнэ сум, нийслэлийн Налайх дүүргийн хооронд хилийн цэсийн тогтоолууд нь 2-улаа давхацсан хүчин төгөлдөр байгаагаас шалтгаалж маргаантай асуудал үүссэн. 2 бие дээрээ дамжуулж, давхардуулж газар олгох ийм асуудлууд гарсан. Энийг шийдэх зорилгоор Засгийн газраас Барилга, хот байгуулалтын яам дээр ажлын хэсэг гараад аймаг орон нутгуудын төлөөллийг оролцуулаад ажиллаж байгаа. Удахгүй бас энийг Засгийн газраар танилцуулж, хэлэлцүүлээд Их Хуралд орон нутаг, нийслэлийн хилийн цэсийг шийдэх талаар асуудал оруулж ирж, шийдүүлэхээр бид нар төлөвлөж байна.

Өвөлжөө, хаваржааны газрын тухай асуулаа. Малчдад бол өвөлжөө, хаваржааны зориулалтаар 1 га хүртэл хэмжээний газрыг эзэмшүүлнэ. Энэ хуулийн төслөөр. Мөн тухайн өвөлжөө, хаваржааныхаа дэргэд 0.1 га газар дээр тэжээлийн ургамал тарих газрыг үнэгүй эзэмшүүлэхээр заасан. 5 га хүртэл газрыг мод үржүүлэх, ойжуулах зэрэг зориулалтуудаар мөн үнэгүй, хүсэлтийнх нь дагуу шийдвэрлэхээр энэ хуулийн төсөл дээр тусгаж өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл энэ асуудлуудаар малчдын мал аж ахуй эрхлэх, аж ахуй эрхлэх газрын асуудлыг шийдэхдээ боломжийг бол олгож өгсөн.

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар газар авахаар дуудлага худалдаанд оролцохоор газрын суурь

үнэ бол 1 га газар авахад 4.8 сая төгрөгийн үнэтэй үнэлгээ гарч байгаа юм. Ер нь бол Засгийн газраас 2 жил тутам улсын хэмжээний газрын суурь үнийг батална. Энэ дээр үндэслээд аймаг, орон нутгууд өөр өөрсдөө Иргэдийн хурлаараа газрын суурь үнээ өндөрсгөж багасгах эрх хэмжээ нь энэ хуулиар олгогдож байгаа. Ингэхээр цаашидаа газрын үнийг бол бодитой тогтоож, иргэдэд газар авч ашиглах нөхцөл бололцоог шинэ хуулиар бас нэлээн түлхүү нэмэгдүүлж өгсөн.

Хадлангийн газрыг бол бид бүхэн иргэдэд эзэмшүүлэхээр заасан байгаа. Төлөвлөлтөөр олгоно. Хадлангийн газрыг мөн иргэдийн хүсэлтийн дагуу олгоно. Хадлангийн газраас бол газрын төлбөрийг чөлөөлж өгч байгаа зэрэг хөнгөлөлтүүд өгч байгаа.

Г.Занданшатар: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Сая тэр сум дээр гэлтгүй, ер нь яг сумын төвд залуучууд шинээр дэлгүүр, гуанз, үйлчилгээний газар, хүлэмж барих газар авах дуудлага худалдааны анхны үнэ аль ч сум дээр энэ аягүй хүнд асуудал болчихоод, газрын дуудлага худалдааны анхны үнэ их өндөр болчихоод байгаа юм, энэ яг хэд байна, цаашидаа энэ хуульд ямар бодлого байна.

Хоёрдугаарт энэ хот суурин газрын иргэд чинь бол зуслангийн газар энэ тэр гээд газрууд авч болдог тийм ээ. Хотоос гадуур. Хөдөө, орон нутгийн иргэд, малчид, тэдний хүүхдүүд төв суурин газар, аймгийн төв, Улаанбаатар хот руу орж ирэхэд газар авч болох уу? Яагаад энэ ялгавартай байдал нь байгаа,

тэгэхээр энэ хуульд энэ асуудал яаж орж ирж байгаа вэ.

Г.Занданшатар: 85.

А.Энхманлай: Тодруулга хариулт өгье. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга Энхманлай.

Монгол Улсын иргэдийн 19 хувь нь өнөөдрийн байдлаар бол газар өмчилж авсан байна. Тэгэхээр бид бүхэн 80 гаран хувийнхаа иргэдэд шинээр газар өмчлүүлэх ийм асуудлыг шийдэх талаас нь энэ хуулийн төслийг боловсруулж, оруулж ирсэн байгаа. Өөрөөр хэлбэл өнөөдөр газраа авч чадаагүй байгаа иргэд аль болох газрыг олгох, энэ хүмүүст зориулсан хөнгөлөлтүүдийг үзүүлэх тал дээр бол энэ хуулийн төсөлд шинэ зохицуулалт орж ирсэн. Өөрөөр хэлбэл зорилтот бүлэг гэж нэрлэж байгаа. Өөрөө газар авч чадаагүй хүмүүс. Энд бол заавал зорилтот бүлгийн төлөөллүүдэд газар олгоно. Энд бол 35 хүртэл насны залуу гэр бүлүүд, гэр бүлийн гишүүн, мөн 0-18 насны 4 болон түүнээс дээш хүүхэдтэй эцэг эхчүүд, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон түүнийг халамжилдаг иргэн.../минут дуусав/

Г.Занданшатар: Тодруулаад дараа нь хариултыг нь өгчхөөрэй. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Энэ маш чухал хууль. Ер нь ноцтой олон асуудал хөндөгдөж болох ийм хууль. Тийм учраас энэ хуулийг хэлэлцэхэд Засгийн газрын зүгээс ч Их Хурлын зүгээс анхаарах ёстой. Одоо яг энэ асуудлыг оруулж ирж байгаа сайд

гэж байна уу энэ танхимд. Сайд нь байна уу? Ер нь Их Хуралд хариулахад бол Төрийн нарийн бичгээс доошгүй албан тушаалтнууд хариулж байх ёстой. Сүүлийн үед ер нь Засгийн газрын төлөөллүүд Ерөнхий сайдын мэдээлэл дээр ч тэр, хаана ч тэр, ер нь яг байх ёстой хүн нь оролцохоо больсон байна. Их Хурал энд анхааралтай хандах хэрэгтэй Их Хурлын дарга аа, та энийг зохион байгуулж байгаа юм. Газрын хууль ярьж байна шүү дээ бид нар. Тэгээд энэ газрын хууль дээр бол Монголд, Монголын төрд байгаа ганц сайн юм бол төрийн мэдэлд газрыг байлгаж байгаа асуудал. Гаднынхан ч гэсэн тэгж ярьж байгаа юм. Танайд харин ганц л сайн юм байна. Тэр чинь бол төрийн мэдэлд газар байгаа гэж. Бусад улс оронд яадаг вэ гэхээр хувийн эзэмшилд байдаг. Тэгээд гаднын мөнгөтэй нөхрүүд орж ирээд нөгөө газрыг нь авчхаад байдаг. Японд ч гэсэн ийм асуудлууд үүсчхээд байгаа юм байна лээ шүү дээ. Аль үржил шимтэй газрыг нь нөгөө гаднынхан орж ирээд авчхаад байдаг. Мөнгөтэй, баян газрын улсууд. Манайд харин одоохондоо, хараахан тийм юм байхгүй.

Гэтэл 2019 онд Үндсэн хуулийн өөрчлөлтөөр манай Их Хурлын дарга нэлээн оролцсон. Төр нийтийн өмч гэж ийм сонин заалт оруулж ирсэн байхгүй юу. Төр нийтийн өмч гэж. Ингээд Үндсэн хуульд энэ заалт орсон. Одоо Иргэний хуулийн 4 дээр юу гэж байна гээч төр, нийтийн өмчийг Монгол Улсын иргэний харьяалалгүй, энд байж байгаа гадаадын иргэн эзэмшиж, ашиглаж болно гээд оруулчихсан байхгүй юу. Одоо энэ хууль дээр ялангуяа тэр нөгөө үржил шимтэй газар газар, тариалангийн нөхцөл ч байдаг юм уу, тариа ногооны

чиглэлээр ашиглахаар тэр узуфрукт ч гэнэ үү ийм нөхцөлөөр гадаад хэлтэй нөхцөл заагаад өгчихсөн. Ингээд эзэмшүүлээд, ашиглуулна гэж байгаа юм. Тэгээд Иргэний хуулиараа гаднын хүнд энэ нээлттэй байхгүй юу. Нээлттэй. Тэгээд яваандаа бол үржил шимтэй газар нутгуудаа бол гаднынханд алдаж болох ийм боломж энд гарчхаад байгаа юм. Иргэний хуулийн. Тийм учраас би Их Хурлын даргад хандаж чиглэл өг өө. Энэ хуулийг, Газрын хуулийг хэлэлцэхэд Иргэний хуулийн гадаадын иргэн, төрийн эзэмшлийн, нийтийн эзэмшлийн газрыг ашиглаж, эзэмшиж болох энэ заалтыг байхгүй болгох ёстой. Тэгж байж энэ хуулийг давхар явуулах ёстой. Газраа алдаад эхлэх юм бол эх орны тусгаар тогтнол ганхаж эхэлнэ шүү. Энийг би хэлье.

Хоёрдугаарт, бэлчээрийн асуудал их ярьж байна. Зөв. Сайн юм орсон байна лээ. Бэлчээр дээр бас тэжээл ногоогоо тарих ийм боломжийг нь нээж өгсөн байгаа нь сайн. Засгийн газар журмаар зохицуулах юм байна гэж би ойлгосон. Тэр 94.15 дээр. Та нар хуулийн заалтаараа болохоор ингэчихсэн байгаа юм л даа. 95.2.3-т өвөлжөө, хаваржааны бэлчээр рүү мал оруулахгүй байна шүү гэсэн байгаа юм. Тэгсэн мөртөө хариуцлагыг нь орхигдуулчихсан. Зөрчлийн хуулиар зөвхөн хадлангийн газар луу мал оруулбал гээд ингэчихсэн. Өвөлжөө, хаваржаа руу нь бас оруулбал тэр зөрчлийн хуулиар торгох заалтыг хэлэлцүүлгийн явцад бий болох ёстой. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх мэдэл дээр бүрхэг болсон юм байна лээ. Ялангуяа тэр газрыг орон нутагт шилжүүлэхэд 3 нөхцөл тавьсан байгаа юм. Энэ 3 нөхцөл өмнөхөөсөө

дордсон уу, 3 нөхцөлд л сумын Иргэдийн хурал бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Магнайсүрэн. Сандагийн Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга.

С.Магнайсүрэн: Даваасүрэн гишүү асуултад хариулъя. Барилга хот байгуулалтын яам Магнайсүрэн. Узуфрукттай холбоотой асуудал бол хөдөө аж ахуйн салбарт, ялангуяа энэ газар тариалан, жимс жимсгэнэ, бусад хүнс, хүнсний ногооны чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээд, ашиг олох энэ чиглэлийг нь бол тодруулж гаргаж узуфруктээр Иргэний хуулийн хүрээнд узуфрукт эрхээр бол газар эзэмшиж, ашиглахаар орж ирж байгаа. Энэ бол хязгаарлагдмал эрхээр газар шилжүүлж, ашиглаж байгаа энэ эрхийн зохицуулалт дээр бид бол гадаадын иргэн, харьяалалгүй хүн, дээр нь нэмээд энэ хууль дээр бүр тусгайлсан заалт оруулж, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид бол энэ узуфрукттэй холбоотой зохицуулалт хамаарахгүй байхаар нэлээн чангаруулж байна. Иргэний хуульд бол ерөнхий зохицуулалт байгаа. Бид бол нарийвчилсан энэ хуулиараа бол газартай холбоотой зохицуулалт хийж байгаа тусгайлсан энэ хуулиараа бол гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол газрыг зөвхөн ашиглана. Ашиглахдаа 5 жилээр ашиглана гээд ашиглах зохицуулалтуудыг нь бол өмнө нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиасаа илүү чангаруулж, илүү хайрцаглаж орж ирсэн гэж бол ойлгож болно. Энэ яагаад гэвэл хэлэлцүүлгийн шатанд нэлээн олон саналууд энэ чиглэлээр гарч ирсэн

учраас тусгайлж бид нар анхаарсан байж байгаа.

3 нөхцөлөөр орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар бол оруулж ирсэн. Энэ нь болохоор зэрэг тодорхой, тухайн орон нутгийн хэрэгцээнд ийм 3 нөхцөл байх бололцоотой юм байна гэдгийг нь бас хэлэлцүүлэгтэй холбоотой. Дээр нь олон бусад байгууллагуудын саналыг үндэслэж бид нар авсан. Улсын тусгай хэрэгцээний газар, орон нутгийн тусгай хэрэгцээний газар давхцаад асуудал үүсгээд өнөөдөр төвөгтэй байдал үүсдэг байсан. Одоо бол орон нутаг, улсын тусгай хэрэгцээний газартай давхцуулж авахгүй. Улс орон нутгийн тусгай хэрэгцээтэй давхцуулж авсан тохиолдолд орон нутгийн тусгай хэрэгцээг тэр шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд хүчингүйд тооцохоор, давхцалгүй байхаар асуудлыг зохицуулж оруулж ирсэн байгаа. Хэлэлцүүлгийн шатанд, тэгэхдээ бид нар энэ дээр тодорхой саналуудыг авч үзэхэд бол бэлэн байгаа.

Хариуцлагатай холбоотой асуудлуудыг бид санал нэг байна. Бид нар энийг хэлэлцүүлгийн шатанд анхааръя.

Г.Занданишатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

Ц.Даваасүрэн: Тэр газар гадаадын иргэн эзэмшиж, ашиглах асуудал чинь иргэний суурь хууль дээр байгаа шүү. Тийм учраас энэ хуулийн асуудлыг хамт явуулахгүй бол болохгүй. Ялангуяа энэ дээр чинь төр, нийтийн өмчийн газар байна гээд ингээд орчхож байгаа шүү дээ. Тийм л учраас би хэлээд байгаа юм. Энэ

хуулийг давхар, хамтад нь шийдэж өгөхгүй бол болохгүй. Суурь хуультай зөрчилдсөн юм болчих гээд байна гэж.

Би нэг зүйл асуусан шүү дээ. Яагаад бэлчээрийн газрын зориулалтаа тусгай хэрэгцээнд авч болохгүй гэсэн юм? Тэр заалтыг нь нэлээн сайн тодотгож өгөх ийм шаардлага байгаа юм биш үү? Бэлчээрийнхээ зориулалтаар шүү. Малын тусгай, та нар ус энэ тэр гэсэн тиймэрхүү юмнууд оруулчихсан байна лээ л дээ. Тэгэхээр тэрийгээ хуучнаасаа дордуулсан уу гээд байна шүү дээ. Тусгай хэрэгцээнд авахад хуучин нээлттэй байсан, одоо бол хязгаарлаад зөвхөн 3 нөхцөлөөр авна гээд. Орон нутгийнхны чинь ганц өөрсдөө шийдэж энэ уул уурхайгаас зугтаж байгаа юм бол тусгай хэрэгцээнд авч байгаа юм байгаа байхгүй юу. Энийг нь ингээд байхгүй болгоод хаячих юм бол энэ уул уурхай.../минут дуусав/

Г.Занданишатар: Магнайсүрэн. 83.

С.Магнайсүрэн: Тодруулж хариулъя. 3 үндэслэлээр тусгай хэрэгцээнд авах энийг бол бид нар илүү тодорхой болгож өгсөн гэж ойлгож байгаа. Энэ дотор бол сум дундын отрын бэлчээр, хадлангийн талбайн зориулалтаар бол авах гээд бэлчээртэй холбоотой юмыг бол бүхэлд нь биш. Энийг бид нар бас хэлэлцүүлгийн шатанд анхааръя гишүүн ээ.

Ер нь бол отрын бэлчээр, хадлангийн талбайн зориулалтаар бол авах гэсэн ийм концепц бол орж ирсэн байгаа. Тодруулаад бид нар бас авч үзье.

Г.Занданишатар: Даваасүрэн гишүүн 1 минут.

Ц.Даваасүрэн: Та нар энэ дээр нэг тийм арга заль хэрэглэчихсэн байгаа байхгүй юу. Зөвхөн отрын бэлчээрийг л гэчихсэн байгаа. Хадлангийн талбай 2-ыг л гэчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр та нар малын бэлчээрийг нь хаячхаад байгаа байхгүй юу. Тийм учраас хэлэлцүүлгийн явцад энийг заавал шийдэх хэрэгтэй. Тэгж байж орон нутаг тусгай хэрэгцээндээ авна. Тэгэхгүй сум дундын отрын бэлчээрийг гээд ингэчихсэн. Тэгэхээр чинь тусгай хэрэгцээнд зөвхөн тэр газар, отрын газрыг л бэлчээрийн газрыг л болгочхож байгаа байхгүй юу. Сум дундын шүү, бүр сум дундын. Тийм учраас энэ бэлчээрийн газрыг гэдэг үгийг заавал оруулах хэрэгтэй. Тэгэхгүй бол ингээд л уул уурхай сэндийчсэн ийм юм бол болно. Хөдөө, орон нутагт наад хууль чинь асуудал үүсгэн. Тэгэхээр энэ заалтыг малын бэлчээр гэдгийг ингэж оруулж шийдэхгүй бол болохгүй гэдгийг би хэлье. Хэлэлцүүлгийн явцад энэ ажлын хэсэг Их хурал бас анхаараарай гэдгийг би зориуд наад 3 заалт чинь би дордуулсан уу гэж асуугаад байгаа шүү дээ, дордуулсан уу гэж. Дордуулчихсан байгаа байхгүй юу. Бэлчээрийг зөвхөн сум дундын.../минут дуусав/

Г.Занданишатар: Магнайсүрэн хариулъя. 83.

С.Магнайсүрэн: Хэлэлцүүлгийн шатанд бид анхааръя. Ажлын хэсэг дээр анхааръя.

Г.Занданишатар: Нэг зүйл тодруулаад хэлчихье. Магнайсүрэн, энэ газрын улсууд ч гэсэн. Төрийн

өмчийн улсууд ч гэсэн. Даваасүрэн гишүүн ч гэсэн нэг зүйл анхаарах хэрэгтэй.

Үндсэн хуулийг бол бид дээдлэх ёстой. Тэгээд Чимид гуай энэ төрийн нийтийн өмч гэдэг тодорхойлолтыг оруулсан. Газар ард түмний өмч байх баялаг бол төрийн ба орон нутгийн өмчийн хууль, Газрын тухай хууль хэлэлцэж байхад зориуд хэлсэн байдаг юм. Тэр нь юу вэ гэхээр төр өөрийн өмч гэж өөрийн өмчид байдаг машин тэрэг, байшин барилга шиг хувьчлаад, эзэмшүүлээд, өөрсдөө шийдвэр гаргаад ингээд захиран зарцуулаад байх, Засгийн газарт шийдвэр гаргаад явж болохгүйн тулд заавал Улсын Их Хурлаар шийдвэрлэдэг өмчийг төрийн нийтийн өмч, бүх ард түмний харьяалалд байдаг, ард түмний төлөөлж шийдэх өмчийг төрийн нийтийн өмч гэж хэлнэ гэж. Өмнө ч гэсэн Эрдэнэтээс авхуулаад олон асуудлуудыг Улсын Их Хурлаар оруулахгүйгээр Засгийн газрын түвшинд шийдвэрлэж байсан ийм практик байсан учраас төрийн нийтийн өмч гээд. Тэгээд бүр оросоор /государственная общественная собственность/ гээд англи, оросоор нь хэлж байгаад энэ хуульд хийчихсэн байгаа. Протокол унших хэрэгтэй. Ордон бол жишээлбэл төрийн өөрийн өмч. Энэ байшин барилга нь, харин ордны доор байгаа энэ газар нь бол төрийн нийтийн өмч буюу бүх ард түмний өмч байна гэсэн Үндсэн хуулийн зарчимтай нийцүүлж ингэж Чимэд гуайн тайлбарласнаар тодотгосон. Тэгэхгүй бол ингээд нийтийн өмч гээд эзэнгүйдүүлэх, аль эсвэл төрийн өмч гээд зөвхөн Засгийн газар ч юм уу түвшинд шийдвэр гаргадаг, энэ стратегийн орд газруудыг эзэмшүүлдэг, ашиглуулдаг, энэ хариуцлагагүй байдлыг засахын

тулд Чимэд гуай бүр тэр үед тодруулж хэлснийг Үндсэн хуульд тэгж төрийн нийтийн өмч гэж тодруулсан юм байгаа шүү. Түүнийг заавал өөрөөр хэлбэл төрийн ба орон нутгийн өмчийн хуульд байгаа, Газрын хууль дээр байгаа тэр заалтуудыг ойлгож, Магнайсүрэн дарга ч гэсэн, манай гишүүд ч гэсэн ойлгож, энийг хэрэглэх хэрэгтэй. Хуулиа зөв хэрэглэх хэрэгтэй шүү.

Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Би 4 асуулт байгаа юм.

Нэгдүгээрт, энэ хот байгуулалтын хуультай хэр уялдсан эсэхийг нь асуучихмаар байна. Ерөнхий төлөвлөгөөгөө хот байгуулалтын яам, нийслэл гээд л батлаад явчихдаг. Тэгээд явцын дунд зориулалтыг нь өөрчлөөд анх сургууль, цэцэрлэг гэж байсан бол тэнд чинь 10, 20 давхар байшин бариад явж байдаг. Хотхон гэж төлөвлөөд дотроо сургууль, цэцэрлэгтэй хотхон гэж төлөвлөөд, тэгээд сургууль, цэцэрлэг байхгүй болоод л үлдсэн. Сүүлдээ бол дан орон сууцны байшин болоод үлдэж байдаг. Энийг хэрхэн яаж зохицуулж байгаа вэ. Бодит жишээ бол энэ олонд алдаршчихаад байгаа тэр авлигал хороолол гээд л байдаг. Анх бол усан парк гээд төр байгууламж барихаар ерөнхий төлөвлөгөөндөө тусгасан юм байна лээ шүү дээ. Тэгээд үр дүнд нь болохоор усан парк гэдэг хотхон барьчихсан. Манай Баянгол дүүргийн 13 дугаар хороо дээр бол анх 3, 4 давхар соёлын, номын сан барина гэсэн зориулалтаар, хими цэвэрлэгээ барина гэсэн зориулалтаар газар аваад л одоо тэнд 16 давхар байшин

барьж байна. Нийслэл рүү бичиг явахаар бүх юм нь зөвшөөрөлтэй, стандартын дагуу өгсөн ийм хариу өгөөд байдаг. Тэгээд ерөнхий төлөвлөгөө солих, энэ зориулалтыг нь өөрчлөх асуудлаар ямар хязгаарлалтай байгаа вэ. Энийг зохицуулалт нь хэрхэн яаж хийж байгаа вэ гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт, хяналт шалгалтыг хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гээд. Ингээд газар чөлөөлдөг, тэгээд нөгөө газар чөлөөлснийх нь дараа иргэд нь ч байдаг юм уу, аж ахуйн нэгжүүд ч байдаг юм уу газраа ингээд сунгаад, сунгаад барьчихдаг хашаагаа. Тэгээд тэр газрыг нь чөлөөлдөг ч үгүй, хашааг нь хойш нь нүүлгэдэг ч үгүй, нөгөө хүний өмч гээд халдаж чаддаггүй. Энийг хэрхэн яаж хэрэгжүүлэх талаар асуучихмаар байна.

Тэгээд энэ хуультай хамт судалгаанууд ерөөсөө тараагдсангүй. Юун дээр үндэслэж оруулж ирж байгаа нь тодорхой бус байгаад байгаа юм. Судалгаануудаа бид нарт тарааж өгмөөр байна.

Дөрөвдүгээрт, сая Даваасүрэн гишүүний яриад байгаа ч гэсэн тэр төрийн нийтийн өмчийг ашиглах гэдэг үгийг ашиглах гэхээр л гадаадынханд газар өгөх гээд байгаа юм шиг л ойлгогддог. Эсвэл нөгөө байгалийн баялгаа гадаадынханд өгөх гээд байгаа юм шиг ойлгодог. Тэгэхээрээ тэр нэр томьёо дээрээ жоохон салгаж оруулмаар байна. Яг нөгөө газрынхаа хууль дээр. Ашиглах гэдэг үгийг гаднын иргэнд бол яаж, дотоодын иргэд, аж ахуйн нэгжүүд яаж тэр нэр томьёог нь хэрэглэх юм тэрийгээ нэг тодорхой болгочихмоор байна.

Сүүлийн асуулт бол үндсэндээ ингээд л хараад байхаар нэг бол эрх мэдэл булаацалдсан сум, дүүрэг, баг, нийслэлд хэн газар олгох юм гэсэн эрх мэдлийн л маргаан яваад байна л даа. Мөн энэ малд зориулсан хууль ч юм шиг яригдаад байгаа юм. Энэ чинь бол эдийн засгийн суурь хууль шүү дээ уг нь бол. Ингээд сонсоход үндсэндээ малчид бол малд зориулсан газар нь бол бүгдээрээ үнэгүй юм байна. Бэлчээр нь үнэгүй юм байна, хадлангийн газар нь үнэгүй юм байна, тариалан нь үнэгүй юм байна, мод суулгах зориулалтаар бас үнэгүй газар өгч байгаа юм байна. Хотын иргэн, хөдөөгийн орон нутгийн иргэн 2-ын хооронд яагаад ийм ялгавартай хандаад байдаг юм бэ? Адилхан л аж ахуй эрхэлж яваа хүмүүс шүү дээ. Яагаад хотын иргэд аж ахуй эрхлэх болохоороо 1 метр квадратаас газрын төлбөр төлөөд, орон нутгийн иргэд болохоор нэг ч төгрөг төлдөггүй юм ер нь. 80 сая малтай Монгол Улс өнөөдөр хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, малын гаралтай бүтээгдэхүүнээр бол үндсэндээ 300 сая доллар л олж байна. Экспортын бүтээгдэхүүн. Нөгөө ноолуураар самнаж ноолуураа л гаргадаг. Манайхтай яг ижилхэн Шинэ Зеланд 60 сая малтай.../минут дуусав/

Г.Занданшатар: Эхлээд хариултаа авчих. Хариулт хангалтгүй бол. 82.

Ц.Баярбат: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Баярбат.

Би таны эхний асуултад хариулт өгье. Хот байгуулалтын тухай хуулийг бас хуулийн төслийг боловсруулаад Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа. Тэгэхээр Газрын хуулийн төсөлтэй хамтатгаж ажлын хэсэг дээр нэгтгэж ярихаар төлөвлөгдөж байгаа. Ер нь 2 өргөн барьсан хуулийн төсөл дээр бол хоёул дээр нь олон улсынхаа жишигийн дагуу хот, газар ашиглалтын бүсчлэл, хот байгуулалтын бүсчлэлийг бол төрлүүдийн нэг болгож өгсөн. Нийтдээ 9 төрлийн бүсчлэлийг бол тодорхой зааж өгсөн. Манайх бол төлөвлөлт хийгээд, төлөвлөлтийг газар дээр нь хэрэгжүүлэх дээр мөрддөг энэ бүсчлэл маань алдагдсанаас болоод газар дээр өөрийг, хот байгуулалт дээр өөр ийм бүсчлэл мөрддөг болсноос зөрж, энэ маань ашиглалт, барилгажилт 2 дээрээ алдаа зөрчлүүд гаргасан ийм юм байгаад байгаа юм. Тийм учраас энийг нэгдүгээрт бүсчлэлийн хувьд бол бид нар ижил болгож нэгтгэж байгаа.

Хоёрдугаарт, энэ бүсчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм гарах ёстой байдаг. Энэ дүрмийг бас хоёуланд нь Нэгдүгээрт бол Засгийн газар энэ дүрэмд газар ашиглалтын шалгуур, шаардлагыг тогтоож өгөхөөр, аймаг, нийслэлийн хувьд бол Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ 2 бүсчлэлийн дүрмээ тус тусад нь одоо ингээд дүрмүүдийг нь баталж, мөрдүүлэхээр заачихсан байгаа. Гол нь энэ бүсчлэлийн дүрэм дээр юу тавигддаг вэ гэхээр тухайлбал, барилга байгууламж барих газар дээр ямар шал талбайн харьцаа байх ёстой вэ гэдгийг нь бүр нарийн тогтоогоод өгчихнө. Жишээлбэл, олгогдсон газрын хэдэн хувьд нь

барилга барих вэ, 30 хувьд нь барина гээд, тэр 30 хувь дээр нь шал талбайн харьцааг нь бүр тусгайлсан мэргэжлийн нэр томъёогоор тооцож гаргаж ирдэг. Тэгэхээр өндөр нь хэд байх вэ, талбай нь хэд байх вэ гэдэг нь харьцаагаараа жишээ нь 50 хувь байна, 20 хувь байна, 10 хувь байна гээд бүс бүр дээр өөр өөр тогтоогдоно. Орон сууцны бүс дээр нэг өөр, үйлдвэрлэлийн бүс дээр нэг өөр, зуслангийн бүс дээр өөр гэдэг ч юм уу, ийм байдлаар нэлээн нарийвчилж ингэж зохицуулахаар хуулиудыг харилцан уялдуулж боловсруулсан байгаа.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Сая бас асуултаа бүрэн, сайн асууж чадсангүй. Монгол Улс бол 80 сая малтай гээд ярьж байна. Тэгээд бэлчээр нь үнэгүй байдаг. Шинэ Зеландын хувьд бол 60 сая малтай мөртөө жилийн экспортоос олж байгаа орлого нь 3-4 тэрбум доллар байдаг. Тэгээд энэ бэлчээр, бусад юунууд чинь үнэ төлбөргүй байгаад байхаараа зүгээр тооны хойноос л хөөцөлдөөд байна шүү дээ. Чанарын хойноос хөөцөлдөхөө больчихлоо. Эрчимжүүлсэн аж ахуй эрхлэхгүй байна. Тэгээд зүгээр тооноос хөөцөлдөөд л бид нар хавар болонгуут манай гишүүд чинь бүгдээрээ уралдаад л, очоод л нөгөө мянгат малчны шагналуудыг нь гардуулаад эхэлчихдэг. Иргэд чинь нөгөө үнэ төлбөргүй болохоор чинь л энэ эдийн засагт чинь өөрчлөлт ерөөсөө орохгүй шүү дээ. Чанар луугаа ерөөсөө шилжихгүй байна. Тэгээд орж ирж байгаа хууль нь дахиад л яг тэрийгээ л дэмжсэн л хууль орж ирээд байна л даа. Энийгээ тодорхой

хэмжээний бага ч гэсэн хамаагүй малаар нь ч гэсэн хамаагүй татвар авдаг болохгүй бол энэ малын даац.../минут дуусав/

Г.Занданшатар: Бэлчээрийн хураамж, татварын асуудал. 85.

А.Энхманлай: Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга Энхманлай. Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Түрүүний асуулт дээр дурдагдсан газрын төрийн хяналт ямар шатанд тавигдах вэ гэж байгаа. Тэгэхээр ямар ч байсан энэ хууль батлагдсанаар газрыг зориулалтыг өөрчлөх, зориулалтын бусаар барилга, байгууламж барих, Газрын тухай хууль, дүрмийг зөрчсөн тохиолдолд хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэх, хэн энэ хариуцлагыг оногдуулах юм, яаж арга хэмжээ авах юм гэдгийг бол нарийн зохицуулсан. Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллагын бүрэн эрхийг энэ хууль дээр тусгаж өгсөн байгаа. Мөн орон нутгийн удирдлага, Засаг дарга, иргэдийн Хурлын бүрэн эрх, мөн мэргэжлийн байгууллагуудын чиг үүргийг бас зааж өгсөн. Хэрвээ энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтан байх юм бол Эрүүгийн хуулиар шийдэхээргүй бол Зөрчлийн хууль, мөн бусад холбогдох хууль журмаар бол шийдвэрлэнэ гээд заасан байгаа. Хамгийн гол зохицуулалт.../минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчих. Товч, тодорхой хариул. 85. Энхманлай.

А.Энхманлай: Газрын санд хамгийн гол нь төрийн бус байгууллагуудын оролцоог хяналт тавиулахаар хуульчилж оруулж ирсэн байгаа. Төрийн бус байгууллагууд энэ

газартай холбоотой гарч байгаа шийдвэр, газрын мэдээллийн сан дээр нээлттэй мэдээлэл дээрээс хяналт тавих чиг үүргийг 104 дүгээр зүйл дээр бол тусгайлан бүр зааж өгч оруулсан. Тэгэхээр бол иргэд энэ газартай холбоотой холбох шийдвэрүүд дээр бол хяналт тавиад ажиглах бүрэн бололцоотой болсон.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Газрын тухай ерөнхий хууль орж ирж байна. Тэгээд энэ бол эдийн засгийн суурь хууль, төвлөрлийг сааруулах, орон нутгийг хөгжүүлэх гол хууль гэж харж байгаа. Энэ шинэчилсэн найруулгыг орж ирж байгаа гол зорилго бол нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцад газартай холбоотой олон талт харилцааг хуучин хуулиар зохицуулахад хүндрэлтэй болж, тус хуулийг шинэчлэх, боловсронгуй болгох цаг үе, нийгэм, эдийн засгийн шаардлага тулгараад байна гэж оруулж ирж байгаа юм. Гэтэл бодит нөхцөл байдлаараа яг энэ иж бүрэн цогцоороо орж ирэхгүй байна гэж харж байгаа юм. Энийг хэлэлцэх нь бол зүйтэй, гэхдээ өнөөдөр Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт тулгараад байгаа гол зүйл бол газартай холбоотой байгаа. Монгол хүн нэг хүнд оногдох газраараа дэлхийд нэгт явдаг ч гэж ярьдаг. Өнөөдөр Улаанбаатар хот 4 уулынхаа дотор багтахгүй болчихоод байна. Энийг аймаг, сумдад нь хуваарилах, хөгжлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тархаах, дархлааг нь ижил түвшинд авчрах гол хууль гэж ингэж харж байгаа юм.

Гэтэл зарим зүйлүүд бол энд ер нь огт эсрэгээрээ орж ирж байна. Зарим зүйлийг бол анхаарах ёстой гэж бодож байна. Би бол энэ хуулийг Үндсэн хуулийн дараа орох Монгол Улсын бүх иргэн хэлэлцүүлэгт орох ёстой гэж үзэж байгаа юм.

Тийм учраас энэ хуулийг өргөн барихдаа Монгол Улсын хэдэн аймаг, хэдэн сум, хэдэн багт хэдэн хүнээс хэлэлцүүлэг хийсэн юм бэ, хэдэн санал ирсэн юм бэ гэсэн асуултыг нэгдүгээрт хэлье гэж бодож байна.

Газрын маргаан бол төвд гэхээсээ илүү Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт бий болдог. Маргааныг таслах үйл явц бол анхан шатанд байх ёстой. Анхан шатанд байх ёстой. Айл өрхүүд хоорондоо маргадаг, баг хоорондоо маргадаг, сумд хоорондоо маргадаг, аж ахуйн нэгжүүд хоорондоо маргадаг. Энэ маргаан бол уягданаар, заавал дээшээ явж, дарга нарын гар харахгүй, агентлагийн гар гарахгүйгээр анхан шатанд шийдэгддэг байх ёстой. Гэтэл бодит нөхцөл байдал, тогтолцоогоороо шийдэгддэг. Хэрвээ газрын харилцааны энэ хуулиар газрын асуудал мэддэг, төрийн захиргааны албан хаагчдыг дээрээс томилдог болох юм бол энэ улам хүнд суртал, авлига, хээл хахуульд автана. Нөхцөл байдал анхан шатандаа шийдэгддэг, сумын газрын даамал, сумын Засаг дарга асуудлыг шийддэг, багийн Засаг дарга, багийн дарга асуудлыг газар дээр нь шийддэг, аймгийн Засаг дарга өөрийнхөө нутаг дэвсгэрт асуудлыг газар дээр нь шийддэг ийм хэмжээнд энэ хуулийн хүчин чадлыг нэмэгдүүлж өгөхгүй юм бол төвлөрлийг дээш нь татах юм бол улам авлига, хээл хахууль нэмэгдэнэ, улам маргаан

нэмэгдэнэ. Энэ зүйлүүдийг энэ хуульд анхааруулан оруулж ирэх ёстой гэж байгаа юм.

Одоо орон нутагт байгаа гол маргаан бол баг хоорондын хилийн цэсийн асуудал, сум хоорондын хилийн цэсийн асуудал, аймаг хоорондын хилийн цэсийн асуудал, дээр нь газар олголтын асуудал ийм зүйлүүд байж байгаа. Өнөөдөр төвлөрлийг сааруулъя, орон нутгийн хөгжлийг дэмжье гэх юм бол энэ хуулийг цогцоор нь бий болгох ёстой. Өнөөдөр газрыг өмчилж байгаа нь гээд эхэлж өгчихдөг, тэгээд тэр дээрээ байшин барилгаа барьдаггүй, хашаа хороогоо барьдаггүй, талын нэгээр нэг тарсан, машины дугуй булсан, 1, 2 шон босгосон, ингээд хотжилтыг эвдэж байгаа зүйлүүд байгаа юм. Энийг энэ хуульд яаж тусгасан бэ гэсэн ийм зүйлүүд байна.

Маш олон зүйлийг асуумаар байна. Энэ хууль бол том хууль. Тэгэхлээр 4 минутад бол амжихгүй. Та бүхний энэ асуултын дараа тодруулж асууя.

Г.Занданшатар: Сүхбаатар сайд яасан. Хууль санаачлагч хүрэлцэн ирээгүй байна. Мөнхбаатар сайд хэзээ ирэх юм бэ. Магнайсүрэн. 83.

С.Магнайсүрэн: Мөнхбаатар сайд 1 дэх өдөр ажилдаа орчихно. Гадаад томилолттой байгаа.

Г.Занданшатар: Мөнхбаатар сайд ирэхгүй бол энэ хуулийг хойшлуулна. Том хууль хэлэлцэж байхад.

С.Магнайсүрэн: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Хэлэлцүүлгийн шатанд бид нар

ерөнхий бүх аймгууд, аймгуудад бол аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар маань хариуцаад бүх сумдын төлөөллийг оролцуулаад, манай агентлагаас удирдан зохион байгуулахад нь оролцоод хийсэн. Бүсчилж хийсэн хэлэлцүүлэгт бол манай яам зохион байгуулж, 4 газар бүсчилж хийсэн. Тэгээд манай салбарын төрийн бус байгууллагууд, бусад судлаачдын оролцоотойгоор бид нар ер нь 20-иод удаа хэлэлцүүлэг хийж, 1000 орчим хүн оролцуулсан тооцоо байдаг. Нийтдээ 225 хүн саналаа цаасаар болоод цахимаар асуулт асууж, санал ирүүлсэн. Энэ дотор бол яг хуулийн төсөлд тусгайлсан авч үзсэн санал бол 450 орчим саналыг бол бид нар тусгайлж авч үзэж тусгасан гэсэн ийм дүн мэдээ байдаг.

Маргаан шийдвэрлэх процесс дээр бол ер нь асуудлыг бол аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн байгууллага дээр энэ газрын эрх шийдэгдэж байгаа. Энэ нь бол яг төлөвлөлтөөс халихгүйгээр, төлөвлөлтийн хүрээнд цахим ийм программаар асуудал шийдэгдэж байгаа учраас их шуурхай, тодорхой хугацаанд асуудал шийдэгдэж байгаа. Шийдэгдсэн шийдлийн дагуу сум, дүүргийн Газар зохион байгуулалтын хэлтэс, сумын газар зохион байгуулагч дээр бол гэрээ хийгдэж, гэрчилгээ, холбогдох баримт бичиг олгогдож ингэж яваа. Маргаан нь бол яг энэ шийдэгдсэн газраа буюу аймаг, нийслэлийн газрын албанд маргаан өгөгдөнө. Цахимаар ч өгөгдөж болно, цаасаар ч өгч болно. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд маргаан шийдвэрлэх зөвлөл гэж бид нар орон тооны бус ийм зөвлөлүүд, мэргэжлийн тийм хүмүүсээр бүрдсэн зөвлөлүүд ажиллаж, шуурхай

шийдвэрлэх, энэ бололцоог нь хуульд хугацаатай нь ямар тохиолдолд ийшээ хандах вэ гээд оруулж өгсөн байж байгаа. Улсын тусгай хамгаалалттай газартай холбоотой маргааныг бол агентлаг буюу газар зохион байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөл шийдэхээр бол тодорхой хуульчилж өгсөн. Тэгээд энэ асуудлууд дээр шийдсэн шийдлүүд дээр гомдолтой байвал иргэн хүний хувьд бол шүүхэд хандах ийм шийдэл нь бол нээлттэй байгаа. Ер нь бол Захиргааны ерөнхий хуулийн дагуу бол энэ урьдчилсан маргааныг урьдчилж шийдэх энэ шийдлүүд бол зайлшгүй хуулиар бол бид нар шаардлагатай гэж үзээд энэ шатуудыг суулгасан.

Энэ маргаан таслах зөвлөлүүд гарснаараа бол бид нар харин ч тодорхой хугацаанд шуурхай шийднэ, мэргэжлийн хүмүүсээр бүрдсэн ийм шийдлүүд гарах учраас их бололцооны үр дүн үзүүлэх болов уу гэж үзэж байгаа юм. Яагаад гэвэл захиргааны шүүх дээр байгаа маргааны 23 орчим хувь нь бол зөвхөн газартай холбоотой маргаан байдаг гэсэн ийм судалгаа байдаг. 3 дахь асуудлаар хэн хариулах уу?

Г.Занданшатар: 85.

А.Энхманлай: Батсуурь гишүүний асуултад тодруулж хариулъя. Газар олгох, иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг бол бид бүхэн бас тодорхой хэмжээнд зохион байгуулж оруулж ирж байгаа. Энд бол ямар асуудал шийдэгдэх гэж байгаа юм гэхээр газрыг бол зөвхөн дэд бүтэцтэй, эсвэл дэд бүтэц төлөвлөгдсөн байриил дээр л өмчлүүлдэг болгох ийм асуудлаар бол

хуулийн төсөл боловсруулагдсан. Ингэхдээ бол хот суурины газрын газар ашиглалтын бүсчлэлтэй уялдуулна. Энэ бүсчлэлийг бол аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд баталж, түүн дээрээ дүрмийг бас батлахаар ингэж зохицуулсан. Ингээд энэ бүсчлэл болон дүрэмд заагаагүй газар дээр хот суурины ангиллын зориулалтаар шинээр газар эзэмшүүлэх, өмчлүүлэх асуудлыг олгохыг бол хориглосон ийм зохицуулалт орж ирж байгаа юм. Ийм агуулгаар цаашидаа бол энэ замбараагүй газар олголт, асуудал бол хязгаарлагдана.

Газрын маргаан асуудлыг шийдвэрлэх ажил дээр бол одоогийн мөрдөгдөж байгаа хуулиар Засаг дарга дээр бүрэн эрх олгогдоод явж байгаа. Гэсэн хэдий боловч газрын маргаантай асуудал багасахгүй байгаа. Өөрөөр хэлбэл энэ газрын маргааныг мэргэжлийн түвшинд урьдчилсан шийдвэрлэх журмыг яаралтай бид нар зохион байгуулж, ийм асуудлыг хариуцсан бүрэлдэхүүнийг байгуулж ажиллуулахгүй бол шүүх дээр очоод энэ газрын маргаантай асуудал маш их удааширдаг. Шүүгч нар бас энэ газрын асуудлаар мэргэшээгүй учраас газрын маргаан 1-2 жилийн хугацаанд шийдэгдэх ийм удааширалтай байгаа. Тэгвэл энэ газрын маргаан таслах зөвлөлийг байгуулаад, зөвлөл нь хэд хоногийн дотор газрын маргааныг шийдэх юм, зөвлөлөөс гарсан шийдвэрийг зөвшөөрөөгүй бол иргэн хэд хоногийн дотор шүүхэд хандаж шийдэх юм, энэ асуудал бол их нарийн, ойлгомжтой байдлаар бол зохицуулагдаж орж, ирж байгаа юм. Зөвлөлийг байгуулах, ажиллуулах дүрмийг батлах эрх нь бол мөн л Засаг даргад байж байгаа юм. Өөрөөр

хэлбэл Засаг дарга өөрийнхөө тэр хийж чадахгүй байсан, амжихгүй байгаа ажлаа зөвлөлөөр дамжуулж, өөрөөр хэлбэл мэргэжлийн бүрэлдэхүүнээр дамжуулж, хэрэгжүүлэх ийм бололцоотой болгож хуульчилсан байгаа.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн тодруулъя.

Ж.Батсуурь: Тэгэхлээр 3 сая гаруй хүмүүсийн нийгмийн харилцаатай холбоотой эдийн засаг, нийгмийн гол суурь хууль. Тэгэхлээр энийг бол би хэлэлцүүлэгт оролцсон хүмүүсийг бол тоог нь голж байна. 1000 орчим хүн оролцсон, 450 ширхэг санал ирсэн гэж бол би ойлгохгүй байна. Би бараг 4000, 400 мянган санал ирэх ёстой л гэж ойлгож байгаа юм. Тийм учраас энэ хэлэлцүүлгийн явцад энэ бүх телевизүүдээр ялангуяа орон нутгийн Малчин телевиз, орон нутагт цацдаг телевизүүдээр шууд ярилцлагууд, хэлэлцүүлгүүдийг маш их хийж, анхан шат, дунд шат, баг, сум, аймаг, хот, дүүрэгт байгаа хүмүүсийн санаа оноог маш сайн авсан, ийм хууль хийгээсэй л гэж бодож байна. Тэгэхгүйгээр дөнгөж батлагдсаны маргаашаас нь авхуулаад л хэл ам дагуулаад явчих вий дээ гэсэн ийм.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Жамбын Батсуурь гишүүн гэсэн олон гишүүн ийм чухал хуулийн талаар эрхэлсэн сайд нь байхгүй байгаа. Тэгээд энэ чухал асуудлаар бас хэлэлцүүлэг шаардлага хангаагүй байна гэсэн ийм улс төрийн асуудлууд тавигдаж байна. Энэ бол төр нийгмийн асуудал мөн. Тийм учраас хууль санаачлагч байхгүй бол хуулийн төслийн

хэлэлцүүлгийг хойшлуулна гэсэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу. Асуулт хариулт нь нийцэхгүй байна. Та сайдаас ирэхээр нь тухтай асуу. Энүүгээр явна, энэ үргэлжилнэ, яг энүүгээр явна. Энүүгээрээ хадгалчхаарай. Хойшлуулж байгаа болохоор буцаагаагүй, хойшлуулж байгаа болохоор яг эндээс үргэлжлээд явна гэсэн үг.

Зөвхөн эрхэлсэн сайд нь төдийгүй, Хөдөө аж ахуйн сайд ч гэсэн энэ бэлчээрийн асуудал яригдаж байна. Ер нь бол энэ хотын асуудал байна шүү дээ Томыг дуурайж, гадаадыг хуулбарлаж, гамбир элдэх мэт хотыг хөгжүүлэх нь түгжрэл утаанд хүргэдэг гэж хэлсэн байгаа юм. Хот ийм уудам газар нутагтай улс мөртөө газрыг эргэлтэд оруулахгүйгээр Улаанбаатар хот дээрээ шавсаар байгаад Улаанбаатар болж байна. Энэ бол газрын эргэлтийн харилцаа буруу байгаагийн яруу тод илрэл. Гамбир элдэнэ гэдэг чинь ингээд л Улаанбаатарыг тэлээд л байна, тийм ээ, тэгэхээр асуудлын гол шалтгаан нь энэ түгжрэл энэ тэр чинь энэ гамбир элдэх мэт хот төлөвлөлтийн газрын харилцааны бүх асуудал чинь байгаа шүү дээ. Энэнийхээ уг үндсийг мөн олж харах хэрэгтэй. Бээжин хотын төвлөрөл, түгжрэлийн асуудлаар, хот төлөвлөлтийн асуудлаар, газрын харилцааны асуудлаар хэлсэн үг шүү. Хуран үйлдэх аргаар биш түгжрэлийг хуран эс үүлдэх аргаар бууруулна гэж байгаа юм. Энэ нь бол хотод барилга, байшин барихыг хориглох, хөрөнгө оруулалтуудыг хөдөөд илүү урамшуулах, Улаанбаатарын төвийн районуудын авто машины паркийн зогсоолын төлбөрийг нэмэх мэт түгжрэлийг бууруулах, ийм хуран эс

үйлдэх аргын талаар бусад улсын туршилага байна гэх мэтчилэн энэ газрын харилцаа чинь өөрөө хөгжлийн үндэс байхгүй юу, улсын үндэс. Тэгээд энэ асуулт хариултад явж байгаа байдал олон гишүүд шүүмжлэлтэй хандаж байгаа нь яах аргагүй байна. Энэ хэлэлцүүлгийн байдлын шаардлагыг хангахгүй. Жамбын Батсуурь гишүүн зөв шаардлага тавьж байна шүү дээ. За ингээд хойшлууллаа.

Энэ чинь өөрөө хот төлөвлөлт, энэ бүх асуудлууд уялдан шүү дээ. Энэ газар чинь улсын үндэс шүү дээ. Ийм чухал асуудал дээр хариуцлагагүй хандаж болохгүй шүү дээ. Энэ хадгалагдана, эндээс үргэлжилнэ. Энийг хадгалж аваарай, бичиж аваарай.

Олон гишүүд ийм санал хэлээд байгаа учраас энийг нээрээ харгалзан үзэхээс өөр арга алга.

Дараагийн асуудалд орёё. Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагч Барилга, хот байгуулалтын сайд байхгүй учраас хойшлууллаа.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал. Хууль санаачлагч гадаад явсан учраас хойшлууллаа.

Нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг

хойшлууллаа. Хууль санаачлагч байхгүй.

Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагч байхгүй учраас хойшлууллаа.

12.17 цаг

Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Ажлын хэсэг байна уу.

14 цагаас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ. Үдээс өмнөх чуулганы өмнө нэгдсэн хуралдаан завсарлалаа.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлт гаргаж, ирүүлснийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан болно.

Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагаар ахлуулж, гишүүдэд Б.Баттөмөр, Д.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, С.Чинзориг нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллалаа.

Байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 48 саналын томъёолол, 5 багц найруулгын санал, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх 26 саналын томъёолол болон Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан зарчмын зөрүүтэй 3 саналын томъёолол тус бүрээр хэлэлцэж, санал хураалт явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн зарчмын зөрүүтэй саналын томъёололд төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг багасгах, түншлэлийн төсөл хэрэгжүүлэх хугацааг тодорхой болгох зорилгоор түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналд хийх урьдчилсан үнэлгээг 30 хоногийн дотор түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бие даан хийхээр, төслийг урьдчилан зарлах хугацаа 12 сар хүртэл байхаар тусгасан болно.

Мөн ажлын хэсгээс аймаг, нийслэлд түншлэлийн төслийг бие даан хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21, 24 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын эрх олгосноор аймаг, нийслэлийн жилийн төсвийн аравны нэгээс хэтрүүлэлгүйгээр аймаг, нийслэл бие даан түншлэлийн төсөл хэрэгжүүлэх, тус харилцааг зохицуулах журмыг энэ

хуульд нийцүүлэн шинээр батлах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Мөн түншлэлийн гэрээний төрөлд “барих, түрээслэх, ашиглах, шилжүүлэх” хэлбэрийг шинээр нэмэхээр хуулийн төсөлд тусгасан нь хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэгийг авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр энэ хууль хэрэгжиж эхлэхээс өмнө холбогдох дүрэм, журмыг шинэчлэн боловсруулах, олон нийтэд сурталчлан таниулахад тодорхой хугацаа шаардлагатай тул хуулийг дагаж мөрдөх хугацааг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлэх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр энэ хуулийн зохицуулалттай уялдуулах зорилгоор дээрх хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэн, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт

явуулж, саналуудыг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд хургүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданиатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Гантөмөрийн Түвдэндорж, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батсүхийн Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Бөххуягийн Мөнхтогтох Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын хуулийн мэргэжилтэн, Очиржанцаны Мөнхтөр Эдийн засгийн хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Үхэртарын Алтаншагай Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын хуулийн

мэргэжилтэн.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Аубакир гишүүнээр тасаллаа. Тогмидын Доржханд гишүүн асуулт асууя.

Т.Доржханд: Баярлалаа. Эдийн засгийн байнгын хороо дээр бол бид нар нэлээн ярилцсан л даа. Тэгээд би бас энэ хуулийн ажлын хэсгийнхэнд, чуулган дээр тодорхой байр сууриа дахиад бас илэрхийлчихмээр санагдаад байна. Ямар асуудал байна вэ гэхээр нэгдүгээрт, Монгол Улсын төр маш их томорсон байгаа. Тэгээд улсын төсөв нь жил болгон тэлдэг. Дөнгөж сая бид нар ирэх жилийнхээ төсвийг баталлаа. Онцлог нь юу байсан бэ гэхээр 20.5 их наяд гээд л өмнөх жилүүдээсээ дахиад л өсөлттэй батлагдчихлаа. Дараагийн онцлог нь юу вэ гэхээр хөрөнгө оруулалт байхгүй. Шинэ хөрөнгө оруулалт хийх өрөө, тасалгаа байхгүй. Өөрөөр хэлэх юм бол бид нар дэд бүтцийн санхүүжилтийг хийх, хөгжлийн санхүүжилтийг хийх ийм орон зай төсөв дээр байхгүй болчихож байгаа юм.

Тэгээд ийм төслүүдийг хэн санхүүжүүлдэг юм бэ гэхлээр төрийн үндсэн үүрэг байдаг. Газар доогуурх дэд бүтцийн төслүүд, зам тээвэр, агаарын тээвэр, төмөр зам, эрчим хүчний төслүүд гээд. Гэтэл эх үүсвэр байхгүй, хувийн сектор энийг хийдэг үү гэхээр хувийн сектор бол ийм төслүүд рүү айхтар ордоггүй. Үр ашигтай тохиолдолд ордог. Монголд тийм үр ашигтай төсөл байхгүй.

Тухайлбал эрчим хүчний салбар нь болохоор үнийн хатуу

зохицуулалттай, гаднын битгий хэл дотоодын компаниуд орсон ч гэсэн шатна. Яагаад вэ гэхээр өртгөөсөө доогуур үнэлэгдчихсэн, тэгээд цаашаагаа банкнаас яг тэр үнэлгээ хийгээд үзэх юм бол bankable гэж ярьдаг төслүүд байхгүй. Маш цөөхөн. Ийм тохиолдолд юу хэрэгтэй юм бэ л гэдэг асуудал байгаа. Ийм тохиолдолд бол бид нар санхүүжилтийн эх үүсвэр хэрэгтэй, ингэхдээ бол төрийн сектор, хувийн сектор хамтарч санхүүжилтээ хийдэг, ийм платформ гээд энэ агуулгаараа бол энэ концепцийг нь бол дэмжээд байгаа юм. Гэтэл яг бодит байдал дээр энэ хэрэгжих үү. Томоохон төслүүд рүү орох уу, Ийм нөхцөл байдалтай.

Хоёр дахь нь бол төр ингээд томроод байгаа зүйлийг жижгэрүүлдэг, төрийн оролцоог жижгэрүүлж, хувийн сектороо илүү их дэмждэг арга хэрэгсэл нь юу байна гэхээр нэг бол хувьчлал байдаг. 1990 онд бид нар хувьчлалыг хийсэн. Үр дүн нь бол харилцан ялгаатай байна.

2 дахь нь болохоор хувийн секторт гэрээний үндсэн дээр төрийн ажил үйлчилгээг хийх байдлаар төрийг жижиглэдэг. Төрийн албан хаагчдыг цөөлдөг, төрийн үйлчилгээний зардлыг бууруулдаг. Энэ агуулгаараа бол өнөөдрийн энэ хуулийн төсөл зорилго нь бол уялдаж байх ёстой. Олон улсад бол ингэж явдаг. Томоохон төрийг жижиглэдэг, хамгийн үр ашигтай тогтолцоо нь юу вэ гэхээр өнөөдөр төрийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр урт хугацаанд шүү, урт хугацаанд олгодог ийм л зохицуулалтыг бол энэ хуулиар олгож өгөх ёстой. Үндсэн 2 нь. Өмнө нь алдаа юу байсан бэ гэхээр мөнгө хэрэгтэй гээд ВТ буюу ашиглаад шууд төсвөөс зарцуулах байдлаар шийдсээр

байгаад, үнэлгээ нь зах зээлийн үнээс 3-4 дахин өндөр үнэтэй гэрээ байгуулдаг, эргээд улсын төсвөөсөө санхүүжүүлдэг, энэ өр болдог, тэгээд үндсэндээ урт хугацааны хувийн секторын амжилттай явдаг ийм санхүүжүүлсэн /POT/ гэдэг нөхцөлтэй ийм гэрээ байхгүй шүү дээ Монголд. Ийм болохоор өнөөдөр сайхан хууль хийж болно. Олон улсын жишигт нийцсэн л гээд байх шиг байгаа юм. Гэхдээ энэ маань өөрөө цаашаа явах уу гэдэг дээр анхаармаар байгаа юм. Цаашаа явах уу гэдгийг анхаарахын тулд энэ нөгөө хэрэгжүүлэх функц нь аягүй чухал байгаа. Хэрэгжүүлэх функц нь төрийн нэг томилгоотой бас нэг ийм намын дарга хүрч ирээд л явах юм бол энэ чинь явахгүй. Тэгэхлээр энэ дээрээ та бүгд маань яг ямар байдлаар хувийн менежментийг оруулж ирэх юм бэ гэдэг.../минут дуусав/

Г.Занданишатар: Байнгын хороо хариулах уу, ажлын хэсэг хариулах уу. Түвдэндорж Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд.

Г.Түвдэндорж: Доржханд гишүүний асуултад хариулъя. Доржханд гишүүнтэй санал нэг байна. Үндсэндээ бол Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн гол үндсэн зорилго, концепци агуулгыг бол та зөв тодорхойлж хэлсэнд баяртай байна. Ер нь бол яг энэ хуулийн төслөөр цаашид ер нь энэ томоохон дэд бүтцийн төслүүд,

Нийгмийн төрийн үйлчилгээний салбарыг хувийн хэвшлээр хэрэгжүүлэх энэ хуулийг хэрэгжүүлэх чадах уу гэдэг эргэлзээтэй асуудал гарч ирж байгаа. Тэр дээр бол өмнө одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Концессын тухай хууль бол хууль, эрх зүйн орчин маш тодорхой

бус, хэтэрхий ерөнхий агуулгатай. Тэгэхээр яг энэ хууль, эрх зүйн орчноор бол томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжгүй байсан. Энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар бол энэ боломжуудыг нээж өгч, тодорхой ойлгомжтой төр ямар үүрэг, хариуцлага хүлээх вэ? Ямар төрийн байгууллагуудын чиг үүргүүдийг маш нарийн тодорхойлж гаргаж өгсөн. Эрсдэл, хувийн хэвшлийг оруулж байгаа хөрөнгө оруулалтыг эрсдэлийг яаж хамгаалах вэ, яаж дэмжих вэ гэдэг асуудлыг энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар бол сайн зааж өгсөн байж байгаа. Баярлалаа.

Г.Занданишатар: Байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг.

Ц.Цэрэнпунцаг: Доржханд гишүүний асуусан асуултад ажлын хэсгийн хариулт дээр нэмээд хариулчихъя. Бид нар түрүүчийнхээ алдаанаас суралцах ёстой. Ер нь 2010 онд батлагдсан концессын хууль бол ер нь зүйрлээд хэлэх юм бол дутуу хагас, машинаар ярих юм бол дугуй, зарим эд анги нь байхгүй ийм л хууль болоод явчихсан юм байна гэж дүгнэсэн. Энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль бол бүрэлдэхүүн хэсэг бол бүтэн, ялангуяа хамгийн гол бидэнд дутагдаад байдаг 7 хэмжигч I огтол гэдэг шиг тэр хэрэгжүүлэх төслөө тандалт судалгааг нь хийж, шинжилгээ хийж, энд үнэлэлт дүгнэлт өгөх энэ процессыг бол их нарийн зааж өгсөн. Тэр гэрээ байгуулах хэсэг байна. Сүүлийн хэсэг нь бол одоогийн 2010 онд гаргасан тэр концессын хуульд байдаггүй, хамгийн урт хугацаа бол 30 жил, удаан хугацаанд хамтарч ажиллана.

Энэ концессыг гэрээний хугацаанд бол араас нь энэ концессын хэрэгжилт, ялангуяа нийтийн үйлчилгээ, төрийн үйлчилгээг нийтэд үзүүлж байгаа үйлчилгээг хүргэж байгаа хамтрагчдаа бол араас нь гэрээний дагуу хянаж ажиллах энэ процессоо бол бас нарийн детальчилж заасан ийм сайн хууль учраас өмнө гаргасан, энэ өмнөх концессын хууль дээр гарч байсан сөрөг үр дагаврууд энд гарахгүй байх гэж харж байгаа.

Хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулагчид маань олдох болов уу гэж байгаа. Тэгэхээр бид нар 1,2 хэд 3 хувийн хөрөнгө оруулагчид, хувийнх нь компаниудад энэ зориулж энэ хууль бичигдээгүй гэж ойлгож байгаа. Энэ бол бид бүхэн одоо нэгэнт байгаа концессын хууль бол одоогийн шаардлагыг хангахгүй болжээ. Дээрээс нь бол тэр дунд хамгийн дампуу юм явсан, тэр барих, шилжүүлэх гэдэг хэлбэр бол бүр болохоо байгаад 2017 оноос хойш тэр төрлийн концессыг бол зогсоосон. Тэрний өнөөдөр төсөв дээр тэр концессын барих, шилжүүлэх гэдэг концессын дагуу хийгдсэн гэрээнүүдийн төсөв дээр ирж байгаа ачаалал бол хүнд байгаа. Одоо энэ төлөгдөөд явж байгаа энэ 200, 300 тэрбумаараа жилд төсөв дээр тавигдаж байна.

Тийм учраас бол энэ алдааг давтахгүйн тулд бид нар энэ хуулийг хийж байгаа. Ер нь энэ хуулиар бол барих, шилжүүлэхээс бусад бүх төрлийн хамтын ажиллагаа энд багтаж байгаа гэж ойлгож болно. Тийм учраас заавал тэр хөрөнгө оруулалт, их хөрөнгө оруулалт шаардсан том төслүүдээс гэлтгүй жижиг, жижиг цэцэрлэгийн барилга барихаас авхуулаад л. Өнөөдөр үр

ашиггүй ажиллаж байгаа Соёлын төвийн барилгыг цааш нь үйл ажиллагааг нь аваад явах хүртэл ийм олон төрлийн хамтын ажиллагаанууд байгаа юм. Тэгэхээр бол энэ бол өнөөдөр Засгийн газрын явуулж байгаа төсвөөсөө хөрөнгө оруулалт хийж явуулж байгаа үйл ажиллагаануудыг, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийх хувийн хэвшлийг өнөөдөр яг төрийн явуулж байгаа, төр өөрөө явуулж байгаа бизнесээсээ, хувийн хэвшилдээ нааш нь хувийн хэвшилээ оруулж ирж, хамтарч ажиллаж, төр хувийн хөгжлийн хийж байгаа бизнесийг зааглаад шугам татах юм бол тэр шугамаас цаашаа хувийн хэвшил рүү гишгэхгүй, харин наад талдаа төрийн талдаа байгаа бизнесээсээ хувийн хэвшилдээ өгөх ийм агуулгатай хууль байгаа юм.

Ер нь бол бас та гадаадын хөрөнгө оруулалт ярьдаг. Энэ бол Байнгын хороо дээр ч бид нар бас ярилцаж байсан. Энэ бол гадаадын хөрөнгө энэ хууль гарснаар бол бас нэг том хууль эрх зүйн орчин нь бол бүрдүүлж өгч байгаа ийм ач холбогдолтой хууль байгаа юм.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууя.

Т.Доржханд: Тэгэхээр нөгөө авч явж хэрэгжүүлэх байгууллагынхаа бүтцийг нэг тодорхой хэлээд өгчхөөрэй. Хувийн секторын менежментийн баг орох юм уу, мэргэжлийн хүмүүс байж чадах юм уу, аль эсвэл зүгээр нэг яамны доор нэг ийм төрийн алба, аппарат байдлаар ингээд цаашаа явах юм уу гэдэг дээр нэг.

Хоёрдугаарт, би ажлын хэсгийн ахлагчаас бас асуух гээд байгаа зүйл нь төсөв дээр чинь тойрог болгонд, сум болгонд л баахан соёлын төвүүд, заримд нь бол давхардаад хийчихсэн жишээ шүү дээ. Гэтэл энэ жилдээ нэг хоёрхон удаа л ашигладаг, бүгдээрээ мэдэж байгаа цагаан сараар нэг алга таидаг, шагнал гардуулдаг, наадмаар нэг ашигладаг тэгээд л боллоо. Бусад үед нь бол хамгийн их эрх мэдэлтэй хүн нь сахиулна гээд байгаа шүү дээ. Тэр нь бол Арабын шех шиг дуртай үедээ соёлын төвөө онгойлгоод л тэндээ партиддаг гэдэг. Тэгээд энийгээ бид нар хувийн секторт гэрээний үндсэн дээр өгөөд цаашаа энэ зардлаа хэмнэх бодитой нөхцөл боломж үүсэх үү? Ингэж байж л бид нар төсвийн хэмнэлтийн асуудал ярихаар.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэрэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг дараа нь нэмээд хариулчхаарай. Доржханд гишүүний тодруулж байгаа нэг асуулт бол яг сая таны хэлдэг энэ жишээ бол одоо би ч гэсэн түрүүн хэлсэн соёлын төвийг үр ашиггүй байгаа, энэ илүү зардал чирэгдэлтэй ийм барилга байгууламжуудыг бол цааш нь энэ хувийн хэвшлийнхэн аваад явах бололцоог нь энд нээж байгаа юм. Ерөнхийдөө бол төслүүдийг 2 хувааж, нэг нь браун филд /brown field/, грийн филд/ green field/ гээд. Браун филд нь одоо барьж байгуулчихсан ийм байгууламжуудыг хувийн хэвшлийн дэд бүтцүүдийг одоо ашиглах, лизинг хийх, түрээслэх, менежментээр нь авч явах гээд олон хэлбэр байгаа. Энүүгээр явж болно. Таны саяын хэлдэг бол тэр яг тэр төрлийн үйлчилгээнүүд, тэр төрлийн

байгууламжуудын үйл ажиллагааг бол хувийнхан аваад явах бүрэн боломж нь энэ хуулиар нээгдэж байгаа юм.

Хоёрт, энэ бүтэц төр хувийн хэвшлийн түншлэлийн төв гэж байгуулагдах юм. Энэ төв нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Түвдэндорж гүйцээгээд хариулчих. 83.

Г.Түвдэндорж: Доржханд гишүүний асуултыг тодруулж хариулъя. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн бас нэг гол шинэлэг зүйл бол энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийг Эдийн засгийн хөгжлийн яамны дэргэд байгуулж байгаа. Энэ төвийг байгуулах гол зорилго нь бол боловсон хүчний асуудлыг бэлтгэх, төвийн дэргэд мэргэжлийн баг, ажлын хэсэг ажиллах юм байгаа юм.

Төслийг бол анхан шатнаас нь бэлтгэхэд ТЭЗҮ судалгаа, эдийн засгийн үр ашиг, хэрэгжүүлэх бүх л тооцоог төслийн зөвхөн бариад, ашиглалтад оруулах үеийнх биш, төслийг бариад урт хугацаанд 20, 30 жилийн хугацаанд үр ашигтай яаж ажиллах вэ? энэ бүх тооцооллыг бол энэ төв хийх ийм давуу талтай байж байгаа. Өмнөх концессын явж ирсэн туршилага.../минут дуусав/

Г.Занданшатар: Товч, тодорхой хариулаач. Тэгээд ер нь суманд соёлын төв, соёлын ордон жилд хоёрхон удаа ашиглагддаг гэдэг бол худлаа. Та очиж үзэх хэрэгтэй. Тэнд чинь бас хүн амьдарч байгаа. Монгол улс Жалга довоос тогтдог шүү. Батсуурь гишүүнээсээ асуу. Аймгийн амьдрал ямар байдаг юм, сумын амьдрал ямар байдаг юм, жилд 2 ашигладаг ордон гэж хаа байна.

Нанзадын Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн үзэл баримтлалыг дэмжиж байгаа. Энэ бол ер нь цаг нь болсон, зайлиггүй хийх ёстой төрийг, хувийн хэвшилтэй түншлүүлж ойртуулах, олон бүтээн байгуулалт хийх, улсын төсвийг хэмнэх ийм олон ач холбогдолтой гэдгийг бол бүгдээрээ мэдэж байгаа.

Нэгжсийн хуулиар орон нутаг концесс гарах эрхтэй болчихсон. Одоогоор өнөөдөртөө ч хэрэгжээгүй л явж байгаа, харин энэ хууль гарч ирснээрээ орон нутаг концесс хэрэгжүүлээд гэрээ байгуулаад тодорхой ажлуудаа хийгээд явах үүд хаалга нь нээгдэж байгаа юу гэсэн гол асуудал байгаа. Ер нь энэ хуульд орон нутгийн эрх үүрэг юу байна вэ, тодорхой ямар хязгаарлалтуудыг орон нутагт төр, хувийн хэвшлийн хүрээнд боломжуудыг нээж өгч байна. Хажуугаар нь ямар хязгаарлалтууд байж байна вэ гэдэг асуудлыг тодруулъя гэж бодож байгаа юм.

Орон нутаг бол энэ төр, хувийн хэвшлийн хүрээнд хийх ажлууд маш их байдаг. Амьдрал дээр энэ хууль маань гараагүй байсан. Өмнө нь концессын хууль, тендерийн хууль 2-оор л бид хувийн хэвшлийнхэнтэйгээ харьцаж байлаа. Тэгэхээр энэ концессын хууль бол учир дутагдалтай байсан нь тодорхой. Бараг худалдан авах ажиллагааныхаа хуультай адилхан, бараг мөнгийг нь дараа нь 2 3 жилийн дараа увуулж цувуулаад л өгчихдөг болохоос биш бусдаар бол бараг ялгаагүй. Цаашаа яаж эзэмших нь тодорхойгүй, яаж сонгон шалгаруулж, яаж дүн шинжилгээ

хийж ингэж явах нь бол тодорхойгүй байсан юм. Тэгэхээр энэ хууль дээр бол нарийн тогтоож зааж өгсөн байх гэж бодож байгаа юм. Тухайлбал, энэ хилийн боомтууд дагасан томоохон бүтээн байгуулалтууд зарим бүс нутагт бол хийгдэх гэж байна. Төмөр зам, авто замууд дагаад энэ дээр хувийн аж ахуйн нэгжүүд хамтарч ажиллах сонирхол их байдаг. Тухайлбал, төмөр зам, авто зам дагасан трименалуудыг хийх, нүүрс ачиж буулгах, жишээ нь талбай, агуулахуудыг хийх, зочид буудал, гуанз хийх. Мөн дээрээс нь нэмээд хилийн боомтуудыг дагасан суурьшлын томоохон бүсүүд, тухайлбал Цагаан хад мэтийн томоохон бүсүүд дээр хэдэн мянгаараа хүмүүс 5, 10 мянгаараа хүмүүс бий болчихлоо шүү дээ. Ямар ч засаг захиргааны нэгж байхгүй л явж байдаг. Тэгээд энэ дээр чинь эмнэлэг байгуулъя, цэцэрлэг байгуулъя гэсэн хувь аж ахуйн нэгжүүд бас байдаг. Тэгэхээр энийг яаж зохицуулж өгч байгаа вэ, энэ хуулиар нээлттэй болж өгч чадаж байгаа юу гэдэг асуудал байгаа. Мөн зарим аж ахуйн нэгжүүдтэй хамтраад зарим аймаг, орон нутаг боо өөрийнхөө нэн хэрэгцээний жишээ нь Дулааны цахилгаан станц, төр, хувийн хэвшлийн хүрээнд хамтраад явъя. Ингээд барьсан газар нь тодорхой хэд хугацаанд ашиглаад, зардлаа нөхөж аваад буцаагаад орон нутагт нь шилжүүлж өгөөд ингээд хамтаръя. Энэ хооронд хүмүүсийг чинь сургаад өгье гэдэг ийм асуудлууд байна. Зарим аж ахуйн нэгжүүд уурхайгаасаа сум хүртэл зам тавьж өгье, энэ дээр хамтарч ажиллая, хил боомт хүртэл бас зам тавья гэдэг ийм асуудлуудыг ярьдаг. Цаашилах юм бол говийн бүс нутаг руу энэ шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан томоохон хөтөлбөр, төслүүдээс бас

нэлээн хэд нь хэрэгжинэ, тухайлбал энэ гадаргын усыг хуримтлуулах, Орхон, Хэрлэн, Тоонот гэсэн төслүүд, жишээ нь хэрэгжихээр байж байгаа. Тэгээд энэ бүгд чинь төр хувийн хэвшлийн хүрээнд хийгдэх боломжтой мөртөө хууль эрх зүйн орчин нь тодорхой, заагдаж өгөөгүй байгаа учраас бас тодорхой хэмжээнд гацаад байгаа болов уу гэсэн ийм бодол байдаг юм.

Тийм учраас энэ орон нутаг өөрөө бие даагаад заавал улсын төсвийг хараад байхгүй, заавал өөрийнхөө төсөвт хязгаарлагдаад байхгүйгээр цаашаагаа хөгжих, эдийн засгаа тэлэх ямар боломжуудыг энэ хуулиар зааж өгсөн. Ер нь цаашидаа миний бодол бол улсын төсөвт элдэв сургууль, цэцэрлэг, сумын Тамгын газар гэж байхаар төсвийг нь аймгуудад нь хуваарилж өгөөд, аймаг нь цаашаагаа энэ төр, хувийн хэвшилтэйгээ хамтраад шаардлага.../минут дуусав/

Г.Занданшатар: Түвдэндорж. 81.

Г.Түвдэндорж: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Орон нутагт таны хэлсэн энэ бүтээн байгуулалтуудын төслүүдийг бол хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Засгийн газраас өргөн барьсан төслийн хувилбар дээр бол орон нутагт эрх нээгээгүй, Засгийн газар дээр яг төрийн хувь хэвшлийн түншлэлийн тухай эрхэлсэн сайдын хүрээнд Эдийн засгийн яаманд хандаад энэ асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхээр заасан байсан, харин Улсын Их Хурал дахь ажлын хэсэг дээр ярьж байгаад орон нутагт тодорхой хэмжээнд эрхийг нээж өгсөн байж байгаа. Энэ

нь хуулийн төслийн 2 дугаар бүлгийн 7.1.8-д Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21, 24 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аймаг, нийслэлд түншлэлийн төсөл, бие даан хэрэгжүүлэх эрхийг аймаг, нийслэлийн 1 жилд хийх түншлэлийн гэрээний нийт үнийн дүн нь тухайн аймаг, нийслэлийн жилийн төсвийн 1/10-ээс хэтрэхгүй байхаар гээд ийм заалтыг оруулж өгсөн байж байгаа.

Энэ хязгаарлалтыг бас асуулаа. Хязгаарлалт дээр бол тухайн аймаг, нийслэлийн жилийн төсвийн 1/10-тэй дүйцэхүйц төсвийнх нь өөрийнх нь чадамжтай, эрсдэлийг даах хэмжээнд чадамжтай нь уялдуулаад 1/10 хэмжээнд төсөл хөтөлбөрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжуудыг нээж өгсөн байж байгаа. Ер нь бол сургууль, цэцэрлэг, эмнэлэг орон нутагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийх бүрэн боломж нь энэ хуулийн төслөөр, энэ хууль батлагдсанаар бол нээгдэж байгаа. Бүх салбаруудад бол хэрэгжинэ. Хориглосон зөвхөн 3 салбар байгаа. Батлан хамгаалах, банк санхүү, уул уурхайн ашиглалт, олборлолт, хайгуулын үйл ажиллагаанаас бусад бүх салбарууд дээр бол бүрэн хэрэгжүүлэх боломж нь энэ хуулиараа нээгдэх юм байгаа юм.

Тэгээд хилийн боомтын дагасан бүтээн байгуулалтуудын ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн сонгодог жишиг төсөл болж чадна. Энэ хуулиараа бол хилийн боомт, том бүтээн байгуулалт, цахилгаан станц, зам, хурдны зам гэх мэтийн том төслүүдийг бол хэрэгжих боломж нь бол бүрэн нээгдэж байгаа юм.

Г.Занданшатар: За Энхбаярын Батшугар гишүүн.

Э.Батшугар: Баярлалаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн энэ хуулийг дэмжиж байгаа юм. Энэ бол цаг үеэ олсон хууль. Мөн Засгийн газар энэ хуульд нэлээн сайн ажилласан гэж би хувь хүнээсээ дүгнэж байна. Бусад амжилттай энэ түншлэлийн тухай хуулиудыг би уншсан улс орнуудын. Тэгэхэд бол концепцийн хуулиуд нь нэлээн нэгдэж байна. Өнөөдөр Монгол Улсын Засгийн газар шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 19.6 их наяд төгрөгийн хөгжлийн төслүүд байгаа. Жишээлбэл, боомтын сэргэлт, эрчим хүчний сэргэлт, хот хөдөөгийн сэрэл гэх мэтчилэн. Тэгэхээр энэ бодлогууд маань аль болохоор хурдан хэрэгжсэнээр Монгол улсад долларын, валютын урсгал нэмэгдэнэ, хани чангарна, төгрөгийн хани чангарна, үнийн өсөлт буурна, аж ахуйн нэгжүүд болон ард иргэдийн орлого нь нэмэгдэнэ, тэтгэвэр цалин нэмэх тийм бололцоонууд нээгдэх юм. Гэхдээ бас бусад улс орнуудыг харахад бол хэзээ ч хөгжсөн, хөгжөөгүйгээр үл хамаарч том хөгжлийн төслүүдээ бол өөрсдийнхөө улсын төсвөөс санхүүжиж чадваргүй байдаг тийм судалгаа гарсан. Делойт компанийн судалгаагаар бол нийт том хотуудын зөвхөн 16 хувь нь л бол өөрийнхөө төсвөөрөө том хөгжлийн дэд бүтцийн төслүүдээ санхүүжиж чадна гэсэн судалгаа гарсан. Тэгэхээр бол баян, ядуу гэхгүйгээр хөгжсөн, хөгжөөгөөгүй гэхгүйгээр үл хамаарч энэ түншлэлийн замаар том том төслүүд хэрэгждэг. Жишээлбэл, Норвеги улсын сутра хурдны зам бол Маквери групп болон СКА групп 2 хамтарч энэ түншлэлийн зарчмаар хурдны замаа барьж байна. Канад

улсын Онтарио хотын хурдны зам нь бол бас л ийм түншлэлийн зарчмаар хийгдэж байна. Хөгжиж байгаа улс орнуудыг дурдвал Сенегал улсын боомт нь бол бас л энэ түншлэлийн замаар хэрэгжиж байна. Амжилттай хэрэгжиж байгаа. Боливи улсын Лапас хотын бас цэвэрлэх байгууламж нь бас л түншлэлийн зарчмаар явж байгаа юм. Тэгэхээр энэ юу харуулж байна вэ гэвэл яг эд нарыг санхүүжүүлдэг том том улс институци байдаг. Мөн санхүүгийн эх үүсвэр нээгдэх юм энэ хууль батлагдсанаар.

2021 онд нийт хөгжиж байгаа улс орнуудад 76 тэрбум долларыг санхүүжүүлээд зөвхөн хөгжиж байгаа улс орнуудын дэд бүтэц рүү орсон. Цар тахлыг үл хамаараад 2019 оныг харвал бараг 100 тэрбум долларын дэд бүтцийн санхүүжилт бас л яг энэ зарчмаар хөгжиж байгаа улс орнууд руу орсон. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр манай нөгөө нэг шинэ сэргэлтийн бодлого болох боомтын сэргэлт, эрчим хүчний сэргэлтийн хэрэгтэй санхүүжилтээ яг энэ зарчмаас бүрэн авах бололцоотой, мөн санхүүжүүлдэг тусдаа банкнууд болон сангууд байдаг. Түрүүнд дурдсантай адилхан Macquarie infrastructure fund гэж Австрали улсын сан бол санхүүгийн сан бол цэвэр түншлэлийн зарчмуудаа хөгжлийн бодлоо төслүүдийг санхүүжүүлдэг. J.P.Morgan бол 26 тэрбум долларыг бас л энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийг санхүүжүүлэхийн төлөө гаргачихсан байна. City bank гэсэн энэ их идэвхтэй ажилладаг юм. Дэлхий даяар. Гэхдээ бас анхаарах хэдэн зүйл байгаа юм. 2 зүйлийг нь би яримаар байна. Эхнийх нь бол төсвийн алдагдалтай санхүүжүүлэх хэрэгсэл байж

болохгүй гэдэг нь бол олон улсын жишээгээр харагдсан.

Хоёрт нь бол заавал том компаниудаа оруулах нь бас зүйтэй биш. Жижиг дунд аж ахуйн нэгжүүд оруулах нь зөв гэсэн дүгнэлт гарсан. Олон улсад. Тэгэхээр асуух гэж байгаа зүйл бол эхний асуулт нь бол нэгдүгээрт жижиг дунд аж ахуйн нэгжүүдээ яаж дэмжих вэ, ямар оролцоог нь хангах хуулийн заалт нь байна уу гэж асуумаар байна.

Хоёрт нь бол ялангуяа хуулийн 26.3-т заасан байна. Хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчтой түншлэлийн гэрээ байгуулна гээд. Тэгэхээр хамгийн сайн гэдгийг нь яг ямар параметрээр зааж байгаа юм бэ? Хамгийн хямд гэж юм уу, хамгийн чанартай гэж байгаа юм уу, хамгийн инновацлаг гэж байгаа юм уу, аль эсвэл хэрэглэгчид хамгийн бага үнээр тарифтай гэж байгаа юм уу, Энийг асууя.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ. Түвдэндорж.

Г.Түвдэндорж: Батшугар гишүүний асуултад хариулъя. Ер нь бол олон улсын жишгээр хөгжилд өнөөдрийн өндөр хөгжилд хүрсэн орнуудын хамгийн тод жишээ бол дэд бүтцийг олон улсын хөгжлийг тодорхойлох нэг гол хэрэгсэл нь бол тэр тухайн орны дэд бүтэц хэр хэмжээнд хөгжсөн бэ гэдгээр тодорхойлогддог. Үүнтэй холбоотойгоор ер нь бол томоохон далан, цахилгаан станц, хурдны замуудыг 1800 оноос хойш хөгжингүй Америк, Европын орнууд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтуудыг татаж, хувийн хэвшлийн санхүүжилтийн механизмуудыг

татаж, олон санхүүжилтийн эх үүсвэрүүдийг татаж байж энэ том бүтээн байгуулалтуудыг хийж өнөөдрийн энэ хөгжилд бол хүрсэн байж байгаа. Тантай бол санал нэг байна.

Ер нь олон улсад 1990 оноос хойш одоо тээврийн салбарт гэхэд л 1600 гаруй, төр, хувийн хэвшлийн түншлэл хэрэгжсэн. Хөгжиж байгаа орнуудад ер нь сүүлийн жилүүдэд 470 гаруй тэрбум төгрөгийн төр, хувийн хэвшлийн түншлэлүүдийн хөрөнгө оруулалтуудыг хийх хийсэн байж байгаа. Манай энэ хуулийн төслийн гол төрөл байж байгаа. Нэгдүгээрт нь бол хэрэглэгчдээс төлөх төлбөр, хоёрдугаарт нь төрөөс төлөх төлбөр, гуравдугаарт энэ хоёрын хосолсон хэлбэрээр төлөх төлбөрүүд байж байгаа. Тэгээд яг хөрөнгө оруулалтыг хувийн хэвшил хийгээд ямар байдлаар, ямар санхүүгийн эх үүсвэрээр механизмаар буцаж хөрөнгө оруулалтаа нөхөх үү, хаанаас санхүүжих вэ гэдгийн энэ хуулийн төсөл дээр нарийн тодорхойлж зааж өгснөөрөө бас их онцлогтой байж байгаа. Ер нь төрийн хөрөнгө оруулалт болон төсвийн хөрөнгө оруулалт, төслүүдийг хэрэгжүүлэх гадаад зээл, тусламжаар бүх энэ хэрэгцээ шаардлагыг хангаж төслүүдийг явуулах боломжгүй. Яг энэ утгаараа хувийн хэвшлийн санхүүжилтийг, механизмыг оруулж ирж байгаа гэдгээрээ бол энэ хуулийн төслийн гол давуу тал байж байгаа.

Түрүүн 26-гийн сонгон шалгаруулалт дээр хамгийн сайн компанийг үнэлэх гэсэн заалт дээр бол ер нь компанийн хуульд тавигдсан шаардлагууд байж байгаа, сонгон шалгаруулах бүх төслийг шалгаруулах заалтууд байж байгаа. Энэ дээр бол

компанийн хувийн хэвшлийн чадамжийг бол инновац, боловсон хүчин, хөрөнгийн чадвартай байдал хамгийн хямдаар биш хөрөнгө санхүүгийн төслийг хэрэгжүүлэх чадамжийг голуу үнэлж харах юм байгаа юм. Тэгээд ТЭЗҮ судалгаа төслүүдийг bankable төслүүдийг хэрэгжүүлэхэд энэ төр хувийн хэвшлийн түншлэлийн төв байгуулагдана. Энэ дээр мэргэжлийн баг ажиллана. Тэр ТЭЗҮ, судалгааг гаргасны үндсэн дээр 20, 30 жилийн хугацаанд энэ төсөл урт хугацаанд үр өгөөжөө өгч, эдийн засгийн ач холбогдолтой гэж үнэлэгдсэн төслүүдийг бол хэрэгжүүлээд явах юм байгаа юм.

Г.Занданшатар: Одоо 83 санал хураалттай. Батишугар гишүүн тодруулж асууя.

Э.Батишугар: Жижиг дунд аж ахуйн нэгжүүд бол нийт эдийн засгийн дийлэнх нь бүрдүүлдэг. Тэгэхээр жижиг дунд аж ахуй нэгжээ дэмжих ямар заалтууд бодлого байгаа вэ? Жишээлбэл, Америк улсад бол шууд Төв банк нь жижиг дунд аж ахуйн нэгжүүдээ энэ PPP-х болох төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжсэн сан байгуулаад түүгээр дамжуулж явуулдаг юм билээ. Яагаад гэвэл жижиг, дунд аж ахуйн нэгжүүд болон хамгийн олон ажлын байр бий болгодог, эдийн засгийн гол суурь нь байдаг. Тэгэхээр манайд бол яг энэ талдаа ямар бодлого байгаа вэ гэж асуумаар байна аа тодруулж.

Г.Занданшатар: Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Нэгдүгээрт, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв бүх нөгөө төслийнхөө судалгааг

хийнэ, ТЭЗҮ-г нь хийнэ. Тэгээд энэ маань нэлээн тийм өндөр, чадвартай, мэргэжлийн улсуудаас бүрдсэн ийм төв байх юм. Тэгэхээр бол жижиг дундууд маань өөрсдөө ТЭЗҮ хийж чадахгүй шүү дээ. Тэгэхээр бид нар төрөөсөө тэр чадалтай боловсон хүчнүүд нь цугласан, мэргэжилтнүүд нь цугласан тэр баг маань төсөл болгон дээрээ төслийн баг гаргаад, тэгээд төслүүдийн судалгааг нь хийгээд ингээд бэлэн ТЭЗҮ-тэй болгож өгөх байхгүй юу. Энэ бол нэг том дэмжлэг, жижиг дунд бизнесүүдэд.

Хоёрдугаарт жижиг, дундыг дэмжиж байгаа нэг дэмжлэг бол уул уурхай, банк санхүү, батлан хамгаалах 3 салбар энэ хуулиар зохицуулагдахгүй. Тэгэхээр бол бусад үлдэж байгаа салбаруудад бол дийлэнхдээ жижиг дундаж ахуйн нэгжүүд голлож бизнес хийдэг учраас бол энэ жижиг дундууд бол түлхүү хамрагдаж, энэ хууль гарснаар.../минут дуусав/

Г.Занданшатар: Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг бол дэмжиж байгаа. Харин ч нэлээн оройтож гарч байна. Ер нь ялангуяа энэ төсвийн ачаалал их буурна, бүх зүйлийг юу гэдэг юм, төсвийн хөрөнгөөр, төрийн өмчтэй компанийн хөрөнгөөр хийдгээ болих ийм бололцоо, боломж нээгдэж байна гэж миний хувьд харж байгаа. Ялангуяа энэ боомтын хөгжлийн асуудлыг сүүлийн жилүүдэд ярьж байгаа. Энэ боомтыг дагасан суурьшлын бүс, боомт руу явсан авто зам, терминалын талбай ч гэдэг юм уу, боомтыг дагасан суурьшлын

бүстэй сургууль, эмнэлэг ч гэдэг юм уу төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгээд явах бололцоо боломжтой олон ажлууд байж байгаа. Тэгээд энэ хуулийг бол олон хөрөнгө оруулагч нар харж байгаа болов уу гэж би бодож байгаа. Хуучин бол Концессын тухай хууль гэж хуулиар зохицуулагдаад явдаг байсан. Энэ хууль өөрөө бас шаардлага хангахгүй ийм хууль байсан. Тэгээд би юу асуух гээд байна вэ гэхээр одоо төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийж байгаа олон ажлууд байж байна. Тухайлбал, одоо юу гэдэг юм, Ханги Мандалаас 5 толгой хүртэл 414 километр авто замын ажил явж байна. Тэгээд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийнэ гээд түншлэлийн гэрээ хийгээд ордог, эргээд нөгөө компаниа хамгаалдаг асуудал нь байхгүй. Үйл ажиллагааг нь тогтвортой явуулдаг, дэмждэг ийм асуудал байхгүй, олон жил явж ирсэн юм явж ирсэн. Тэгээд энийг хамгаалсан заалтууд энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль дээр чинь орсон юм уу? Ерөөсөө төр, хувийн хэвшлийн түншлэлээр орж ирж байгаа компаниуд ганц л юмыг л харна. Түншлэлээр ороод хийлээ гэхэд төр яаж дэмжих юм, төр дараа нь яаж хамгаалах юм, бидний үйл ажиллагааг яаж тогтвортой явуулах юм бэ гэдэг юмыг л харна. Тийм учраас ийм заалт орсон уу, ороогүй юу гэдгийг нэгдүгээрт хэлж өгөөч гэж хэлмээр байна.

Хоёр дахь асуудал бол энэ түрүүн Наранбаатар гишүүн ярьсан. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль дээр аймаг, нийслэл, үнэт цаас, концесс хийх бололцоо, боломжийг нээж өгсөн байж байгаа юм. Тийм учраас энэ хууль батлагдаад гарах юм бол орон нутаг, төр хувийн хэвшлийн

түншлэлээр томоохон төслүүдийг хэрэгжүүлэх ийм бололцоо боломжийг нь хэр нээж өгсөн бэ гэдэг дээр 2 дахь асуудлаа асууя.

Гурав дахь асуудал бол энэ хуулийн хамрах хүрээ, хууль батлагдсанаараа эхний ээлжид хэрэгжих бололцоо, боломжтой ямар төслүүд байна. Тийм судалгаанууд та бүхэнд байна уу? Тийм бол үүнийг нэрлэж өгөөч гэдгийг бол хүсмээр байна.

Тэгээд эцэст нь хэлэхэд энэ хуулийг олон хөрөнгө оруулагч нар хараад байж байгаа шүү. Үнэхээр Монгол Улсад хийх ашигтай бизнесийн томоохон хэмжээний төсөл хөтөлбөрүүд маш олон байж байгаа. Маш олон байж байгаа. Тийм учраас л юу гэдэг юм, энэ хууль дээр хамгийн гол нь тэр тогтвортой байх, үйл ажиллагааг нь дэмжих энэ тал дээр нэлээн анхаарч ажиллавал нэлээн үр дүнд хүрэх болов уу гэж бодож байна. За баярлалаа.

Г.Занданшатар: Түвдэндорж. 81.

Г.Түвдэндорж: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн үзүүлэх дэмжлэг, баталгааг бол яг хуулийн төслийн 5 дугаар бүлэг бол бүхэлдээ зохицуулсан байж байгаа. Түншлэгч талуудын чиг үүрэг, эрсдэлийн удирдлага, түншлэлийн баталгаа гээд 28 дугаар зүйл дээр түншлэгч талуудын чиг үүрэг гээд, 28-дугаар зүйлээр бол бүхэлдээ баталгаа дэмжлэгүүдийг зааж өгсөн байж байгаа. Мөн 30 дугаар зүйл дээр түншлэлийн эрсдэлийн удирдлагыг бол зааж өгсөн. Түншлэлээр хэрэгжүүлэх

төслүүд дээр маш олон төрлийн эрсдэлүүд гардаг. Тухайн төслийг ТЭЗҮ судалгааны үед, гэрээ хэлцэл байгуулж байх үед, гэрээ хэлцэл байгуулаад барилга, байгууламж бүтээн байгуулалтын ажлууд явагдаж байх үед, тэрнээс хойшоо ашиглалтад орсноос хойш үйл ажиллагаа явуулахад ямар нэгэн давагдашгүй хүчин зүйл, төрөл бүрийн маш олон төрлийн эрсдэлүүд гардаг. Энэ эрсдэл, чиг үүргүүдийг бол хуулиар бол маш сайн процессын дагуу төр нь ямар чиг үүргийг хүлээх вэ, хувийн хэвшил ямар чиг үүргийг хүлээх вэ, эрсдэлүүдээ бол төрийн төсөв санхүүг яаж хамгаалах вэ, өрийн удирдлагаас яаж хамгаалах вэ, хувийн хэвшлийн санхүүжилтийг оруулсан хөрөнгө оруулалтыг яаж хамгаалах вэ гэдгийг бол энэ хуулийн төслийн маш сайн процессжуулж, чиг үүргүүдийг ойлгомжтой, тодорхой болгож оруулснаараа бол төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн ач холбогдолтой. Орон нутгийн эрхийг бол Их Хурлын ажлын хэсэг дээр ярьж байгаад нээсэн. Тухайн аймаг, нийслэлийн тухайн жилийн төсвийн 1/10-тэй тэнцэхүйц хэмжээнд түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийг бол хэрэгжүүлж болно.

Одоо яг энэ хууль батлагдаад хэрэгжүүлж болох хамгийн түрүүнд ямар төслүүд хэрэгжүүлж болох вэ гэдэг дээр бол ер нь Хөх морь төслийг бол хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Говийн бүсүүд рүү усан хангамжийг нийлүүлэх хувь цөөрөм байгуулах, экологийн их сайн төсөл байж байгаа. Мөн уул уурхай, энэ үйлдвэрлэл, бүтээн байгуулалтуудын усаар хангах ийм төслийг бол бүрэн ТЭЗҮ судалгаа нь бол хийгдчихсэн ийм төсөл. Энэ бол урт хугацаанд эдийн засгийн хувьд нь ач холбогдол, үр ашгийг нь сайн

тооцож байгаад хувийн хэвшилд хөрөнгө оруулалт хийгээд ашигтай гэх тохиолдолд бол төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх бүрэн боломжтой байж байгаа. Мөн хурдны зам, боомтууд, боомтын бүтээн байгуулалтууд, нийтийн тээвэр, метро ч гэдэг юм уу, нийтийн тээвэр, хогны менежментийн төслүүдийг ч юм уу хэрэгжүүлэх бүрэн боломжтой байж байгаа.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна. Байнгын хорооны санал, дүгнэлтээс асуулт асууна. Алга байна. Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Энэ хуулиар бол уг нь бол бид нар багагүй асуудлуудыг зохицуулах боломжтой хууль байгаа юм. Орж ирэх нь бол зөв бид нар хэлэлцээд, цааш нь сайжруулаад явах нь бол зөв байгаа юм. Гэхдээ хэд хэдэн эргэлзээтэй бас асуултууд байгаа юм. Тэгээд тэрийг бас та бүхнээс нэгдүгээрт асуучихмаар байна.

Нэгдүгээрт, төсвийн хуультайгаа хэрхэн яаж уялдаж байгаа вэ? Нөгөө дагалдахаар төсвийн хуулиудыг бас харж амжсангүй. Бусад оронд бол ер нь хамрах хүрээ, төсөвт эзлэх хувиар хязгаарлаж өгдөг шүү дээ. Ер нь бол тэгж байж дараа нь бодитой болдог. Тэгээд би яг тийм ерөөсөө олж харсангүй. Тухайлбал Англи бол 10 хувь дотор барьж явдаг. Тэгэхээр тэр чинь нөгөө лоозонгийн шинж чанартай байхаа больчих юм л даа, яг бодит болно гэсэн үг.

Хоёрдугаарт, 3 дугаар бүлэгт төсөл хэрэгжүүлэгч төслийг санаачилж болно гээд орсон байх юм. Энэ бол хэрэггүй байх. Энэ чинь

мэдээлэлд ойрхон байгаа хүмүүс нь л хэнээр байдаг юм таньдаг компаниараа оруулаад л нэг төсөл санаачлуулаад тусдаа нэг ийм шалгаруулалт болоод л явах тийм нөхцөл байдал үүсэхээр харагдаж байна.

Гуравт болохоор энэ салбарын зарим хуулиудаар одоо бол нөгөө төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ бол хэрэгжээд явж байгаа шүү дээ. Одоо тухайлбал сэргээгдэх эрчим хүчний гэрээгээр бид нар нэлээн олон тооны гэрээ тусгай зөвшөөрөл өгчихсөн байдаг. Тэгээд тарифыг нь хуулиар тогтоочихсон, тэгээд бид чинь иргэдийн бүх өрхүүдээс сэргээгдэх эрчим хүчний дэмжлэг гээд мөнгө авч байгаа шүү дээ, хурааж байгаа, одоо бол татвар ишг болчихсон. Гэтэл өнөөдрийн сэргээгдэх эрчим хүчний өртөг тухайн үед бодож байсан өртөг 2 чинь шал өөр газар, тэнгэр ишг болчихоод байгаа байхгүй юу. Бусад оронд бол тэрийг чинь тендерээр хамгийн бага үнэ өгсөн, хамгийн шилдэг технологиор шалгаруулдаг бол, манайд бол эсрэгээрээ зүгээр тэр тарифаар нь зүгээр эрчим хүчний систем доголдох хэмжээнд хүргэхээд байна шүү дээ. 80 тэрбумын ашигтай ажилласан байхад эрчим хүчний систем 79 тэрбумын алдагдалтай ажиллаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээрээ энэ салбарынхаа хуулиудыг хэрхэн яаж зохицуулах юм цаашидаа гэдгийг асуучихмаар байна.

Дөрөвт, концессын хууль гээд л жигтэйхэн гоё хууль гээд л явсан. Тэгээд сүүлдээ бол концессын хулгайчууд болоод дууссан. Тэгээд энэ хууль чинь явж байгаад сүүлдээ баахан төр, хувийн хэвшлийн

түншлэлийн хулгайчууд болоод дуусах вий дээ. Төртэй юм хийсэн болгон ер нь Монголд дампуурч байна шүү. Тэгээд сая Энхтүвшин гишүүний хэлсэн үгийг нь бас дэмжиж хэлмээр байна. Эрх ашгийг нь хамгаалдаг байгууллага алга байна. Тэгээд тэр чинь гэрээгээр зохицуулж байгаа харьцаа бол тэр чинь уг нь бол иргэний хуулиар явах ёстой байтал бүгдийг нь эрүүлжүүлээд хаячихсан. Тэгээд нөгөө компаниудыг нь бүгдийг нь айлгаад, салгалуулаад тэр нь яваандаа аягүй бол тэгээд 10, 20 жилийн дараа энэ хууль болохгүй байна, төсвөөс хамаг мөнгийг нь саадаг хууль боллоо гээд л явна шүү дээ. Тэгэхээр аль алиныхаа тэр хамрах хүрээ, төсөвт эзлэх хувийг бол маш тодорхой зааж өгөхгүй бол яг л дараа нь тийм юм руугаа явна шүү. Том төсөл, том хөрөнгө оруулалтын юмнууд хэрэгжүүлнэ л гээд байх юм. Мэдэхгүй дээ одоо тэгээд гэрээ хийгээд ер нь энэ чинь 4 жилийн циклээр л хамаг юмаа өөрчлөгддөг болчихоод байна шүү дээ. Тэгээд цаашидаа яах юм байгаа юм? Тэгээд энэ хуулийнхаа хамгаалалтын юмаа сайн бодолцож хиймээр байна. Тэгээд саяын асуусан асуултууддаа хариултаа авчихмаар байна. Дараа нь тодруулъя.

Г.Занданшатар: Түвдэндорж. Дэд сайд.

Г.Түвдэндорж: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Төсвийн тухай хуультай бол уялдаж явна. Төсвийн тухай хуульд дагаж өөрчлөлтүүд оруулж байгаа. Өмнөх концессын тухай зохицуулалтуудыг бүгдийг өөрчилж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар гэж өөрчилж явж байгаа. Мэдээж энэ төсөвтэй уялдаж явах нь бол

чухал. Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт түншлэлийн талаарх төрийн байгууллагуудын бүрэн эрх, чиг үүргүүдийг маш сайн ялгаж, зааглаж өгсөн байгаа. Энэ процессжуулж өгөөд төрийн байгууллагууд салбар яамнууд нь ямар үүрэгтэй оролцох юм, яг энэ түншлэлийн төслийг Эдийн засгийн яам нь ямар үүрэгтэй, бодлогоо яаж авч явах юм гэдэг дээр бол оролцоно. Сангийн яам бол төсөв дээр ирэх эрсдэлийг тооцно. Энэ дээр төсөв дээр ирэх эрсдэл, өрийн удирдлагыг Сангийн яам дээр бол бүрэн шинжилгээ хийж тооцно. Яг хуулийн төсөл дээр бол төсөвтэй уялдуулж, хязгаарлалтыг тавьж өгөөгүй. Энэ хуулийн төслөөрөө эдийн засгийн маш сайн тооцоо судалгааг хийгээд хувийн хэвшилд ашигтай байх нөхцөлөөр хөрөнгө оруулалтыг нээж өгөхөөр ийм хуулийн төсөл бол орсон. Тэгэхээр Сангийн яамны чиг үүрэг дээр бол төсөв дээр ирэх эрсдэл, урт хугацаанд төсөв дээр ямар дарамтуудыг учруулах вэ, яаж төсвийн зөв удирдлагыг тогтвортой байдлыг хангах уу, ирээдүйд ямар өр төлбөр үүсэх вэ гэдэг талаас нь маш сайн дүн шинжилгээ хийж, Сангийн яамны зөвшөөрөл өгөөд энэ төслийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэсэн тохиолдолд Засгийн газарт гэрээ байгуулах эрхийг бол нээж өгч байгаа. Ер нь төсөл, эрчим хүчний төслүүдийг аваад үзэх юм бол ер нь төр, хувь хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл бол салбар яамны бодлоготой бол маш сайн уялдуулж өгсөн байгаа. Аль ч төслийг хувийн хэвшил болон төр, салбар яам, орон нутаг аль аль нь бол ижил тэнцүү тэгш эрхтэйгээр төсөл санаачлаад хэрэгжүүлэх боломжтой байгаа. Хэрвээ төр санаачилсан бол төрд хэрэгтэй төслүүдээ өөрсдөө хийх боломжгүй төслүүдээ бол

санаачлаад хувийн хэвшилд гадаадын хөрөнгө оруулагч нарт төслийг зарлаж төслөө хэрэгжүүлэх урилгыг явуулах ийм бололцоог нь нээж өгч байгаа.

Эрчим хүчний төслүүд дээр бол яг салбарын бодлоготой уялдаж чадаагүй нэг гол асуудал бол эрчим хүчний төслүүдийн барих, ашиглах, шилжүүлэх төрлийн одоогийн байгуулагдсан нийт 20 гэрээний бол ихэнх нь эрчим хүчний төслүүд байгаа. Энэ эрчим хүчний төслүүд нь салбарынхаа бодлоготой ерөөсөө уялдаагүй, салбар яамаараа дамжаагүй учраас Монгол улсын жилийн эрчим хүчний хэрэглээнээс 10 дахин илүү хэрэглээний гэрээнүүдийг байгуулсан байгаа. Нүүрсний уурхай болгон дээр цахилгаан станц байгуулах ийм гэрээнүүдийг байгуулчихсан байсан. Тэгэхээр бол салбарын бодлого уялдаатай энэ хуулийн төслийг бол маш сайн уялдуулж явж байгаагаараа давуу талтай байж байгаа юм.

С.Одонтуяа: Тодруулъя, Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Тэгэхээр би нөгөө хамрах хүрээг асуугаад байгаа юм л даа. Ингээд л концесс өгсөн ч, тендер өгсөн ч. Оролцсон байгууллага, уул нь ер нь сүүлдээ ингээд л дампуураад л гарч байна шүү дээ яг одоо бол. Тэгээд энэ сэргээгдэх эрчим хүчний тэр хууль руу хөндөлт хийх үү? Үгүй юу? Дагуулж. Тэр чинь бас ялгаагүй сонгон шалгаруулалтын журам нь нөгөө шударга өрсөлдөөний зарчимд нийцэх ёстой. Сонгон шалгаруулалтын арга хэрэгсэл энэ хуультай чинь нийцэж байх ёстой байхгүй юу. Тэгэхээр тэр дагалдах хуулиудаараа өөрчлөх эсэх асуумаар

байна? Хамрах хүрээ мэдмээр байна. Төсвийн хүрээний мэдэгдлээр яг ийм чиглэлээр бид нар төр хувийн хэвшлийн түншлэлээр хийнэ. Энэ дээд тал нь тэд байна гээд. Бид нар яах вэ үзвэрлэг дээр бол маш сайн амжилттай хийлээ шүү дээ. Яг тэрүүн шиг бид нар жил болгон тэр төсөв дээр нь ч суугаад явж байдаг, гишүүд ч гэсэн ил тод нээлттэй мэдэж байдаг, олон нийт ч гэсэн мэдээллээ авдаг ийм байхгүй бол наадах чинь тэгээд л хөшигний цаана юу болж байгаа нь мэдэгдэхгүй тэгээд л 10 жилийн дараа, 20 жилийн дараа баахан.../минут дуусав/

С.Одонтуяа: Байнгын хорооны дарга Цэрэнпунцаг нэмж хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Ганхуяг гишүүн түрүүн бас асуусан. Тэр төслийг санаачлах эрхийг нь хувийн хэвшлийнхэнд өгч байгааг та буруу гээд байх шиг байна. Тэгэхээр хувийн хэвшлийнхэн чинь энэ санаачилгыг нь авахгүй бол бас юм гарахгүй байна шүү дээ. Үгүй ээ, үгүй яах вэ, энэ чинь бол хувийн хэвшлийнхэнд том боломж л олгож байгаа юм л даа. 3 Санаачлагч байгаа. Энэ төрөөс санаачилна, хувийн хэвшил санаачлан. Ер нь энэ концессын гэрээ яаж хувийн хөрөнгө оруулагчдаа хамгаалах юм бэ гээд байгаа юм. Концесс бол бид нар бас буруу зөвийг, сөрөг талыг нь харлаа шүү дээ. Энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн энэ хуулийн гол агуулга бол ерөөсөө аль аль талдаа байгаа эрсдэлээ л маш нарийн сайн тодорхойлж, тэгээд ялангуяа хөрөнгө оруулагч чинь хувийн тал шүү дээ. Тийм учраас хувийн талаасаа орж байгаа хөрөнгө оруулалтыг хамгаалах, эрсдэлийн нарийн тодорхойлж.../минут дуусав/

С.Одонтуяа: Одоо Жамбын Батсуурь гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль өргөн баригдаж байгаа явдалд бас талархалтай байгаа. Гэхдээ бас л тийм иж бүрэн шинж эндээс ерөөсөө харагдахгүй байна. Энэ хуулийн амин сүнс бол би анхан, дунд шатны эрх мэдлийг өгснөөр энэ төр, хувийн хэвшлийн түншлэл Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт, бүх шатанд явагдана гэж ингэж ойлгодог. Жишээлэх юм бол Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулиар эрхийг нь олгоод, тэгээд үүнтэй холбогдуулан Засгийн газар эрх олгосноор гээд үг ороод л ингээд хумсаа аваачаад шигтгэчихдэг. Өмнө нь бонд гаргах эрх орон нутагт байсан уу гэвэл байж л байсан. Бүх зүйл нь хийгдээд ирэнгүүт яг энэ үгнээс болоод явдаггүй. Нэг сайд дээр юм уу, том хүнд суртал дээр Засгийн газар дээр ирээд гацчихдаг. Тийм учраас анхан, дунд шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурал гэж маш том, өөрийн гэсэн хөрөнгөтэй, өөрийн гэсэн хууль зүйн хэмжээ хязгаартай, хэрэгжүүлэх эрх мэдэлтэй ийм газар байгаа шүү дээ. Энд нь асуудлыг шилжүүлэх замаар энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн үзэл санааг илүү хүчирхэгжүүлж өгөхгүй юм уу. Ер нь энэ дагасан хуулиудад ер нь гол үзэл санаа явдаггүй гол зүйл бол ерөөсөө л бүх сайд нар, бүх яамнууд босоо удирдлагын тогтолцоонд оруулдаг, эрх мэдлийг анхан шатнаас дунд шатанд, дунд шатнаас дээд шатанд татаж явдаг нь л хамаг гол энэ үзэл санааг нь унагачих байх л гэсэн ийм зүйлүүд байж байгаа. Жишээлэх юм бол Монгол улсын хэмжээнд хэдэн сум байдаг билээ. Сумын халаалтын

байгууллагыг бол хувьчлах бүрэн боломжтой шүү дээ. Зөвшөөрөл өгдөггүй. Мөн хот тохижуулах гэрэлтүүлгийн компаниуд, нийтлэг үйлчилгээний газрууд Монголын төрийн нуруун дээр хачиг шиг шахчихсан, түүгээр дамжуулж зүгээр ямар ч үр ашиггүй хөрөнгө оруулалт тусгадаг, энэ зүйлийг таслан зогсоох боломж бол байж байгаа шүү дээ. Тэгээд энэ бүх зүйлийг орон нутагт хийхээр дунд шатанд хийх гэхээр Засгийн газрын эрх олгосноор, яамны эрх олгосноор гээд ингээд бүгдийг нь татаад авчирчихдаг. Тэгээд тэр дунд шатны хурлын ард түмнээсээ сонгогдсон, яг бодит зовлон жаргалаа мэдэж байгаа Иргэдийн Хурлын сүр хүч гэж байхгүй болчихдог. Сумандаа тэр үйл явдлыг даван туулах бүх хүч, сөрөг хүчээ нь байхгүй болгочихдог. Тэгэхээр энийг энэ хуульд иж бүрнээр нь суулгаж өгөхгүй юм уу?

Сая Газрын тухай хууль орж ирж байна. Энэ хуулийн гол хууль нь бол Газрын тухай хуулиуд. Гэтэл газрыг мөн босоо удирдлагатай болоод нэг яамны сайд Монгол улсын бүх нутаг дэвсгэрт томилгоогоо авах юм бол тэнд байгаа зовлон, жаргал, тэнд байгаа төр, хувийн хэвшлийн түншилэл хэзээ ч явагдахгүй. Хэзээ ч явагдахгүй. Тэгэхлээр энэ хуулиар тэр асуудлуудыг нь нээж өгөхгүй юм уу. Засгийн газрын эрх олгосноор, яамны эрх олгосноор гэсэн энэ муурын хумснудаа бүгдийг нь татаж авах хэрэгтэй. Энэ муурын хумснудаа татаж авах хэрэгтэй.

Тэгэхгүйгээр энэ өр авлага, Монгол Улсын төсөв эрүүлжинэ гэж байхгүй. Төр хувийн хэвшлийн түншилэл бол хаана байх вэ гэхээр бие биеэ мэддэг, бие биеэ ойлгодог, тэр шатны хүмүүсийн түншилэл байх

ёстой болохоос тэнд байгаа хүмүүсийн бодлыг энд байгаа яамны сайдтай авчирч байгаад, үгүй бол тэнд байгаа хүмүүсийн хийх гэж байгаа үйл ажиллагааг Засгийн газар дээр хийж авчраад зөвшөөрөл өгнө л гэх юм бол энэ цаашидаа явахгүй болно. Энийг бүрэн нээсэн ийм ойлгомжтой хууль бол болохгүй юм уу гэсэн энэ асуулт байна. Тэгээд хариултыг авсны дараа ахиад тодруулъя гэж бодож байна.

С.Одонтуяа: Эхлээд Байнгын хорооны дарга Цэрэнпунцаг гишүүн хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Батсуурь гишүүний асуусан асуултад хариулъя. Хамгийн гол нь энэ хуулиар хэрэгжих төслүүд маань ерөнхийдөө төрлөөр нь үзэх юм бол 3 төрлийн хууль байгаа. Нэгдүгээрт, өөрөө энэ төлбөр хураамж аваад хэрэглэгч нь төлөөлж явдаг, ашигтай гэж бид нар ярьдаг. Эдийн засгийн үр өгөөжөө өгдөг төсөл байна.

2 дахь нь бол төсвөөс эргэн төлөгддөг том авто зам жишээлбэл. Төлбөр хураамж авах боломжгүй. Хөрөнгө оруулалт их шаарддаг энэ төслүүд бол төслөөс эргэн төлөгдөнө. Тэгэхдээ удаан хугацаанд 15, 20, 25 жилээр төсвөөс төлөгдөх ийм төслүүд.

Нөгөө 3 дахь хэлбэр нь бол холимог. Тэгэхээр зэрэг энэ хамгийн гол нь Монгол Улс бол одоо нэгдсэн улс. Нэг төсөвтэй. Тэгэх дээр төсөв дээр энэ эрсдэлүүд үүсэхээс бол гарцаагүй болгоомжлох хэрэгтэй, энэнээс сэргийлэх ёстой. Өнөөдөр барих шилжүүлэх гэдэг концесс чинь өнөөдөр төсөв дээр энэ том хүнд ачаа авчирч хаячхаад бид нар энэний горьг нь амсаж байна шүү дээ.

Тэгэхээр зэрэг эрсдэлийг бол гарцаагүй харж үзэж, энэ Засгийн газар нь энийг хариуцаж байгаа байгууллага нь, энийг хариуцсан төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль нь, төв нь энэ дээр бол шинжилгээгээ хийнэ, ТЭЗҮ-гээ хийнэ, судалгаагаа хийнэ, тэгээд энэ дээрээ үндэслэж төслүүдээ сонгох нь гарцаа байхгүй нэгдсэн удирдлагатай байх хэрэгтэй байгаа юм. Ер нь өмнөх концессын бас нэг алдаа бол нэгдсэн удирдлага гэж байгаагүй. Тэгээд зөвхөн 2010 оноос хойш 12 жилийн хугацаанд 7 байгууллага дамжсан байдаг юм. Тэгэхээр бол энэ алдааг бид нар засах ёстой. Цаашидаа бол энэ орон нутагт түрүүн нээж өгч байгаа эрх байгаа. Яг хэмжээндээ бол эрсдэлээ даах хэмжээнд нь, тэрнээс буцаад орон нутагт баахан юм хийж хийж ёстой тэр танил талаараа, наагуур цаагуураа нийлж баахан юм хийж найрлаж байгаад нааш нь шиддэг, тэгээд сүүлд нь энэ татвар төлөгчдийн мөнгөнөөс төлдөг юм байж болохгүй гэж. Энэ эрсдэлийг бол бид нар гаргаж болохгүй юм байгаа юм. Тийм учраас бол энэ бид нар нэгдсэн удирдлагатай, энүүгээрээ оруулж гаргадаг байя гээд. Дээрээс нь Их Хурлын гишүүд бид нар ард түмнээ төлөөлөөд сууж байна. Жил болгон бид нар жилийнхээ төлөвлөгөөг ярихдаа ямар ямар төслүүд явахыг бас бүгд мэдэж байх ёстой байгаа юм аа. Тэрнээс өнөөдөр энэ хаяандаа байж байгаа Улаанбаатараа хүртэл юу хийх гэж байгааг мэдэхгүй л сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ бол гишүүддээ бас мэдээлэлтэй байх талаасаа бид нар энэ жил юу юу хийх юм, ямар ямар том төслүүд нь жижгүүд нь, дундууд нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар хэрэгжих юм бэ гэдгийг гишүүд маань

жил болгон тэр жилийнхээ төлөвлөгөөг хэлэлцэж байхад мэдэх боломж нь олгох юм. Дээрээс нь аймаг, сумуудад өөрсдийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиа тодорхойлохын тулд бол энэ зүгээр бид нар шийдчих биш, бас нэлээн нарийн судалгаа шинжилгээ, мэргэжлийн улсууд шаардагдах юм байна лээ. Тэгэхлээр энэ хүмүүс маань ямар цалин шаарддаг билээ. Элбэг, дэлбэг байдаг билүү гэвэл үгүй. Тэгэхээр энэ хүмүүсээ бид нар аль боломжоороо бөөгнүүлж, энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвөө одоогийн статусаар бол Улсын үйлдвэрийн газар гэдэг статустай байгуулъя. Энэ нь өөрөө ашигийн төлөө тэр ашигтай том төслүүд дээр нь ТЭЗҮ-гээ гаргаж өгнө. Тэр гадагшаа энд тэндхийн компаниудаар хийлгэдэг ТЭЗҮ-гээ тэгвэл эндээ хийе, дээрээс нь орлогоо ашиглаад буцаад тэнд ажиллаж байгаа тэр өндөр мэргэжилтэй боловсон хүчнүүдээ бас гайгүй цалин пүнлүүтэй нийгмийн асуудлыг нь шийдэж ингээж хадгалж хамгаалж бас нэг ийм мэргэжлийн чадамжийг бүрдүүлж ажиллахгүй бол бид нар хаа, хаанаа тараагаад тавьчихвал бид нарын гараас чанартай юм гарахгүй ийм л болчих гээд байгаа талууд байгаа учраас энэ хуульд бол өөрийнх нь төр, хувийн хэвшлийн түншлэлийг авч хэрэгжүүлэх байгууллагынх нь бүтцийг нарийн зааж өгч хийж өгсөн.../минут дуусав/

С.Одонтуяа: Жамбын Батсуурь гишүүн тодруулъя.

Ж.Батсуурь: Үгүй ээ, би асуултдаа хариулт авсангүй л дээ. Тэмээ гэхээр ямаа гэж яриад байх юм. Хамгийн гол нь ийм тогтолцоо хийж дээш нь татдагаа болио. Та нар нэг

хартай авгай нар шиг бид нар мэднэ гээд анхан болон дунд шатны бүх эрх мэдлийг дээшээ татдагаа болио. Тэр аймгийн иргэдийн Хурал гэж аймгийнхаа ард түмнээс сонгогдсон, тэрний бодлогыг мэддэг, зовлон жаргалыг нь мэддэг хүмүүсээр нь асуудлыг нь шийдүүлээ, сумын иргэдийн Хурал гэж сумынхаа ард иргэдийн зовлон жаргалыг мэддэг тэр хүмүүсээр нь асуудлыг шийдүүлээ. Битгий эрх мэдлийг нь дээшээ энэ тогтолцоогоор булааж аваад бай гээд байхад шал өөр юм яриад өөр тайлбар хийгээд ингээд тэмээ гэхээр ямаа яриад байх юм. Орон нутгийн эрх мэдлийг өгөхгүйгээр, анхан шатанд эрх мэдлийг өгөхгүйгээр энэ төр, хувийн хэвилийн асуудал цаашаа явахгүй.

С.Одонтуяа: 83 дугаар микрофон. Сангийн яам хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Бид нар төр, хувийн хэвилийн түншлэлийн хуулийн төслийн судалгаа хийж байхдаа өнгөрсөн хугацаанд орон нутгууд бие дааж хэр хэмжээний концессын төслүүд хэрэгжүүлсэн, түүнийгээ яаж төлсөн, төсвийнхөө төсөвт нь хэр хэмжээний эрсдэл учруулсан гэдэг судалгаанууд хийж үзсэн. Ер нь олон улсдаа ч гэсэн тэр энэ төр, хувийн хэвилийн түншлэлийн гэрээнүүд заавал эргэж төлөгддөг, төлбөр санхүүжилт байдаг учраас төсвийнхөө чадамж эрсдэлтэй бол заавал уялдаж авдаг. Тийм учраас эхний санхүү, төсвийн удирдлага цоо шинэ хууль эрх зүйн зохицуулалт оруулж ирж байгаа учраас аймгууд маань яг тухайн жилд хийгдэх нийт дүн нь бол тухайн жилийн төсвийнхөө 1/10 -тэй тэнцүү байхаар тэгээд Сүхбаатар аймгийн сүүлийн

жилийн төсвийг харах юм бол 6-7 тэрбумын жилд түншлэлийн гэрээ хийгээд явах эрхийг нь бол тавьж өгч байгаа. Засгийн газрын чиг үүрэг дээр эрх олгох асуудлыг тусгасан боловч энэ үйл ажиллагааг журмаар зохицуулах юм. Тэр журмын хүрээнд аймаг өөрийнхөө саналаар.../минут дуусав/

С.Одонтуяа: За Батсуурь гишүүн тодруулъя. Асуултад нь яг дэлгэрэнгүй, тодорхой хариулт өгмөөр байна.

Ж.Батсуурь: Үгүй ээ, яах вэ, ойлгоод л байна л даа. Энэ засгийн газрын эрх олгосноос, олгосноор нь гэдэг энэ муурын хумснудаа татаж аваач ээ л гээд байгаа юм. Ерөөсөө аймгийн иргэдийн Хурал, сумын иргэдийн Хурал гэж ер нь юу гэж байгаа юм. Ер нь орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг байгуулаад яагаад 30 жил болж байгаа юм. Яг сайхан төлөвшөөд л ирэнгүүт нь босоод тогтолцоонуудаар бүх эрх мэдлүүдийг нь авчихдаг. Тэнд байгаа зовлонг энд мэдэхгүй байж байж тэнд байгаа эрхийг нь булааж аваад байдаг байхгүй юу. Тэр Баян-Өлгийд байгаа сумд, тэр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд байгаа зовлонг энд байгаа яамныхан мэдэх үү? Мэдэхгүй. Тэр аймагт байгаа зовлонг мэдэхгүй. Тэгээд ямар үг очдог вэ гэхээр Засгийн газар эрх олгосноор. Тэгээд энд ирээд нэг яамны сайдын эрх, юуг хараад суучихдаг, үгүй бол Засгийн газар руу явсан бичиг ирэхгүй.

С.Одонтуяа: Хэн хариулах уу, Сангийн яам Дэлгэржаргал уу? За хариул.

Ж.Дэлгэржаргал: Хуулийн төслийн 11 дүгээр зүйл дээр бол

аймаг, нийслэлийн иргэдийн Хурал болон Засаг даргын бүрэн эрхийг бол тодорхойлж өгсөн байгаа. Тэгэхээр эрх олгоно гэдэг маань яг таны хэлсэнтэй санал нэг байна. Бид нар төсөл болгон дээр Засгийн газар оролцоод эрх олгох асуудал биш байгаа юм. Яг энийг аймагт орлох асуудлын Засгийн газрын чиг үүрэг дээр тавьчхаад, харин тухайн журмаараа тэндээ шийдэж авахаар бас дагалдсан ийм зохицуулалтууд орсон байгаа. Тэгэхээр тэнд орон нутаг бие даан хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээнүүдийг, тухай бүр нь Засгийн газар батлаад юм уу, хэрэгжүүлэх эрхийг нь олгоод явахааргүй байгаа. Яагаад гэвэл дагалдах зохицуулалтууд нь бол журмаар зохицуулна, журмынхаа хүрээнд орон нутаг бие даагаад хэрэгжүүлэх эрхийг нь нээж өгсөн байгаа.

С.Одонтуяа: Одоо Тилеуханы Аубакир гишүүн асууна. Тэгвэл Нямаагийн Энхболд гишүүн эхлээд асууя.

Н.Энхболд: Энэ хууль гарахыг дэмжиж байгаа. Үндэслэлүүд байгаа. Ер нь аливаа бүх асуудлыг Засгийн газар хийх боломжгүй. Тийм маягаар явъя гэвэл эргээд нөгөө төлөвлөгөөтэй, захиргаатай эдийн засаг дэглэм рүүгээ орохоос өөр аргагүй болно. Нэг шалтгаан нь. Нөгөөдөх нь засаг их том том зорилтууд тавьчихсан байгаа. Урт хугацааны, дунд хугацааны. Энэ юмнуудыг дангаараа бас өөрөө хэрэгжүүлж чадахгүй. Заавал хувийн хөрөнгө оруулалт, хувийн хэвшилтэй хамтарч хийхгүй бол энэ бодлого ч биелэхгүй, ер нь цаашидаа ажлууд ч явахгүй. Тийм учраас энэ хуулийн хэлэлцүүлгийг дэмжиж байгаа. Нэг

асуулт байгаа. Энэ уг нь анх хэлэлцэх эсэхийг ярихад л яригдаж байх ёстой зүйл л дээ. Гэхдээ Байнгын хороо дээр яригдсан уу, үгүй юу? Ийм ажлыг хийхийн тулд хувийн компаниуд заавал тийм тусгай зориулалтын компани нээх хэрэгтэй байх уу. Тэгж байж гэрээ хийх үү. За тэрэнд хариулаарай. Тэгээд яагаад гэвэл энд биччихсэн байна л даа. Тусгай зориулалтын компаниар дамжуулж хийнэ. Тэр нь 5.1.20 дээр байгаа ийм тусгай компани байна гэж. Тэгэхээр ингэж заавал тусгай зориулалтын шинээр компани байгуулна гэдэг нь ямар учиртай юм бэ? Байнгын хороо дээр яригдсан уу? Ер нь энэ ажлыг тэгээд нэлээн чадалтай хөрөнгө оруулалт хийх боломжтой, техник технологи, хүний нөөцийн хувьд сайн түүхтэй компани байж байж л энэ том төслүүдийг хийнэ шүү дээ. Түүнээс цоо шинэ компани байгуулаад хийнэ гэвэл тэр компанийн ард заавал нэг тийм юутай юм байж таарна. Боломжтой, хөрөнгөтэй, сайн түүхтэй компани байж байж энийг зохион байгуулна. Түүнээс цоо шинээр ийм дундын компани гарах их төвөгтэй. Хэрэв ард нь ийм компани байна гэж үзвэл тэгвэл 27.1.6 гэдэгтэй зөрчилдөхгүй юу. Нэг болохоор тусгай компани заавал байна гээд заачихсан, нөгөө талд нь энэ тэр гол хөрөнгө оруулагч хамаардаг, элдэв янзын юмтай, хамааралгүй байх ёстой гээд, өөрөөр хэлбэл цоо шинэ маш шинэ түүхтэй, шинэ хүүхэд шиг ийм юм гаргаж ирэх гээд байгаа байхгүй юу. Энэ 2 чинь хоорондоо хэр уялдаж байгаа юм бэ? Ийм боломжтой гэж үзэж байгаа юм уу. Өнөөдөр тийм том төслийг цоо шинээр компани байгуулаад хэнээс ч хамааралгүй, урьд нь сайн түүхтэй, хөрөнгө оруулагч компани, охин компани ийм юмгүйгээр том

төсөл хийх юм цаасан дээр л гарч ирнэ шүү дээ. Энэ 2 чинь хоорондоо яаж уялдаж байгаа юм бэ? Өөрөөр хэлбэл 5.1.2 чинь 27.1.6-тай яаж уялдаж байгаа юм бэ л гэдгээ хариулчих.

С.Одонтуяа: Түвдэндорж дэд сайд хариулъя.

Г.Түвдэндорж: Энхболд гишүүний асуултад хариулъя. Тусгай зориулалтын компанийг бол 5.1.20 дээр заавал ч үгүй байгуулах ёстой биш, тусгай зориулалтын компанийг бол байгуулж болно. Энэ тусгай зориулалтын компанийг байгуулах гол үндэслэл нь бол гадаадын хөрөнгө оруулалттай компани, дотоодын компанитай түншлэх эсвэл төртэй хамтарсан байдлаар түншлэх юм уу, ийм тохиолдолд санхүүгийн хөрөнгө оруулагчид, зарим яг түншлэлийн жишиг хуулийн дагуу бол энэ зохицуулалтыг хийж өгсөн байдаг. Энэ бол зайлшгүй байх ёстой. Гэхдээ хувийн хэвшил энийгээ өөрөө л шийднэ. Заавал тусгай зориулалтын компани байгуулна гэсэн үг бол биш. Байгуулахгүй ч байж болно. Энэ тусгай зориулалтын компанийг 42 дугаар зүйлээр бол зохицуулж өгсөн байж байгаа. Хувийн хэвшлийн түншлэгч төсөл хэрэгжүүлэх тусгай зориулалттай компанийн бүтэц, зохион байгуулалт гээд 42 дугаар зүйл дээр үндэслэлүүдийг нь заагаад өгсөн байгаа. Гэрээгээрээ зохицуулаад л явах, заавал байгуулах асуудал биш.

С.Одонтуяа: Нямаагийн Энхболд гишүүн тодруулъя.

Н.Энхболд: Тусгай зориулалтын компани байж ч болно, байхгүй ч байж болно гэж ойлголоо. Тэр тохиолдолд дахиад өнөөдөр үйл

ажиллагаа хэвийн явуулж байгаа компани өөрөө төртэй гэрээ хийгээд ажил хийж болно биз дээ. Тэрийг хориглосон зүйл энэ дотор байхгүй биз дээ. Тийм ээ. Оролцогч компанийн эцсийн өмчлөгч болон хараат охин компани харилцан хамааралгүйгээр хамтарч оролцохгүй байх. Их том компаниуд байна шүү дээ. Юу гэдэг юм нэгэн зэрэг ган хийц ч хийчихдэг, барилга ч барьчихдаг юм байж болно. Төмөр замынхаа ажилд оролцъё гээд нэг нь орох гэсэн чинь 2-уулаа хамтарч байж тэрийг хийдэг тэгэхээр болохгүй нь байна шүү дээ. Хамааралтай компани болно. Нэг эзэнтэй байж таарна. Тэрийг яаж зохицуулах вэ?

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Түвдэндорж дэд сайд.

Г.Түвдэндорж: Яг энэ асуудлыг бол найруулгаар засаж байгаа. Групп компани маш олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг, санхүүгийн байгууллагатай барилга угсралтын компанитай, эрчим хүчний инженерингийн компанитай ч юм уу, энэ компани бол хамтраад сонгон шалгаруулалтад оролцож болно. Зэрэгцээ нэг төсөл рүү сонгон шалгаруулалтаар 2, 3 компаниараа 1 төсөл рүү оролцохгүй гэсэн ийм зохицуулалтаар орж ирж байгаа. Хамтарч оролцоно, гэхдээ 3 компани оруулаад 1 эзэмшилтэй 3 компани ороод 1 төсөл дээр өрсөлдөж орохгүй л гэсэн ийм зохицуулалттай явж байгаа.

С.Одонтуяа: Энхболд гишүүн ээ, хариулт хангалттай юу. Одоо Тилеуханы Аубакир гишүүн асуулт асууна. Гишүүдээ танхимдаа орж ирж сууцаана уу. Одоо 83 саналын томъёоллоор санал хураалт байгаа.

Т.Аубакир: Баярлалаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг бол цаг үеэ олсон яг манайд шаардлагатай бас нэг хууль орж ирж байгаад баяртай байгаа юм. Миний хувьд бол дэмжиж байгаа. Энэ дээр хоёрхон асуулт асууна. Гишүүд олон асуулт асуусан юм чинь ажлын хэсгийнхнээс би 2 асуулт асууя.

Олон улсын туршлагаас үзэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхэд судалгаа шинжилгээ маш чухал байдаг. Тийм учраас эдгээр олон улсын туршлагыг ер нь мэргэжлийн түвшний судалгаа хийсэн үү? Шинжилгээ ТЭЗҮ-гээр гаргаж ирсэн яг ямар ямар судалгаа хийсэн бэ? Энэ дээр ажлын хэсэг нэгдүгээрт хариулаад өгөөч.

Хоёрдугаарт, концессын хууль 2010 онд батлагдаад 12 жил болж байгаа. Энэ хуулийн хэрэгжилтийг дүгнэвэл ер нь ямар байна? Концессын хуулиас ялгаатай зүйлсийг нь бас хэлэх хэрэгтэй байна. Энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, концессын хуулиас яг ийм ийм зүйлээрээ ялгаатай юм гэж. Тэгээд энэ оруулж ирж байгаа хуулийнхаа батлагдах юм бол нэгдүгээрт, хоёрдугаарт, гуравдугаарт ийм ийм дэвшилтэт зүйл байгаа юм гээд 1, 2, 3 зүйл нэрлээд өгөөч надад. Нэгдүгээрт ийм, хоёрдугаарт ийм, гуравдугаарт ийм дэвшилтүүд гарах юм гэж. Би бол Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бол хувьдаа дэмждэг хүн. Төр бол зарим ажил үйлчилгээг хувийн хэвслээр гүйцэтгүүлэх хэрэгтэй. Төр бол одоо жишээлбэл, нэг сумын төвийн сургуулийн качкар хийгээд байх шаардлага байхгүй. Хувийн хэвслээрээ хийлгэх, гүйцэтгүүлэх хэрэгтэй гэх зэргээр бол би төр,

хэвшлийн түншлэлийг бол хувьдаа дэмждэг хүн. Тийм учраас энэ хуулийг бол дэмжиж байгаа. Саяны миний асуусан асуулт дээр олон улсын яг ямар ямар туршлагауудыг яаж яаж судалсан бэ? Хоёрдугаарт, Концессын хуулиас ялгаатай зүйл нь яг юу байна. Энэ дээр хариулаад өгөөч гэж.

С.Одонтуяа: Дэд сайд хариулъя. Түвдэндорж.

Г.Түвдэндорж: Аубакир гишүүний асуултад хариулъя. Ер нь бол төсөл хэрэгжүүлэх, амжилттай хэрэгжүүлэх нь бол судалгаа шинжилгээ хамгийн чухал байдаг. Тухайн төслийг хэрэгжүүлэхийн бэлтгэл үе шатанд судалгааг бол маш сайн нарийн тооцож хийх нь бол маш чухал байдаг. Бараг төслийн 70 хувь нь л гэсэн үг. Тэгэхээр энэ судалгаа, шинжилгээг хийхийн тулд энэ хуулийн төсөл дээр нэг шинэлэг тал нь түрүүн хэд хэд дурдсан. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийг байгуулж байгаа. Энэ төв бол яг bankable хөрөнгө оруулалт хийхэд боломжтой, ашигтай гэсэн төслийг бэлтгэж гаргаж ирнэ. Мэргэжлийн дэмжлэг үзүүлнэ, боловсон хүчнийг бэлтгэнэ, мэргэжлийн баг энэ төв дээр ажиллана, төслийн анхан шатны үнэлгээ болон бүрэн шинжилгээнүүдийг хийнэ. Төсөл хэрэгжүүлэх хэлбэрүүдийг тодорхой болгоно, эрсдэлүүдийг үнэлнэ, мэргэжлийн арга зүйгээр энэ төв хангаж ажиллах олон улсын бол туршлагаараа ийм байдаг. Тэгэхээр энэ төвийг байгуулж байгаа нь бол онцлогтой.

Концессын тухай хуулиас юугаараа ялгаатай вэ гэвэл энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль бол маш ойлгомжтой,

тодорхой заалтуудыг олон хэлбэрээр бол оруулж өгсөн байгаа. Төрийн байгууллагуудын эрх, чиг үүргүүдийг маш сайн тодорхойлж, нарийн процессын дагуу явах үе шатуудыг нарийн сайн тооцож өгсөн. Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилтийн төрлийг тодорхой зааж өгсөн байгаа. Эргээд хөрөнгө оруулалтуудаа ямар хэлбэрээр нөхөх вэ гэдэг энэ санхүүжилтүүдийн хэлбэрийг зааж өгсөн. Төслийг зарлах, сонгон шалгаруулах процессуудыг маш сайн тусгаж өгсөн.

Тавдугаар бүлэг дээр бол түншлэгч талуудын үүргийн баталгаа Засгийн газар, төрийн байгууллагууд ямар үүрэг хүлээх вэ, ямар баталгаа өгөх вэ, ямар дэмжлэгүүдийг хувийн хэвшилд өгөх вэ гэдгийг бол нарийн сайн зааж өгсөн байгаа. Гэрээ хэлэлцээрүүдийг бол олон улсын жишигийн дагуу яаж гэрээ хэлэлцээр байгуулах вэ, хэдэн төрлөөр байгуулах вэ гэдгийг бас маш сайн зааж өгсөн байгаа. Түншлэлийн сан байгаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн санг бас байгуулж байгаа. Энэ сан бол ирээдүйд хэрэгжих төслүүдийг бэлтгэхэд хэрэгжүүлэх ийм сан байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжиж байгаа төслүүдээс төсөл амжилттай хэрэгжсэн тохиолдолд гэрээ байгуулсан тохиолдолд энэ сан хураамжуудыг авдаг, энэ сангаараа дамжуулж бэлтгэл үе шатанд гарч байгаа мэргэжлийн байгууллагуудын чиг үүрэг, мэргэжилтнүүдийн цалин хөлсийг бэлтгэх, ТЭЗҮ бэлтгэх зардлуудыг гаргана. Хуулийн төсөл бол ер нь хөрөнгө оруулагчдад бас нэг тодорхой, ойлгомжтой байх зүйл бол хэрвээ маргаан гарах тохиолдолд, эрсдэл гарах тохиолдолд яах вэ гэдгийг бол маш сайн тооцож өгсөн.

Хувийн хэвшил хөрөнгө гаргаад төрийн ямар нэгэн буруутай үйл ажиллагаанаас болоод оруулсан хөрөнгө оруулалт нь эрсдэлд орох тохиолдолд ямар хуулиар зохицуулах уу, аль улсын хуулиар зохицуулах уу, иргэний хуулиар зохицуулах уу, захиргааны хуулиар зохицуулах уу, олон улсын арбитраар зохицуулах уу гэдгийг хөрөнгө оруулагч талд нээлттэйгээр зохицуулж өгсөн ийм эрх зүйн зохицуулалтууд байгаа.

Энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсанаар бол ил тод, нээлттэй эдийн засгийн сайн төслүүдийг хэрэгжүүлнэ, зөв менежментийг оруулж ирнэ, өрсөлдөөнийг маш сайн дэмжинэ. Хамгийн гол асуудал.../минут дуусав/

С.Одонтуяа: Байнгын хорооны дарга нэмж хариулахын өмнө мэндчилгээ хүргэе.

Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар Багахангай, Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ард иргэдээ ажилтай орлоготой, эрүүл аюулгүй орчинд амьдруулахын төлөө сэтгэл зүрх... Пүрэвдорж гишүүн амжилт хүсэж, мэндчилгээ дэвшүүлээ. Та бүхэнд бас ажлын амжилт хүсэн ерөөе.

Улсын Их Хурлаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг хэлэлцэж байна.

Саяны асуултад нэмж Эдийн засгийн байнгын хорооны дарга хариулна.

Ц.Цэрэнпунцаг: Аубакир гишүүн ээ, Та 3 онцлогийг нь хэлээд өгөөч гэсэн. Нэгдүгээрт, хувийн хэвшилд гардаг эрсдэлийг нарийн тооцож, хамгийн бага хэмжээнд энэ эрсдэлийг болгох энэ давуу тал бол энэ хуульд байгаа. Хувийн хэвшлийгээ хамгаалах гэсэн үг. Нэг талдаа хөрөнгө оруулагчдаа.

Хоёрт, төсөв дээр ирдэг ачааллыг багасгана. Ялангуяа нөгөө дампуу барих, шилжүүлэх гэдэг концепциор хийгдсэн нөгөө дампуу хуулийг засаж байгаа. Хамгийн гол давуу талтай.

Гурав дахь нь бол ерөөсөө урьдчилсан хийх үү, хийхгүй юу гэдгээ бид нар нөгөө 7 хэмжисж 1 огтолно гэдгээр судалгаа шинжилгээ, тэр ТЭЗҮ, үндэслэлүүдийг нь бол сайн гаргаж ирж байж. Энэ төслөө хэрэгжүүлэх юм байна гээд тэр үндсэн дээрээ хийдэг ийм 3 давуу талтай.

Тэгээд та 2010 онд гарсан концесийн хуулийг дүгнээд хэлээч гэж байна. Энэ бол үндсэн дампуу хууль байсан. Одоо бид нар горьг нь амсаад байж байна. Ялангуяа тэр барих, шилжүүлэх хэлбэр бол өнөөдөр ер нь сайн туршилага судлаад явсан бид нар, манай багийнхан, ажлын хэсгийнхэн Солонгост очиж үзлээ. Үгүй ээ, бид нар барих шилжүүлэхээ асуусан чинь хэзээ ч Солонгос улс тийм төрлийн хамтын ажиллагаа байгаагүй, байж болох ч үгүй зүйл гэж байна лээ. Тэгэхээр бид нар буруу хэлбэртэй ийм хамтын ажиллагаа үүсгэж явсан юм байна гэж ингэж дүгнэж байгаа юм.

С.Одонтуяа: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Нийт зарчмын зөрүүтэй 83 санал байна. Гишүүд танхимдаа судлаа эзэлцгээе. Зарчмын зөрүүтэй санал дээр асуулт хариулт байхгүй. Дэмжсэн болон дэмжээгүй гишүүд үг хэлж болно. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн саналууд:

Нэг. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хүүлийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

1.Төслийн 3.4 дэх хэсгийн “хөрөнгийг” гэснийг “хөрөнгийн эрхийг” гэж, 3.7 дахь хэсгийн “холбогдох хууль тогтоомжид” гэснийг “энэ хуульд” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/.

Үг хэлэх гишүүд алга байна. Санал хураалт. Нийт 55.8 хувийн саналаар нэг дэх санал дэмжигдлээ.

2.Төслийн 3.2.1 дэх заалтын “үндэсний аюулгүй байдал”, 3.7 дахь хэсгийн “мэргэжлийн зөвлөхтэй” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.8 хувийн саналаар саналын томъёоллын 2 дахь санал дэмжигдлээ.

3.Төслийн 3.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.5.Түншлэлийн хүрээнд бусдын эзэмшил газрыг нөхөх олговортой солих буюу эргүүлэн авах асуудлыг Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.8 хувийн саналаар батлагдлаа.

4.Төслийн 5.1.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдээ анхааралтай байна шүү. 56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 5.1.14 дэх заалтын “/нийтийн үйлчилгээ/” гэснийг хасаж, 5.1.23 дахь заалтын “нийтийн” гэснийг “төрийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59.1 хувийн саналаар дэмжигдсэн байна.

6.Төслийн 5.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 5.1.32 дахь заалт нэмэх:

“5.1.32. “Засгийн газрын баталгаа” гэж түншлэлийн төслийг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан Засгийн газрын хүлээсэн үүргийг.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Сэргэлэнгийн урилгаар Хил хамгаалах байгууллагын ахмад хилчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд нийт Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс мэндчилгээ дэвшүүлж, эрүүл энх, сайн сайхан

бүхнийг хүсэн ерөөе. Нэг хүнд бас онцгойлон мэндчилгээ дэвшүүлье.

Манай Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Сэргэлэнг шинэ цэрэгт алба хааж байхад Заставын даргаар нь ажиллаж байсан Хурандаа Саандар гуайд тусгайлан сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байна.

Санал хураалтдаа орёе гишүүд ээ,

7.Төслийн 6.1.1 дэх заалтын “талаарх стратеги, бодлого болон мэдээллийг,” гэснийг “зорилт, арга хэмжээг” гэж өөрчлөн, 6.1.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 7.1.7 дахь заалтын “зорилгоор” гэсний дараа “хувийн хэвилийн түншлэгчтэй тохироцсоны дагуу” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.8 дахь заалт нэмэх:

“7.1.8.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21, 24 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аймаг, нийслэлд түншлэлийн төсөл бие даан хэрэгжүүлэх эрхийг аймаг, нийслэлийн нэг жилд хийх түншлэлийн гэрээний нийт үнийн дүн нь тухайн аймаг, нийслэлийн жилийн төсвийн аравны нэгээс хэтрэхгүй байхаар олгох.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал байна.

Нямаагийн Энхболд гишүүнд микрофон өгье.

Н.Энхболд: Гишүүдийн дунд нэлээн асуулт үүсгээд байсан заалтуудын нэг байна. Засгийн газраас орж ирсэн дотроо ийм заалт байхгүй байгаа. Ажлын хэсгээс, Байнгын хорооноос нэмсэн заалт юм байна. Яг ингээд хийчихээр заавал 1/10 хүртэл хувиар гэрээ хийж байх ийм байдалтай гэж ойлгоод явах вий. Угаасаа өөрсдөө төсвөөс санхүүжилт авдаг аймгууд зөндөө олон байгаа шүү дээ. Тэгээд төсвөөс очсон мөнгөний 1/10-ээс нь гээд яваад байвал тэр чинь нөгөө түрүү зарим гишүүдийн яриад байгаа Байнгын хорооноос тайлбайрлаад байгаа улсын төсвийн мөнгийг очсон хойно нь аймаг өөр юманд зарцуулах эрх нь нээгдэх вий дээ. Тэгэхээр би 2 дахь хэлэлцүүлэг дээрээ энийг бодож үзээсэй гэж бодож байна. Энэний оронд харин энэ хуульд эсхүл холбогдох хуульд нь төсвөөс оруулж байгаа мөнгөөр ийм ажил хийвэл тэрийг төвд заавал авч улсын төсвөөс авсан бол төвд байдаг улсын төсөв хянадаг байгууллагаар нь шалгуулна. Орон нутаг өөрөө бүх зардлаа даагаад дээр нь илүү орлого олоод тэрүүгээрээ ийм гэрээ байгуулъя гэвэл тэр 100 хувь хийнэ үү, 10 хувь хийнэ үү орон нутгийн өөрийнх нь эрхийн асуудал, Хурлынх нь эрхийн асуудал маягаар томъёолж эрхийг нь нээж орхих нь зүйтэй болов уу гэж би бодож байна. Тэгэхгүй бол улсын төсвөөс очсон мөнгөний 10 хүртэл хувиар бид нар хийж болно гэж ойлгоод явчихвал болохгүй шүү дээ. Угаасаа зарчимд нийцэхгүй. Тэгэхээр санал хураалгаад яаж гарахыг мэдэхгүй. Дахиж яриад чиглэл өгүүлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Би тэр орон нутагт

тодорхой эрх байхыг ерөөсөө эсэргүйцэхгүй байгаа. Гэхдээ чадах юмаараа түншиллээ хийх хэрэгтэй. Чадахгүй байж багшийнхаа цалинг тавьж чадахгүй төсвөөс мөнгө авдаг байж тэрийгээ хурал мэдээд өөр юманд зарцуулна гээд Улсын Их Хурлаар баталсан төсөв мөнгөний 10 хүртэл хувиар зарцуулаад байж болохгүй шүү дээ. Энэ ялгаа зөрүү, агуулгыг сайн тодруулж, томъёолж байж энийг хураах хэрэгтэй байх гэж бодоод байна.

С.Одонтуяа: Ж.Сүхбаатар гишүүн санал хэлнэ.

Ж.Сүхбаатар: Би Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд байр сууриа хэлье. Засгийн газрын өргөн барьсанд байхгүй байсан гэж байна шүү дээ. Би ч гэсэн нэгжийн хууль дээр ажлын хэсэг ахлаад батлуулсан хүмүүсийн нэг. Зарчим нь бол улсын төсөвтэй юм уу, орон нутгийн төсөвтэйгөө шууд уях нь буруу байгаад байгаа юм. Нэг хэсэг энэ олон жилүүдэд зөв байсан. Ер нь улсын төсөв дулдуйдаж л амьдарлаа шүү дээ. Одоо Улаанбаатар хот нь хүртэл улсын төсвөөсөө хамааралтай явж байгаа шүү дээ. Бусад газар бол том хотууд бол бие даасан төсөвтэй, улсын төсөвт нь багтдаггүй л байхгүй юу. Тийм учраас өөрсдөө өр зээл үүсгээд явж болдог. Хотууд дампуурдаг байхгүй юу. Манайхны ойлголт болохороо улсын төсөв гэдэг нэрийн доор хотын төсөв гэдэг ойлголт байдаггүй байхгүй юу. Тэгэхээр бүх юмыг нь боймолчиж байгаа юм. Бусад улс оронд хот дампуурдаг юм шүү дээ. Тэгэхээр энэ бол төсөвтэй уяахаас илүүтэй цаашидаа Улаанбаатар хот, Дархан хотууд бол өөрийн төсвийн мөнгөн хөрөнгийн сан гэдгээ нэмэгдүүлээд

эхний ээлжинд бол эхлээд өмчтэй болох чиглэлд нь бид явж байгаа. Аймаг, нийслэлийн өмч гэсэн нэгжийн хуулиар сум, дүүргийн өмч гэж бий болгосон. Одоогоор өмч бий болоогүй байгаа.

Гэхдээ тухайн аймаг, нийслэл сум, дүүрэг өмч нь нэмэгдэхийн хирээр орлогын бааз суурь нэмэгдэхийн хирээр хүчин чадал нь тэрүүгээрээ тодорхойлогдох ёстой болохоос биш төсвөөр тодорхойлогдох ёсгүй байхгүй юу. Төсөв нь том байвал орлого олдог бол тэдийн тэдэн хувь гээд. Жишээлбэл, Станбул гээд Туркын хотын захирагчаар нь одоогийн Ерөнхийлөгч Ирдиган ажиллаж байсан. Ирдиган тэнд тэр үеийн түгжрэл агаарын бохирдлыг юу хийж шийдсэн бэ гэхээр Станбул хот өр зээл үүсгэж бонд их гаргаж байгаад маш их хэмжээний мөнгө өр зээл үүсгэж байгаад нүхэн гарц, гүүрүүдийг байгуулж газ автобус руу шилжүүлээд тухайн үедээ тэр асуудал шийдвэрлэгдэж байсан. Тэрнээс улс нь шийдэж өгөөгүй. Тэрэн шиг аймгууд, нийслэл хотуудыг улсын төсвөөр хөгжүүлнэ гэж хэзээ ч байхгүй. Хувийн хэвшил дангаараа чадахгүй. Тэгэхээр хүчин чадалтай аймгууд эхнээсээ бий болж байна шүү дээ. Дархан, Өмнөговь, Дорноговь гээд хүчин чадал өндөртэй аймгууд бий болж байна. Нэгжийн хуулиар ч гэсэн бид боломжийг нь олгосон. Ирэх жилээс Өмнөговь улсын төсвийн орлоготой харьцуулахад боломжийн хэмжээний орлогыг бид нар зарцуулах боломжийг нээж өгсөн. Яах вэ, хаах гэж оролдож байгаа юмнууд байгаа байх. Гэхээр хандлагаа бодохгүй бол одоо бонд өр, зээл үүсгэчих вий гэж айж байгаа айдас байгаагүй ч гэсэн 1/10 гэхээр төсөвтэй уячихаар сахилга баттай юм байна гэж байгаа

ч гэсэн бид нарын тавьж байгаа зорилтод нийцэхгүй болох байх. Ер нь бид нар бүх аймгуудаа ядуу байхыг дэмждэг. Нэг бол орлоготой байгаа аймгуудаа чөдөрлөх гэж оролдог. Хэзээ хаана хөгжих юм бэ гэж. Улсын төсвөөрөө дандаа хөгжүүлэх юм уу. Ийм асуудлууд дээр хандлагын өөрчлөлтийг Улсын Их Хурал харин өөрчилж яваа. Харамсалтай нь манай зарим нөхдүүд аль ч шатанд бас ойлгохгүй гацааж байгаа. Мэдээж манай төсвийн сахилга муу байгаа нь үнэн. Гэхдээ бид хөгжлийн шат руу орохын тулд төсөв нь хөгжлийн л байх ёстой. Бодлогын хувьд. Тэгэхээр энэ 1/10 гэдгийг бол ер нь хязгаарласан идэвхгүй байгаа аймаг, нийслэл дандаа хулгайч нар байдаг эсхүл буруу зарцуулчих вий гэдэг эсхүл боловсрол нь дутна гэж боддог юм уу энэ хандлага бол одоо эхний 20 жил болоод л байсан. Одоо дараагийн хөгжлийн шинэ сэргэлтийн бодлого алсын хараа гэж яриад төлөвлөлттэй болж байна. Өнөөдөр Улаанбаатар хот завсрын төлөвлөгөөтэй явж байгаа шүү дээ. Хот төлөвлөлт нь тодорхой болоогүй. Тэгэхээр нэгэнт төр нь төлөвлөлт бүх юм нь тодорхой болвол илүү боломжийг нь олгох ёстой. Эхлээд хязгаарлагдмал явах ёстой. Гэхдээ 1/10 гэхээр Улаанбаатар хот 100 тэрбумын боломжтой л байх юм уу. 100 тэрбумаар юу хийх юм. Хаана юм хийх юм. 100 тэрбумаар асуудал шийдэж, газар чөлөөлөөд дуусна. Сургууль, цэцэрлэгийн асуудал, хамран сургах тойрог гэхэд л.../минут дуусав/

С.Одонтуяа: Содномын Чинзориг гишүүн үг хэлье. Дээгээр 3 дэмжсэн, 3 дэмжээгүй үг хэлж болно.

С.Чинзориг: Энэ 7.1.8-ыг бас ажлын хэсэг дээр нэлээн ярьсан.

Засгийн газраас орж ирээгүй санал. Тэгээд ажлын хэсгийн санал болгоод орж ирсэн. Тухайн үедээ би жаахан болгоомжлоод аймаг, нийслэлүүдэд түншилэлээр төсөл хэрэгжүүлэх эрх олгох нь зөв үү, буруу юу. Манай аймгууд ихэнх нь 6 аймгаас бусад нь Улсын төсвөөс татаастай байдаг ийм эрх олгох нь хэр оновчтой юм гэдгийг нэлээн ярьж байгаад ажлын хэсгээс санал нэгдээд энэ санал орж ирсэн.

Нэгдэх асуудал нь энэ 7.1.8-д орж байгаа заалт чинь бол орон нутгуудад шууд түншилэлээр төсөл хэрэгжүүлэх эрхийг нь шууд олгож байгаа асуудал биш. Засгийн газрын бүрэн эрх дотор нь эрх гэсэн хэсэгт нь орж байгаа юм. Өөрөөр хэлбэл тухайн орон нутгуудад түншилэлээр төсөл хэрэгжүүлэх үү, үгүй юу гэдгийг Засгийн газар өөрөө шийдэх юм байна. Тэр эрхийг нь Засгийн газар олгох юм байна гэж ойлгосон. Засгийн газрын бүрэн эрх дотоо орж ирж байгаа юм.

Хоёр дахь нь, төслийн 1/10 ээс хэтрэхгүй гэдэг чинь бол төслийхөө 10 хувиас хэтрэхгүйгээр түншилэлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ гэсэн үг биш л дээ. Тухайн үеийн, тухайн жилд хэрэгжүүлэх аймаг, нийслэлд хэрэгжүүлэх түншилэлийн төсөл нь гэрээний үнийн дүн нь орон нутгийн аймаг, нийслэлийн тухайн жилийн төсвийн 1/10 хүртэлх хувиас хэтрэхгүй байна гэсэн ийм хязгаарлалт хийж өгч байгаа юм. Тэрнээс биш төсвийн 10 хувиар ийм төсөл, түншилэлийн гэрээ, төсөл хэрэгжүүлэх юм байна гэсэн ийм ойлголттой байгаа. Тийм учраас ажлын хэсэг дээр нэлээн ярьж байгаад дэмжсэн. Гол нь шууд төсвийнхөө 10 хүртэл хувиар

түншилэлийн гэрээ хийх эрхийг нь аймаг, орон нутагт шууд олгож байгаа юм биш. Ийм эрхийг Засгийн газар өөрөө олгох юм. Тэгэхээр Засгийн газар ийм эрхийг тухайн орон нутаг, тухай жилд, тухайн аймагт нь олох уу, үгүй юу гэдгийг Засгийн газар өөрөө шийдээд явах юм байна. Тийм учраас хяналттай байх юм байна гэж бодоод ажлын хэсэг дээр нэлээн гишүүд ярьж ойлголтоо нэгтгэж байгаад оруулаад ирсэн төсөл байгаа.

С.Одонтуяа: Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ хуулийн зорилго бол хөгжилд хувийн хэвшлий оролцоог нэмэгдүүлэх том зорилт тавьсан. Тэгэхээр бид нар энэ гэрээний хэлбэрээр юмаа зохицуулаад байгаа юм байна лээ. Тэр 15 дугаар зүйл дээр их тодорхой байгаа. Барьж, ашиглаж, шилжүүлэх үйл явц дээр бол ямарваа нэгэн зүйлтэй хязгаарлуулж барих шаардлагагүй. Тэрийг бол оролцье гэсэн хувийн хэвшлийг нь бүрэн оруулаад дэмжих ёстой. Харин төр тодорхой хөрөнгө гаргах хэсэг дээрээ саяны яриад байгаа хязгаарлалтынхаа асуудлыг ярина уу гэхээс биш тэртээ тэргүй өөрсдөө барьчихаад ашиглаад үр шимээ хүртчихээд дараа нь шилжүүлэх гэж байгаа үйл явц дээр бол ийм зүйл яриад баймааргүй байна. Энийг та хэдийг ялгаач ээ гэж би зориуд хэлмээр байна. Тэгэхээр яг нарийндаа Засгийн газрын бүрэн эрх дээр баймааргүй байгаа юм. Орон нутгийн эрхийг хязгаарлаж байгаа байхгүй юу. Ер нь бол тэр төр, хувийн хэвшлийн түншилэлийн нэгж тодорхой түншилэлийнх нь үйл явцууд дээр үнэлгээ хийж үзээд болох ёстой түншилэлийн чиглэл мөн байна гэдгийг

нь л гаргаад өгчих ёстой. Тэгээд тэр нутгийн өөрөө удирдах байгууллага өөрийнхөө бүрэн эрхийн хэмжээнд шийдвэрээ гаргаж явдаг байх ёстой. Гол зүйл бол үнэлгээний асуудлыг нь хийж өгөх тухай асуудал байгаа. Тэрнээс биш Засгийн газар энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг дэмжиж байна гэсэн тийм чиглэл өгдөг байх юм бол ямар юмны орон нутгийн бүрэн эрхийг хангах юм бэ. Тэгэхээр энэ дээр бол зориуд гүйцээн боловсруулах гэдэг юм уу тийм чиглэл өгч шилжүүлэхгүй бол санал хурааж боломгүй байна. Энэ орон нутгийн эрх мэдэлд дэндүү халдаж байна.

С.Одонтуяа: Мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар, Салдангийн Одонтуяа миний бие бидний урилгаар Баянгол дүүргийн 162, 242 дугаар цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн дарга саналаа хэлээд эсвэл санал хураахгүйгээр гүйцээн боловсруулж болно. Эцсийн хэлэлцүүлэг дээр. Ажлын хэсгийн дарга Цэрэнпунцаг үгээ хэлчих.

Ц.Цэрэнпунцаг: Оруулж ирсэн саналаар уг нь санал хураамаар байгаа юм. Яагаад гэхээр сая зарим дэмжээгүй гишүүд ярьж байна. Яагаад заавал төсөвтэй нь уясан юм гээд. Төсөвтэй уяахаас өөр арга байхгүй. Төсвийн хөрөнгө оруулалт бол төсвийн 30 хувь орчим байгаа юм. Тэгэхээр төсвийн хөрөнгө оруулалт бол 30 хувь дээр төсвийн 30 хувь дээр байгаа юм чинь үүнийн 1/3 гэдэг

баримжаа авч 1/10 гэж оруулсан. Тэрнээс төсвийн орлого гэж ойлгож болохгүй. Төсөвтэй уяж байж төсвийн 30 хувь хөрөнгө оруулалт байдаг гэдэг ийм логик ард нь байгаа юм. Бас зарим гишүүд яриад байна. Хэрэглэгчээс хураамж авдаг нь ашигаа олоод явна биз араас нь төр анхаарах хэрэггүй гэж. Энэ ерөөсөө анх бид нар ажлын хэсгийнхэн тэгж бодож байсан. Энэ бол болохгүй юм шиг байна. Яагаад гэвэл энд төрийн үйлчилгээг хүргэж байгаа, ард иргэд маань энэ үйлчилгээнд нь сэтгэл ханамжгүй байх юм бол янз бүрийн гомдол, санал гаргах юм бол, жишээлбэл, автобусны үйлчилгээ өгдөг, нөгөөх чинь тарифаа нэмээд явчихвал төр хаяж болохгүй шүү дээ. Гэхдээ төр бол хамтыг ажиллагааг хэрэгжиж дуустал заавал оролцож араас нь явж, хувийн хэвшлийнхэн үүргээ гүйцэтгэхгүй бол төр гарцаагүй төсвөөс зарцуулах эрсдэлүүд үүсэх учраас төр заавал орох хэрэгтэй байгаа юм. Тийм учраас энэ орж ирсэн томъёоллоор саналаа хураачихвал дээр байх гэж бодож байна.

С.Одонтуяа: Ажлын хэсгийн болон Байнгын хорооны дарга тодорхой санал хэллээ. Тэгэхээр энэ саналын томъёоллоор Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэдгээр санал хураая. 31.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн саналд оръё. Саяны санал унасан учраас 10 дугаар саналаар санал хураах шаардлагагүй болж байгаа юм байна. Тэгэхээр 7.1.8-тай холбоотой холбогдох журам гэдэг нь саяны санал унасантай холбогдуулж дэмжигдэхгүй юм байна. Гишүүдээ дараагийн санал хураалтад оръё.

11.Төслийн 8.1.1 дэх заалтын “үнэлгээнд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран үнэлгээ өгч,” гэснийг “үнэлгээг” гэж өөрчилж, 8.1.3 дахь заалтын “шинжилгээг” гэсний дараа “хянаж, дүгнэлт гарган” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 8.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 8.1.19, 8.1.20 дахь заалт нэмэх:

“8.1.19.энэ хуулийн 7.2.8-д заасан журмыг боловсруулах.

8.1.20.баримт бичгийн үнэ тогтоох.” Санал гаргасан ажлын хэсэг. Энэ саналтай холбогдуулж Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Энэ бол төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх Эдийн засаг, хөгжлийн яамны бүрэн эрх дээр энэ 2 эрхийг нэмэх гэж байгаа юм. Эхний эрх нь болохоор 7.2.8-д заасан журмыг боловсруулах гэдэг нь нэгдүгээрт санал хураах шаардлагагүй болчихлоо. Яагаад гэхээр сая 9 дэх санал дэмжигдээгүй учраас. Үүний дагуу 10 дахь санал хураалтад байсан энийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам батлах гэдэг санал хураалтыг хийгээгүй. Шаардлагагүй болсон. Одоо журмыг нь боловсруулах гэдэг заалт бас шаардлагагүй болчхож байна гэсэн үг. Санал хураах шаардлагагүй болчхож байгаа юм.

Хоёрдугаарт, энэ баримт бичгийн үнэ тогтоох гэж ямар юм бэ. Энэ яам үнэ тогтоодог гэдгийг би сайн ойлгохгүй байгаа юм.

Жишээлбэл, ямарваа нэгэн үнийг чинь улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар тогтоодог санагдаад байх юм. Ямарваа нэгэн юмыг үнэлж байгаа бол Улсын тэмдэгтийн хураамжийн хуулиар, хоёрдугаарт энэ хуулиар тогтоодог байхгүй юу. Иргэнээс мөнгө авах гээд байна шүү дээ. Бичиг баримтын үнэ гэж. Ийм юмыг хуулиар тогтоодог. Иргэний халааснаас мөнгө авах гэж байгаа учраас. Энэ заалт чинь болохоор Эдийн засгийн хөгжлийн яам үнийг нь тогтооно гээд. Энэ юун үнэ тогтоогоод явдаг болох гэж байгааг би сайн ойлгохгүй байгаа. Жишээлбэл, Улсын бүртгэлийн байгууллага гадаад паспортыг иргэдэд өгч байна шүү дээ. Энэний үнийг Засгийн газрын хурлаар Улсын тэмдэгтийн хураамжийн хуулиар тогтоодог. Тэгж байж 25 мянган төгрөг юм уу, 50 мянган төгрөгөөр гадаад паспортын хураамжийг төлж иргэд авдаг. Тэгэхгүй яам цаашидаа үнэ тогтоогоод явбал энэ бол болохгүй байх. Манай эрх зүйн зарчимд нийцэхгүй байх гэж бодож байна.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ саналыг Байнгын хороонд гүйцээн боловсруулах чиглэл өгөөд Байнгын хороонд өгье. Яагаад гэхээр 7.1.8 дугаар заалт унасантай холбогдуулж, 10 дугаар санал хураагаагүй. Тийм болохоор 12 дээр журмыг боловсруулах гэж үг байхгүй болж байгаа учраас энэ саналыг гүйцээн боловсруулъя. Байнгын хороо руу шилжүүлээ.

Мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням, Болдын Жавхлан, Баагаагийн Баттөмөр нарын урилгаар Дархан-Уул аймгийн Хатан эх зөгийчдийн холбоо төрийн бус байгууллагын

гишүүд болон Говь-сүмбэр аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд нийт Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс ажлын амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Гишүүд ээ, олон сайхан бүсгүйчүүдийг хараад манай гишүүдийн анхаарал сарниад байх шиг байна.

Гишүүд ээ, санал хураалтдаа оръё. Нийт 83 саналаас дөнгөж 13 дээр явж байна шүү.

13.Төслийн 8.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Нийт 55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 9.1.1 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 9.1.5 дахь заалтын “хэрэгжүүлэх” гэсний дараа “төслийн бүрэн шинжилгээнд үндэслэн төсвийн эрсдэл, төсөвт үзүүлэх нөлөөлөл болон хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл өгөх,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 9.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Сандаг-Очир гишүүн санал гаргая.

Ц.Сандаг-Очир: Энэ заалтыг дэмжиж байгаа. Сая санал өгөх гээд хоцорчихлоо. Саяны санал хураалтыг хүчингүй болгож, дахиж санал хурааж өгөөч.

С.Одонтуяа: Сандаг-Очир гишүүний гаргасан горимын саналаар саяны саналыг хүчингүй болгоё гэдгээр санал хураая. Санал хураалт. 59.1 хувийн саналаар Сандаг-Очир гишүүний гаргасан санал дэмжигдэж, саяны санал хүчингүй боллоо.Гишүүд анхааралтай байна шүү.Сайхан зөв явж байгаад дарга орж ирэх үеэр буруу дараад.

Төслийн 9.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.Санал хураалт. 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 17.Төслийн 10.1.4 дэх заалтын “хувийн хэвшилээс” гэсний өмнө “аймаг, нийслэл болон” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Төслийн 11.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

19.Төслийн 15.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 15.1.4 дэх заалт нэмэх:

“15.1.4.барих, түрээслэх, ашиглах, шилжүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 18.2.1 дэх заалтын “энэ хуулийн 19.4, 19.6-д нийцүүлэн гүйцэтгэсэн” гэснийг “боловсруулсан” гэж өөрчилж, 18.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2.7.төслийн үйл ажиллагаанд шаардлагатай, Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдох тусгай болон энгийн зөвшөөрлийг тодорхойлсон байх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Аубакир гишүүн.

Т.Аубакир: Би сая дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Саяны хураасан саналыг хүчингүй болгож, дахин санал хурааж өгнө үү.

Г.Занданшатар: Энийг бусад хууль тогтоомжтой нийцүүлээд редакцын засвар авчихмаар засвар байна. Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлсэн юм байна шүү дээ. Тэгэхээр энийг дахиж хураахгүй, найруулгын засвараар эцсийн хэлэлцүүлэг дээр авчих.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир, Хавдисламын Баделхан, Буланы Бейсен нарын урилгаар Баян-Өлгий аймгийн сумдын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. /салам-алейкум/.

Дараагийн санал хураалт явуулъя.

21.Төслийн 19.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэсний дараа “; аймаг, нийслэл” гэж нэмж, 19.3 дахь хэсгийн “хуульд заасан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ ажлын хэсэг хэн байна. Найруулгын алдаатай байна шүү.

“Хуульд заасан” гэдгийг хасчих юм бол “энэ” гэдэг үг үлдэж байна шүү дээ. Найруулга дээр анхааръя.

22.Төслийн 19.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

23.Төслийн 19.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.4.Энэ хуулийн 19.1-д заасан төслийн саналыг хүлээн авснаас хойш салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншлэлийн төв хамтран урьдчилсан үнэлгээг 30 хоногийн дотор хийж, дүгнэлтийг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн байрандаа суугаарай. Санал хураалт. 22 гишүүн дэмжиж, 51.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Мэндчилгээ дэвшүүлъя. Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлъя. 11 дүгээр сарын 10-нд Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг Шажингийн Мөнхөө, Жадамбын Цээпил нарын айлын 6 дахь хүүхэд болж эхээс мэндэлжээ. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгтээ төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ ард түмний элч болсон танд болон танай сайхан гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Санал хураалтаа үргэлжлүүлъя.

24.Төслийн 20.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.3.Энэ хуулийн 20.2-т заасан төслийн багийн бүрэлдэхүүнд түншилэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншилэлийн төслөөс хамааран холбогдох төрийн байгууллага, төсөл хэрэгжих аймаг, нийслэлийн төлөөлөл байх бөгөөд төслийн багийн бүрэлдэхүүний 30-аас доошгүй хувь нь санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, нийгэм, байгаль орчин болон холбогдох бусад салбарын үндэсний, олон улсын мэргэжлийн судлаач, зөвлөх, хөндлөнгийн хараат бус зөвлөх гишүүн байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Төслийн 20.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.6.Энэ хуулийн 7.2.4, 9.2-т заасан аргачлал болон 20.4-т заасан эрсдэлийн шинжилгээний дүгнэлтийн дагуу түншилэлээр хэрэгжүүлэх төслийн эрсдэлийг үнэлэх, хуваарилах, бууруулах, хянах зэрэг эрсдэлийн удирдлагын арга хэмжээг төлөвлөсөн байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

26.Төслийн 21.3, 21.4 дэх хэсгийн “10” гэснийг “15” гэж, 21.6 дахь хэсгийн “Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ” гэснийг “Засгийн газарт хүргүүлнэ” гэж, 21.7 дахь хэсгийн “шийдвэрийг гаргаж, ТХХТ-ийн төслийг батална” гэснийг “шийдвэрийг гаргана” гэж, 21.8 дахь хэсгийн “хэрэгжүүлнэ” гэснийг “зохион байгуулна” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын

хэсэг. Санал хураалт.57.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Төслийн 21.2.1 болон 21.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.1.энэ хуулийн 21.2-т заасан хяналтын хуудсанд төрийн түншилэгчид хамаарах дараах мэдээллийг тусгана:

21.2.2.энэ хуулийн 21.2-т заасан хяналтын хуудсанд дараах түншилэлийн мэдээллийг тусгана:” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 25.2.6 дахь заалтын “үнэлэх” гэснийг “үнэлэх, шаардлага хангаагүй бол энэ хуулийн 25.2.7-д заасан хугацааны дотор оролцогчид мэдэгдэх;” гэж өөрчлөн, 25.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 25.2.2.д дэд заалт нэмэх:

“25.2.2.д.баримт бичгийн үнэ;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Эрхэм гишүүн Баттөмөрийн Энхбаяр үг хэлнэ.

Б.Энхбаяр: Энэ төслийн 25.2.2.д дэд заалт нэмэх гэж томьёоллоор санал хураах гэж байгаа юм. Төсөл дээр нь болохоор 25.2.2.д гэдэг заалт байгаад байгаа. Тэгэхээр төсөл дээр байгаа “д” гэдэг заалт байна. Тэгэхээр энэ нэмэх биш “д” гэдэг заалтаа өөрчилж байна уу, өөрчилж байгаа бол өөрчлөн найруулах гэж санал хураах ёстой.

Хоёрдугаарт, энэ баримт бичгийн үнэ гээд байгаа нь түрүүн даргыг орж ирэхээс өмнө Одонтуяа

дарга санал хурааж байхад Эдийн засгийн хөгжлийн яам нь өөрөө тэр баримт бичгийн үнийг тогтоогоод байх нь зөв юм уу, Улсын тэмдэгтийн хураамжийн хуулиар тогтоохгүй юу гэдэг зарчим яригдаад тэгээд гүйцээн боловсруулах гэдэг чиглэл ажлын хэсэгт өгөгдсөн. Тэр баримт бичгийн үнэ гэдэг заалт энд орж ирээд байна. Төслийн 25.2.2.д гэдэг заалт байгаад байгаа. Тэгэхээр энэ нэмж байгаа бол биш. Хэрвээ нэмж байгаа бол “е” гэж нэмэх ёстой. Тэгэхээр “д”-г өөрчлөн найруулах гэж санал тавимаар байна. Зөрчил үүсээд байх шиг байна.

Г.Занданшатар: Энэ яагаад ингэсэн юм. 25.2.2.д чинь шаардлагатай бусад баримт бичиг мэдээлэл гэсэн заалт байна шүү дээ. Найруулга дээр хэн ажигласан юм. Найруулга маш муу байна. Эхний хэдэн уншилтаар саналууд их сонин уншигдаж байна. Хэн ажигласан бэ.

Зочид танилцуулъя. Шихихутуг хууль зүйн их сургуулийн эрх зүйн I^б ангийн багш, оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Сурлагын өндөр амжилт хүсье. Сайн хуульч болоорой. Хууль бол дангаараа салбар дундын шинжлэх ухаан болж байгаа учраас бусад шинжлэх ухааныг сайн судлах хэрэгтэй.

Яагаад ийм хариуцлагагүй заалт оруулж байгаа юм. Техникийн алдаа гаргах ёсгүй. Алдаа гаргасан хүнд хариуцлага тооцно шүү. Энэ заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

29.Төслийн “25.6.2.в” дэд заалтыг хасах. Санал гаргасан ажлын

хэсэг. Санал хураалт.56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хуулийн цэг, таслал өөрчлөгдөхөд утга өөрчлөгддөг гэдгийг ер нь, техникийн алдаа гээд сууж байж болохгүй.

30.Төслийн 26.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.2.Ажлын хэсэг энэ хуулийн 25.6.7-д заасны дагуу хамгийн сайн нөхцөлтэй төслийн саналаар шалгарсан оролцогчоос эхлэн хэлэлцээг хийж, үр дүнг нээлттэй мэдээлэх бөгөөд хэлэлцээрийн тэмдэглэлийг энэ хуулийн 52.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Энэ зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Ажлын хэсгийн яг энэ саналыг бол дэмжиж байгаа. Төсөл дээрх өгүүлбэрээс нь юу хасагдсан гэхээр хоёр үг хассан байна. Тэр нь хамгийн сайн нөхцөлтэй төслийн сонгон шалгаруулагчаас, оролцогчоос эхлэн хэлэлцээ хийж, үнэлгээ өгөх гэдгийг үнэлгээ өгөх гэдгийг нь хассан байна. Тэгэхээр энэ чухал заалт байсан уу, үгүй юу. Би бол мэдэхгүй байна. Хэлэлцээ хийгээд л, хийгээд л хамгийн муутай нь ч гэсэн тохирчих юм биш байгаа. Үнэлгээ өгнө гэдэг нь чухал заалт байх байсан юм биш байгаа. Эсвэл шаардлагагүй редакцын засвар байсан юм болов уу. Би сайн мэдэхгүй байна. Тэгээд үнэлгээ өгөх гэдэг нь бол бодвол чухал заалт байлгүй дээ. Үнэлгээгээрээ хэнтэй нь, аль төслийг нь хэрэгжүүлэх вэ гэдгээ шийдэх байх л даа. Эсвэл хэлэлцээж тохирч байгаад шийдчих юм болов уу. Үнэлгээгүйгээр.

Үнэлгээ өгөх гэдэг заалтыг яагаад аваад хаясан юм бол.

Г.Занданшатар: Үнэлж гэж байна. Тийм ээ. 25.6.7. Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг хувийн хэвшилээс ирүүлсэн саналыг үнэлж, хамгийн сайн нөхцөлтэй саналаас эхлэн дараалуулах байдлаар сонгон шалгаруулах гэж заалт байсныг ажлын хэсэг энэ хуулийн 25.6.7-д заасны дагуу хамгийн сайн нөхцөлтэй төслийн саналаар шалгарсан оролцогчоос эхлэн хэлэлцээг хийж, үр дүнг нээлттэй мэдээлэх бөгөөд хэлэлцээрийн тэмдэглэлийг энэ хуулийн 52.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд тусгана. Үнэлгээ өгөхийг нь шууд хэлэлцээ хийж дуусгах болоод байна. Үнэлгээ гэдэг үг нь баймаар л юм шиг байх юм. Үнэлж байж мэдээллийн сандаа тусгана биз дээ. Энэ заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Үнэлгээ өгнө гэдэг заалтыг нэгдсэн санд тусгана гээд сулруулж байна шүү дээ. Тэгэхгүй бол эцэсгүй маргаан болно шүү дээ. Үнэлгээ хийхгүйгээр мэдээллийг нэгдсэн санд тусгана гэхээр, үнэлгээ хийгээд тэрийгээ мэдээллээд тэгээд тэмдэглэгээг нэгдсэн санд тусгана гэж өөрчилмөөр байна. Энд өөрчилж болохгүй учраас гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

31.Төслийн 27.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.7.сонгон шалгаруулалтад оролцогчид нь Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасны дагуу харилцан хамааралгүй байна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Санал хураалт. Саранчимэг гишүүн суугаарай. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 27.1.6-д

Сонгон шалгаруулалтад оролцогч компанийн эцсийн өмчлөгч болон хараат охин компани харилцан хамааралгүй байх, хамтарч оролцохгүй байх гэсэн ижил утгатай заалт байна.

Харилцан хамааралгүй байх, хамтарч оролцохгүй байх гэдэг заалт төсөл дээрээ байна. Тавигдах шаардлага дээр. Эцсийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулж ахиж хянаж үзье. Сая уначихлаа.

32.Төслийн 29.1 дэх хэсгийн “зээлдэгчийн” гэснийг “санхүүжүүлэгчийн” гэж, 29.2 дахь хэсгийн “Монгол Улсын хууль болон түншилэлийн гэрээнд заасан эрх, үүргийн дагуу оролцоно” гэснийг “холбогдох хууль, түншилэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Бямбасүрэнгийн Эн-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Сая миний төхөөрөмж ажилласангүй. Тийм учраас энэ удаагийн санал хураалтыг хүчингүй болгож өгөхийг хүсэж байна.

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Энэ заалт унасан байна. Дараагийнх нь.

33.Төслийн 33.9 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Төслийн 34 дүгээр зүйлийн гарчгийн “төлбөрийн” гэснийг “төсвөөс санхүүжүүлэх” гэж

өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Төслийн 34.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Төслийн 35.2.26 дахь заалтын “байгуулах аливаа” гэснийг “түншилэлийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавхтай холбоотой” гэж, 35.2.35 дахь заалтын “хянах боломжгүй” гэснийг “урьдчилан тооцоолох боломжгүй” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

37.Төслийн 37.1.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Төслийн 41.3.1 дэх заалтын “газрыг” гэсний дараа “холбогдох хуульд заасны дагуу” гэж нэмж, 41 дүгээр зүйлийн гарчгийн “газар чөлөөлөлт” гэснийг болон 41.3.1 дэх заалтын “газар чөлөөлөх” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Зочид танилцуулъя. Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11 11 төвийн ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсэн ерөөе. 11 11-ын мэдээллийн тоймоо ирүүлж байгаарай та нар. 11 11 төвийн ажилтнууддаа баярлалаа. Сайд нар байхгүй. Баатарбилэг гишүүн байсан. 38 дугаар саналыг уншсан. Санал хураалтаа явуулъя. 56.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

39.Төслийн 43.6 дахь хэсгийн “дагуу бий болсон хөрөнгийг” гэснийг “зүйлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

40.Төслийн 44.5 дахь хэсгийн “хувийн хэвилийн түншилэгч” гэсний дараа “энэ хуулийн 44.4-т заасны дагуу” гэж, “үйл ажиллагааны эрх,” гэсний дараа “төсөл хэрэгжүүлэх зорилгоор авсан” гэж, 44.7 дахь хэсгийн “хувийн хэвилийн түншилэгч түншилэлийн” гэсний дараа “үндсэн болон дагалдах” гэж, “зардлын дагуу” гэсний дараа “түншилэлийн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Төслийн 44.1 дэх хэсгийн “санхүүжүүлнэ” гэснийг “санхүүжүүлж болно” гэж өөрчилж, 44.7 дахь хэсгийн “хариуцлагыг баталж” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

42.Төслийн 45.2 дахь хэсгийн “төлбөрийн хэмжээг” гэсний дараа “харилцан тохиролцож,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

43.Төслийн 46.3 дахь хэсгийн “түншилэлийн гэрээг” гэсний өмнө “төрийн түншилэгчээс” гэж, мөн хэсгийн “шилжүүлж” гэсний өмнө “уг нөхцөл байдал арилах хүртэлх хугацаанд” гэж тус тус нэмж, 46.2 дахь хэсгийн “Тайлбарыг” доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Тайлбар: “Санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрх” гэдэгт санхүүжүүлэгч, эсхүл зээлдүүлэгч нь түншлэлийн гэрээний үүргээ зөрчсөн хувийн хэвшлийн түншлэгчийн эрх, үүргийг энэ хуульд заасан шаардлагыг хангасан өөр этгээдэд төрийн түншлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр шилжүүлэхийг ойлгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.64.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

44.Төслийн 46.3 дахь хэсгийн “буруутай үйл ажиллагааг засаж залруулаагүй” гэснийг болон мөн хэсгийн “Тайлбарыг” бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45.Төслийн 50.1.3 дахь заалтын “ажлын төлбөр,” гэсний дараа “төслийн баримт бичгийн үнэ,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

46.Төслийн 52.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

47.Төслийн 56.4 дэх хэсгийн “25.6.8” гэсний өмнө “25.2.6,” гэж, мөн хэсгийн “гомдол” гэсний өмнө “багтаан” гэж тус тус нэмж, төслийн 56.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“56.5.Түншлэлийн төслийн сонгон шалгаруулалттай холбоотой маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хүсэлтээр үндэсний болон олон улсын шинжээчийг оролцуулж, дүгнэлт

гаргуулж болох бөгөөд холбогдох зардлыг оролцогч хариуцна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

48.Төслийн 57.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тогтохсүрэн дарга аа, Чуулганд хүндэтгэх шалтгаангүйгээр ирээгүй, санал хураалтад оролцоогүй гишүүдийн гадаад, дотоод томилолтын захирамж, томилолтыг бичиж өгөхгүй байя. Ирц бүртгэж байгаад. Тэгж тохирлоо шүү. 53.3 Хувийн саналаар санал дэмжигдлээ.

49.Төслийн 60.1 дэх хэсгийн хуулийн дагаж мөрдөх хугацааг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Санал хураалт. 53.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Жигжидийн Батжаргал, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс Та бүхэнд ажлын өндөр амжилт сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Одоо найруулгын саналаар санал хураалт явуулна.

Хоёр. Найруулгын санал

1.Төслийн 3.4 дэх хэсгийн “өмчийн тухай” гэсний дараа “хууль” гэж, 5.1.17 дахь заалтын “төсөл

хөгжүүлэх сан” гэсний өмнө “түнилэлийн” гэж, 5.1.27 дахь заалтын “Компанийн тухай” гэсний дараа “хууль” гэж, 14.1.3 дахь заалтын “заасны” гэсний дараа “дагуу” гэж, 14.4 дэх хэсгийн “зардлыг” гэсний дараа “дангаар” гэж, 17.1.2 дахь заалтын “төсөлд” гэсний өмнө “түнилэлийн” гэж, 17.1.2.б, 17.1.2.г, 17.1.7 дахь заалтуудын “төслийн” гэсний өмнө “түнилэлийн” гэж, 20.1 дэх хэсгийн “үр ашиг” гэсний өмнө “төслийн” гэж, 20.2 дахь хэсгийн “дэргэд” гэсний дараа “хамтран” гэж, 20.10 дахь хэсгийн “зарим” гэсний ард “уялдаатай” гэж, 21.2.2.г заалтын “барилга” гэсний дараа “, байгууламж” гэж, 25.2.2.б заалтын “хувийн хэвшлийн” гэсний дараа “түнилэгчийн” гэж, мөн заалтын “дэмжлэгийн” гэсний дараа “тухай” гэж, 35.2.2б дахь заалтын “төрийн” гэсний дараа “түнилэгчийн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Адышаа гишүүн суудалдаа суу.

2.Төслийн 2.1 дэх хэсгийн “ТХХТ эсхүл” гэснийг хасаж, төслийн зүйл, хэсэг, заалтуудад байх “ТХХТ” гэснийг тохиолдол бүрд нь тохируулан “түнилэл” гэж, 5.1.2б дахь заалтын “бичгүүдийг” гэснийг “бичгийг” гэж, 8.1.2 дахь заалтын “хийгдсэн” гэснийг “хийсэн” гэж, 8.1.7 дахь заалтын “орчинг” гэснийг “орчныг” гэж, 9.2 дахь хэсгийн “хүрээнд төсвийн” гэснийг “төсөвт үзүүлэх” гэж, 12.2.3 дахь заалтын “мэргэжлийн зөвлөхүүдтэй хамтран мэргэжлийн түвшинд төслийн багтай” гэснийг “мэргэжлийн зөвлөх, төслийн багтай” гэж, 12.2.5 дахь заалтын “төслүүдийн” гэснийг “төслийн” гэж, 12.2.6 дахь заалтын

“эксперт” гэснийг “шинжээч” гэж, 13.1 дэх хэсгийн “чиглэлүүдийг” гэснийг “чиглэлийг” гэж, мөн хэсгийн “тогтооно” гэснийг “батална” гэж, 14.1 дэх хэсгийн “ТХХТ-ийг санхүүжүүлэх” гэснийг “Түнилэлийг санхүүжилтийн” гэж, 14.4 дэх хэсгийн “хураамж дангаар” гэснийг “хураамжаар” гэж, 18.1.2 дахь заалтын “бодлогод тусгагдсан” гэснийг “бодлого” гэж, 18.1.3 дахь заалтын “хэлбэрүүдэд” гэснийг “хэлбэрт” гэж, 18.2.12 дахь заалтын “нөхцөлүүдийг” гэснийг “нөхцөлийг” гэж, 18.2.16 дахь заалтын “удирдахад тавигдах” гэснийг “удирдах зорилгоор” гэж, 19.1, 22.1 дэх хэсгийн “тухайн” гэснийг “салбарын” гэж, 19.5 дахь хэсгийн “байгууллагаас” гэснийг “байгууллага” гэж, 21.2 дахь хэсгийн “хүргүүлсэн байна” гэснийг “ хамт хүргүүлнэ” гэж, 21.10, 22.8 дахь хэсгийн “тохиолдолд” гэснийг “бол” гэж, 21.2.2.д заалтын “байгууллагууд” гэснийг “байгууллага” гэж, 22.3 дахь хэсгийн “заасны дагуу” гэснийг “заасан” гэж, 22.4 дэх хэсгийн “үзсэн байна” гэснийг “үзнэ” гэж, 23.1 дэх хэсгийн “хойших 12 сарын ” гэснийг “хойш 12 хүртэлх сарын” гэж, 23.4 дэх хэсгийн “тооцогдохгүй, тухайн төслийн” гэснийг “тооцохгүй бөгөөд” гэж, 24.1 дэх хэсгийн “хэсгийг” гэснийг “хэсэг /цаашид “ажлын хэсэг” гэх/-ийг” гэж, 24.5 дахь хэсгийн “ижил түвшинд” гэснийг “жигд” гэж, 25.2.6 дахь заалтын “хангах” гэснийг “хангаж байгаа” гэж, 25.6.12 дахь заалтын “зааснаар” гэснийг “заасан” гэж, 25.7 дахь хэсгийн “этгээдээс” гэснийг “оролцогчийн” гэж, 26.5 дахь хэсгийн “ТХХТ-ийн” гэснийг “түнилэлийн асуудал эрхэлсэн” гэж, 27 дугаар зүйлийн гарчгийн “шалгаруулалтын” гэснийг

“шалгаруулалтад” гэж, 27.1.2 дахь заалтын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэйгөөр” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу энгийн болон тусгай зөвшөөрөлтэйгөөр” гэж, 28.1.5 дахь заалтын “гэрээний зүйлийн” гэснийг “түншлэлийн зүйлийн” гэж, 28.2.6 дахь заалтын “хугацаанд нь хангах, түүний үнэн зөв, найдвартай байдлыг хангах” гэснийг “хугацаанд нь хангаж, түүний үнэн зөв, найдвартай байдлыг хариуцах” гэж, 30.2 дахь хэсгийн “холбоотой” гэснийг “холбогдсон” гэж, 33.10 дахь хэсгийн “Засгийн газраас” гэснийг “Засгийн газар” гэж, 35.2.22 дахь заалтын “нөхцөлүүд” гэснийг “үндэслэл,” гэж, 35.2.26 дахь заалтын “түүнчлэн хувьцаа эзэмшигчтэйгээ” гэснийг “хувьцаа эзэмшигчтэй” гэж, 35.2.31 дэх заалтын “онцгой тохиолдол” гэснийг “үндэслэл” гэж, 39.3 дахь хэсгийн “байгууллагын дүгнэлтийг” гэснийг “байгууллагаас” гэж, 41.3.6 дахь заалтын “хууль бус, үндэслэлгүйгээр цуцлах, хураан авахыг таслан зогсоох” гэснийг “хууль бусаар хураан авахгүй байх” гэж, 51.8 дахь хэсгийн “сангийн цахим хуудаст” гэснийг “цахим санд” гэж, 52.3 дахь хэсгийн “52.2-т” гэснийг “8.2-т” гэж, 59.3 дахь хэсгийн “хууль зөрчигчид” гэснийг “хууль зөрчсөн этгээдэд” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийг “ТҮНШЛЭЛИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Хойшид Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн яам хуулийн төслийн найруулга, зохиомж, ойлгомжтой байх тал дээр онцгой анхаарах хэрэгтэй. Хүн ойлгохын аргагүй

юмнууд бичдэг. Ийм их найруулгын засвар орж байна. Цахим Dparliament.mn дээр тавиад бөөсийг нь түүлгээд, найруулга дээр анхаарахгүй бол ийм олон санал хураалт явж байна гэдэг бол хууль муу боловсруулсны шинж шүү.

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5.1.25 дахь хэсгийн “урьдчилсан” гэсний дараах “үнэлгээ” гэснийг, 12.2.3 дахь заалтын “байгууллага” гэснийг, 12.2.7 дахь заалтын “үр дүнг” гэсний дараах “тухайн” гэснийг, 20.2 дахь хэсгийн “хамтран” гэснийг, 21.5.3 дахь заалтын “хууль” гэснийг, 22.4 дэх хэсгийн “холбогдох” гэснийг, 22.4.3 дахь заалтын “цор ганц,” гэснийг, 23.1 дэх хэсгийн “зориулан” гэснийг, 23.3 дахь хэсгийн “шаардлагатай” гэснийг, 22.2, 24.1, 51.7 дахь хэсгийн “тухайн” гэснийг, 24.7 дахь хэсгийн “байх” гэснийг, 24.2, 25.6.4, 25.6.7, 25.6.9 дэх заалтуудын “сонгон шалгаруулалтын” гэснийг, 25.6.12 дахь заалтын “ТХХТ-ийн” гэснийг, 27.3 дахь хэсгийн “этгээд” гэснийг, 30.1 дэх хэсгийн “хуваарилах,” гэсний дараах “эрсдэлийг” гэснийг, 30.4 дэх хэсгийн “түншлэгчид,” гэсний дараах “эрсдэлийн” гэснийг, 33.1 дэх хэсгийн “хувийн эрх зүйн салбарын гэрээнд хамаарах” гэснийг, 35.2.7 дахь заалтын “аль” гэснийг, 37.2 дахь хэсгийн “тухайн” гэснийг, 42.2, 50.4 дэх хэсгийн “Монгол Улсын” гэснийг, 43.2 дахь хэсгийн “ТХХТ-ийн гэрээний” гэснийг, 48.3 дахь хэсгийн “нэг бүрчлэн” гэснийг, Гуравдугаар бүлгийн гарчгийн “ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал

хураалт. 52.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон эшлэлийн дугаарыг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын засвар хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гурав. Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

1.Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1/Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл. Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 30 гишүүн дэмжиж 65.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2/Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1/Төслийн 1 дүгээр зүйлийн “6.1.16” гэснийг “16.1.16” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1/Төслийн 1 дүгээр зүйлийн “15.1.16” гэснийг “17/ ” гэж, 2 дугаар зүйлийн “15.1.16” гэснийг “1 дэх хэсгийн 17” гэж, “15.1.17” гэснийг “18/ ” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1/Төслийн 1 дүгээр зүйлийн “33.1.23” гэснийг “33.1.24” гэж, 2 дугаар зүйлийн “33.1.23” гэснийг “33.1.24” гэж, “33.1.24” гэснийг “33.1.25” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1/Төслийн 1 дүгээр зүйлийн “10.29” гэснийг “10.30” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2/Төслийн 1 дүгээр зүйлийн 10.29.2 дахь заалтын “хуульд” гэснийг “хуулийн 28.2-т” гэж өөрчлөн, мөн заалтын “зохих ёсоор” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1/Төслийн 1 дүгээр зүйлийн 14.1-ийн “түншиллээр” гэсний дараах “хэрэгжүүлэх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 46 гишүүн оролцож, 28 гишүүн дэмжиж 60.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1/Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмж, мөн төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“2 дугаар зүйл. Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.12 дахь заалтын дугаарыг “21.1.13” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2/Төслийн 1 дүгээр зүйлийн “21.1.13” гэснийг “21.1.12” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1/Төслийн 2 дугаар зүйлийн 52.6.3-ын “түншиллэлийн” гэсний дараах “тухай” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төр, хувийн хэвшлийн түншиллэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

1/Төслийн 2 дугаар зүйлийн “энэ хуульд зааснаар хүчингүй болгосон, цуцалсан, өөрчилснөөс бусдаар” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2/Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3/Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4/Төслийн 6 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5/Төслийн 8 дугаар зүйлийн “мөн адил энэ хуулийн дагуу” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6/Төслийн 10 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7/Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх.

“7 дугаар зүйл. Энэ хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө Концессын тухай хуулийн дагуу байгуулсан концессын гэрээнүүдэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран үнэлгээ хийж, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, цуцлах концессын гэрээнүүдийг Засгийн газар холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийн урилгаар Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Төв лабораторийн албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

8/Төслийн 12 дугаар зүйлийн “хүчин төгөлдөр болсноос” гэснийг “батлагдсанаас” гэж, “батлах ба тэдгээрийг батлагдах хүртэлх хугацаанд тухайн харилцааг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журам, аргачлал, холбогдох бусад баримт бичгээр зохицуулна.” гэснийг “батална.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

10.Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1/Төслийн 1 дүгээр зүйлийг “Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9, 6.5.10 дахь заалтын “концессын гэрээ” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ” гэж, мөн зүйлийн 6.2.4, 6.5.8 дахь заалтын “концессын зүйлийн жагсаалт” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалт” гэж, мөн зүйлийн 6.5.10 дахь заалтын “концесс эзэмшигч” гэснийг “хувийн хэвшлийн түншлэгч гэж, “ концессын зүйл” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн зүйл” гэж тус тус өөрчилсүгэй.” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Концессын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:

1/Төслийн 1 дүгээр зүйлийн “18” гэснийг “28” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар” гэснийг хасаж, мөн зүйлийн “төсөл санаачлах,” гэсний дараа “Засгийн газар эрх олгосны дагуу түншлэлийг хэрэгжүүлэх,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийн ахлагч Цэдэндамбын Цэрэнпунцаг саналаа татаж авч байвал санал хураалгахгүй. Микрофонд хэл.

Ц.Цэрэнпунцаг: 9 дүгээр санал дэмжигдээгүйтэй холбоотойгоор энэ саналыг санал хураах шаардлагагүй учраас татаж авч байна.

Г.Занданшатар: Саналаа татаж авсан учраас ажлын хэсгийн ахлагч, Байнгын хорооны дарга саналаа татаж авсан учраас татаж авсанд тооцлоо.

13. “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай ” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1/Төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг 2023 оны 3 дугаар улиралд багтаан хэрэгжүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2/Төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.60.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3/Төслийн 3 дахь заалтыг төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалт болгож, “хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Эдийн засаг, хөгжлийн яам /Ч.Хүрэлбаатар/-нд тус тус үүрэг болгосугай” гэснийг “хэрэгжүүлэх” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр саналаа тайлбарлаж үг хэлнэ.

Б.Энхбаяр: Эрхэм гишүүд ээ, Энэ Байнгын хороо бол дэмжээгүй биш байгаа юм. Энэ гишүүд гарч яваад ирц дутаад ирцэд байхгүй байгаа гишүүд татгалзсанаар гараад унасан юм.Тэрнээс биш миний саналыг уг нь толгой дохиод бүгд дэмжээд байх шиг байсан. Энэ ямар санал вэ гэхээр энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дагалдуулж тендерийн хуулийн өөрчлөлтийг оруулж ирсэн байгаа юм. Энэ тендерийн хууль нь ямар хуулийн өөрчлөлт байна вэ гэсэн чинь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуульд заасан төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт болон тус хуульд

заасан бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй гэж байгаа юм. Энэ юу гэсэн үг вэ гэхээр ер нь бол төр, хувийн хэвшлийн түншилэл буюу концессын хууль дээр тендерийн хууль үйлчлэхгүй гэдэг ийм хууль оруулж ирсэн. Энэ зарчмыг би болохгүй гэж үзэж байгаа юм. Яагаад болохгүй вэ гэхээр би 2 баримт хэлье. 2016 онд Хөгжлийн банкны асуудлыг шалгаж, ажлын хэсэг ахалж, дүгнэлт гаргаж байхад анхаарал татсан нэг зүйл нь Хөгжлийн банкны тухай хуульд Ардчилсан нам эрх барьж байхдаа авангуутаа ганцхан өгүүлбэр оруулсан байдаг юм билээ. Тэр нь Хөгжлийн банкны дотоод үйл ажиллагаанд тендерийн хууль үйлчлэхгүй гэдэг заалт оруулсан. Ингээд хулгайгаа эхлүүлсэн байдаг. Шалгаад үзэхэд яахаараа Хөгжлийн банк энэ зах зээлийн үнээс хэд дахин өндөр үнэтэй, 20 тэрбумын өртгөөр ийм байр авсан юм бол гэхээр манай хуульд тендерийн хууль үйлчлэхгүй. Ийм заалт орсон юм. Яахаараа та нар чинь ийм өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүн аваад байдаг юм бэ. Манай банкны үйл ажиллагаанд тендерийн хууль үйлчлэхгүй гэдэг хууль орсон. Хэзээ оруулсан юм. 2013 оны эхээр оруулсан байсан. Ганцхан өгүүлбэр. Энэ бол хуулийн хулгай шүү. Тэгэхээр хуулийн ид шид гэдэг бол ийм хүчтэй байдаг. Одоо бид нар аймар гоё концесийн хууль бол жинхэнэ хулгайг арилгаж байгаа гэххэд яг төгсгөл дээр нь концесийн үйл ажиллагаанд тендерийн хууль үйлчлэхгүй ээ. Ерөөсөө ингэх гэж байгаа байхгүй юу. Тийм учраас надад энэ бол таалагдахгүй байгаа.

Хоёр дахь жишээ нь, бид нар нэг төмөр зам бариад байгаа шүү дээ. Тэгсэн чинь Голомт чинь одоо хүртэл

төмөр замын гэрээ нууц байгаа тийм ээ. Энэ бусад төмөр замаасаа 3, 4 дахин өртөгтэй барьсан гээд байгаа шүү. Нөгөө концесс чинь. Яадаг вэ гэхээр тендерийн хууль байхгүй, гэрээ нууц. Энэ дээр хулгай хийгээд байгаа байхгүй юу. Том хулгай чинь. Хэдэн сая доллароор. 1 км дээр хэдэн сая доллароор илүү өндөр өртөгтэй барьж байгаа байхгүй юу. Яагаад гэхээр тендерийн хууль үйлчлэхгүй. Нээлттэй биш. Тийм учраас би энэ тендерийн хууль үйлчлэхгүй гэж байгаа энэ хуулийг буцаах нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Тийм учраас Та бүхэн маань кноподоо хүрэхгүйгээр Байнгын хорооны дэмжээгүйг дэмжихгүйгээр байж энийг буцааж өгөөч гэж хүсэх гэж байгаа юм. Хэрвээ энэ тендерийн хууль үйлчлэхгүй гэдэг заалт орж ирэх юм бол энийг бол дахиад ярина гэж бодож байгаа юм. Энэ бол нэлээн ноцтой асуудал байгаа.

Г.Занданшатар: Санал хураалт. Тайлбар гэж байхгүй. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ. Өөрсдөө үгээ хэлэхгүй байсаар байгаад өнгөрөөлөө. Үнэн л юм байлгүй гэж гишүүд бодлоо. Баттөмөрийн Энхбаяр гишүүний гаргасан санал дэмжигдэж, Байнгын хорооны дэмжээгүй санал уналаа. Энийг эцсийн хэлэлцүүлэг дээр Байнгын хорооны хурал дээрээ ярьцгаа.

2. Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Санал

хураалт явуулах уу. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Энэ төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийг дагалдуулж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл орж ирсэн байгаа юм. Энэ ямар хуулийн өгүүлбэр орж ирсэн бэ гэхээр би уншаад өгье. Төрийн өмчийн газар, түүний хэвлий, төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг Төр, хувийн хэвшлийн түншилэлийн гэрээнд заасныг үндэслэн эзэмшүүлэх, ашиглуулах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулахтай холбогдсон харилцааг Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд зааснаар зохицуулна гэдэг ийм өөрчлөлт орж ирсэн.

Би энэ өөрчлөлтийг дэмжихгүй, буцаах нь зүйтэй гэж үзэж байгаа. Яагаад. Бид нар үдээс өмнө газрын багц хуулийг хэлэлцэх эсэхийг ярьж байгаа. Төрийн өмчийн газрын харилцааг бол газрын хуулиар зохицуулах ёстой. Энэ орж ирж байгаа өөрчлөлт юу орж ирж байна гэхээр төрийн өмчийн газар, газрын хэвлий энэ чинь байгалийн баялаг ороод ирж байна шүү дээ. Ингээд энийг концессын үндсэнд гэрээгээр эзэмшүүлэх асуудал яригдах юм бол энэ хуулиар зохицуулна гэдэг ийм заалт орж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар газар болон газрын хэвлий, төрийн болон орон нутгийн өмчтэй холбоотой суурь харилцаануудыг дандаа эцэг хуулиар нь зохицуулах ёстой. Суурь харилцааг зохицуулсан хуулиар нь зохицуулах ёстой. Газрын хуулиар байна уу, Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны суурь хуулиар, газрын

хэвлийн хуулиар байна уу эсвэл ашигт малтмалын хуулиар байна уу тэр хуулиар зохицуулах ёстой байхгүй юу. Энэ хууль илүү хүчин төгөлдөр үйлчилж болохгүй. Яагаад. Жишээлбэл ийм асуудал үүснэ. Би төмөр зам дээр жишээ болгоё. Манай улс Үндсэн хуульд зааснаараа газрыг гадаадын иргэн, хуулийн этгээдэд төлбөртэй, хугацаатай ашиглуулна гэдэг заалттай. Монгол улсын Үндсэн хуульд нийцээгүй олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй гэдэг заалттай. Гэтэл манай улсын газрыг төлбөргүйгээр гэрээгээр гадаад улсын оролцоотой хуулийн этгээд ашиглаж байна. Үндсэн хуультай нийцэхгүй явж байна шүү дээ. Тэгэхээр бид нар гэрээнд тэгээд заачихсан учраас гээд Үндсэн хуулиа нулиад байж болохгүй. Ялангуяа төр, хувийн хэвшлийн түншилэлийн харилцаатай холбоотой асуудал дээр. Газрын асуудал ярьж байгаа байхгүй юу. Газрын хэвлийг ярьж байна. Тийм учраас бид энэ асуудал дээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Засгийн газар хэлэлцсэн. Гурван 7 хоногийн өмнө. Шинэчилсэн найруулга. Тун удахгүй Улсын Их Хуралд орж ирж хэлэлцэх эсэх асуудал нь яригдах байх. Газрын багц хууль нь өмчийнх нь багц хуулиуд нь дандаа сууриараа шинэчилсэн найруулга хэлбэрээр концепцийн хувьд өөрчлөгдөөд орж ирж байгаа учраас одоо энэ асуудлыг шууд буцаая. Энэтэй холбоотой харилцааг нэгэнт одоо Улсын Их Хурал хэлэлцэж байгаа, шинэчилсэн найруулга хэлбэрээр нь ярьж байгаа, тэр хуулиудаар нь нарийвчилж зохицуулъя гэдэг ийм зарчмын байр суурь баримталж байгаа учраас би буцаах саналыг гаргаж байгаа. Тийм учраас дэмжихгүй байж, буцааж өгөөч гэж хүсэх гэж байгаа юм.

Г.Занданишатар: Санал гаргасан гишүүн саналаа тайлбарлаж үг хэлж болно гэсэн дэгийн тухай хууль байгаа. Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Болдын Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Энэ ийм юм байгаа шүү гишүүд ээ, Төрийн худалдан авах ажиллагааны хууль бол төсвөөс мөнгө гараад сургууль, цэцэрлэгийн байшин, барилгыг барихад хөрөнгө оруулалт хийхэд тэр хуулиар зохицуулна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр төсвөөс нэг ч төгрөг гарахгүй. Хувийн хэвшил өөрөө цэцэрлэг, сургуулиа бариад тэр барьсан барилгаараа төртэй түншлэх гэж байгаа хэлбэр. Олон улсын зарчим ч энүүгээр явдаг. Одоо байгаа концессын тухай хууль ч гэсэн худалдан авах ажиллагааны газраар явдаггүй шүү дээ. Тэр хуультай ерөөсөө хамаагүй, дангаараа хэрэгждэг. Концессын тухай хууль өнөөдрийг хүртэл. Яг тэр зарчмаараа л явах гэж байгаа тийм л асуудал. Төсвөөс нэг ч төгрөг гаргаж байшин барилга барихгүй, замыг барихгүй, хувийн хэвшлийнхэн өөрсдөө барьж гүйцэтгээд мөнгөө олж ирээд, хөрөнгө оруулагчаа олж ирээд хийх гэж байгаа юмыг төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль өөрөөр хэлбэл төсвөөс мөнгө гарч худалдан авалт хийж байгаа, хөрөнгө оруулалт хийж байгаа тэрийг зохицуулдаг хуулиар зохицуулна гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ дээр нөгөө барих, шилжүүлэх гэдэг тийм харилцаа байхгүй энэ хууль дээр. Тийм учраас энэ хуулийг өөрийнх нь энэ хуулиар нь зохицуулж, олон улсын зарчмаар нь явуулж өгөөч эрхэм гишүүд ээ.

Г.Занданишатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн. Газар, газрын

хэвлий орчихоороо Үндсэн хуулийн шахуу зөрчилтэй болоод байна.

Ц.Цэрэнпунцаг: Энэ Байнгын хорооны дэмжээгүй саналыг гишүүд ээ, Та бүхэн дэмжиж өгөх хэрэгтэй юм байгаа юм. Энэ нарийн ойлголт хэрэгтэй байх. Ер нь газрын хэвлийг ашиглах эрхийг энүүгээр олгож байгаа юм шиг яриад байгаа юм. Энэ хууль үйлчлэх хүрээ чинь ашигт малтмал орохгүй, банк санхүү гээд 3 салбарт энэ хууль үйлчлэхгүй шүү дээ. Дээрээс нь энэ төрийн өмчийн газар, түүний хэвлийг эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг холбогдох хуулиар нь зохицуулахаар энэ хуульд тусгасан байгаа. Тэгэхээр хольж, хутгаж болохгүй. Тэгэхээр энэ хуулийг энэ дэмжээгүй саналыг цөмөөрөө дэмжээд явъя гэж байгаа юм. Холбогдох хуулиар явна гэж байгаа.

Г.Занданишатар: Санал хураалт явуулъя. Төрийн өмчийн газар, түүний хэвлий бусад юмтай холбоотой холбогдсон харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд зааснаар зохицуулна гэж байгаа юм. Хоёуланд нь хавсарсан тодорхойгүй нөхцөл байдал үүсгэж байна. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Түрүүчийнхийг, санал хураасан юм дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөхгүй дэгээрээ. Энэ заалт дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Байж байгаарай. Сүүлийн санал хураалт. Энд нэг санал орхисон байгаа. Уучлаарай гишүүд ээ сууж байгаарай. Нямаагийн Энхболд гишүүн, Мөнх-Оргил гишүүн сууж байгаарай. Найруулгын санал хураагдана. Дагаж орж ирсэн хуулиудын найруулгын санал.

**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн
тухай хуулийн төсөлтэй хамт
өргөн мэдүүлсэн хуулийн
төслүүдийн талаарх найруулгын
санал**

1/Холбогдох хуулийн төслүүдийн “санал хүргүүлэх” гэснийг “санал гаргах” гэж тохиолдол бүрд өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Саяны заалт 2 тодорхойгүй харилцаа үүсгэж байгаа учраас аль хуулиар нь зохицуулахыг гүйцээн боловсруулж болно.

Тэр тендерийн хууль бол энэ хууль үйлчлэхгүй гэж байгаа учраас гүйцээн боловсруулах аргагүй юм байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, дараагийн асуудалд орно. Газрын багц хуулиудыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Үг, үсэг найруулгаа сайн анхаараарай. Том хууль нарийн харахгүй бол болохгүй юм байна. Ажлын хэсэг сайн ажилласан байна. Эцсийн хэлэлцүүлэгт Эдийн засгийн байнгын хороо онцгой анхаарч ажиллахыг чиглэл болгоё. 17.27 цагт.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Маргааш өглөө 10 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ. Газрын тухай хуулиуд бусад хуулиудаа хэлэлцэнэ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ
Э.СУВД-ЭРДЭНЭ